/Гадаад хүмүүс/								
EZ SAVER	295,000 □	147,500 □			590,000 □	295,000 □		
EZ NET	248,800 □	124,400 □			497,600 □	248,800 □		
EZ PAY	196,500 □	98,250 □			393,000 □	196,500 □		

Чойбалсан=COQ (909/910)

Үнийн төрлүүд	Замын 1 талын тийзний үнэ				Замын 2 талын тийзний үнэ			
	Том хүн	Хүүхэд*	Нялх хүүхэд* *	Ахмад настан***	Том хүн	Хүүхэд	Нялх хүүхэд	Ахмад настан
EZ FLEX /Гадаад хүмүүс/	271,300 □	135,650 □	16,870 □	126,525 □	542,600 □	271,300 □	33,740 □	253,050 □
EZ RIDER /Гадаад хүмүүс/	243,300 □	121,650 □			486,600 □	243,300 □		

EZ SAVER	230,300□	115,150□			460,600□	230,300□		
EZ NET	195,000□	97,500□			390,000□	195,000□		
EZ PAY	168,700□	84,350□			337,400□	168,700□		

Үнийн төрлүүд	Ачаа, тээш
EZ Flex	25kg (20 kg + 5 kg гар цүнх)
EZ Rider	20kg (15 kg +5 kg гар цүнх)
EZ Saver	25kg (20 kg + 5 kg гар цүнх)
EZ Net	20kg (15 kg 5 kg гар цүнх)
EZ Pay	15kg (10 kg + 5 kg гар цүнх)
EZ Хүүхэд	EZ Хүүхдийн ачаа, тээш том хүнийхтэй ижил хэмжээтэй

Тээшний үнэ:

11	Овоот	OVT	987/988	3400□	3200□
12	Хайлаар	HLD	9271/9272	4300□	3000□
13	Ховд-Булган сум	HVD-BSM	993/994	2800□	2600□
8	Хархорин	KHR	957/958	2800□	2600□
9	Улаангом	ULO	921/922	3700□	3500□
10	Өлзий даланзадгад	ULG	923/924 925/926	4100□ 3000□	3900□ 2600□

2. Галт тэрэгний хуваарь, үнийн тариф

Өртөө	Үнэ			
	Тасалгаат	Унталгын	Нийтийн	Хүүхэд
Толгойт	500	500	500	300
Эмээлт	1200	1200	1100	300
Давааны	3400	2700	1200	500
361	4100	300	1200	500
Рашаант	4100	300	1200	500
347	4500	3200	1500	600
Партизан	4500	3200	1500	600

Чиглэл	Цаг	Өдөр	Үнэ			
			Тасалгаат	Унталгын	Нийтийн	Хүүхэд
УБ-Сүхбаатар	10:40	өдөр бүр	18900	11800	5300	1800
УБ-Сүхбаатар	21:20	өдөр бүр	18900	11800	5300	1800
УБ-Чойр	17:40	5 дахь	14900	9700	4800	1200
УБ-Дархан\Энгийн \	15:50	өдөр бүр	15300	10000	5000	1100
УБ-Зүүнхараа	17:30	өдөр бүр	10800	7400	5800	1100
УБ-Эрдэнэт	20:20	өдөр бүр	20300	12300	6830	2000
УБ-Дархан\хурдан\		өдөр бүр	39700			25200

335	500	3400	1500	600
324	5400	3900	2000	600
Мандал	5900	4100	2100	800
Хужирт	6200	4200	2300	800
Баянбуурал	8400	5800	2600	800
Шатанга	8400	5800	2600	800
290	8400	8500	2600	800
284	8400	5800	2600	800
Түнх	9800	6200	2900	800
264	9800	6200	2900	800
Үнэгт	10400	6700	3300	800
246	10400	6700	3300	800
241	10400	6700	3300	800
Бэрх	12000	7700	4100	1100
Баруунхараа	13800	8800	4200	1200
Номгон	14000	9300	4500	1200
Эрхэт	14000	9300	4500	1400
Салхит	14900	9700	4800	1400
Цайдам	14900	9700	4800	1400
Шарын гол	17400	11100	5700	1500
Хөтөл	15000	10000	5000	1400
Бэлэндалай	15800	10200	5100	1400
Орхонтуул	17400	11000	5700	1500
Хангал	18900	11800	6300	1800
Улаан толгой	19400	17100	6600	2000
Орхон	17400	11100	5700	1500
Ерөө	17400	11100	5700	1500
Дулаан	18300	11400	6000	1800
Шаамар	18400	11800	5300	1800
Энх тал	17000	10400	5600	1500

3. Авто тээврийн хуваарь, үнийн тариф

Улаанбаатар- Төв аймаг

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Зуун мод	Өдөр бүр 07:30-20:30			
Жаргалант	1,4,6,	08:00	1,4,6,	17:00
Заамар	1,3,5,	08:00	1,3,5,	19:00
Шижир алт	1,3,4,5,6,7,	14:00	1,3,4,5,6,7,	12:00
Цээл	2,4,6,	08:00	2,4,6,	17:00
Сүмбэр	1,3,6,	08:00	1,3,6,	14:00
Өндөрширээт	1,3,6,	08:00	1,3,6,	18:00
Угтаал цайдам	2,4,6,	08:00	2,4,6,	17:00
Баян жаргалан	1,4,	08:00	1,4,	19:00
Алтанбулаг	3,5,	12:00	3,5,	10:00
	6,7,	10:00 13:00	6,7,	09:00 12:00

Тариф

Чиглэл	Дамжин онгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			автобус		микро	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Зуун мод	Зуун мод сум	43			1800	1000
Жаргалант	Жаргалант сум	135			5500	3000
Заамар	Заамар сум	170			6700	4000
Шижир алт	Шижир алт сум	260			11500	6900
Цээл	Цээл сум	177			7500	4500
Сүмбэр	Сүмбэр сум	160			6000	3600
Өндөрширээт	Өндөрширээт сум	188			8400	4910
Угтаал цайдам	Угтаал цайдам сум	152			7000	4200
Баян жаргалан	Баян жаргалан сум	168	7200	4800		
Алтанбулаг	Алтанбулаг сум	52	1500	750		

Улаанбаатар- Баян-Өлгий

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Баян-Өлгий	Өдөр бүр 08:00-20:00		Өдөр бүр 16:00	

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф	
			Автобус дунд оврийн	
Баян -Өлгий	Өлгий сум	1709	73900	44100

Улаанбаатар- Говь-Алтай

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Говь-Алтай автобус	3,5,7,	13:00	1,4,6,	14:00
фургон	Өдөр бүр	14:00	Өдөр бүр	22:00

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		фургон	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Говь-Алтай	Дэлгэр сум	92	42500	25500	38000	22800
	Говь-Алтай	1047	46500	27000	42000	25200

Улаанбаатар- Увс

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Увс	3,5,7,	15:00	1,3,5,	09:00

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн			
			хүн	хүүхэд		
Увс	Завханы нөмрөг	947	35000		21000	
	Завханы сонгинт	1035	38000		22800	
	Увсын улиастай	1427	51000		30600	

	Увсын Наранбулаг	1297	48000	28800
--	---------------------	------	-------	-------

Улаанбаатар-Эрдэнэт

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Эрдэнэт	Өдөр бүр	10,12,14,15,16	Өдөр бүр	16:30 18:30 20:30 21:30 22:30

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		фургон	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Эрдэнэт	Сэлэнгэ Сайхан	249	11600	6600		
	Сэлэнгэ		11000	6600		
	Баруун бүрэн		12200	7320		
	Эрдэнэт Баян- өндөр	371	13500	8100		

Улаанбаатар-Булган

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Булган	1,2,3,4,5,	11:00	1,2,3,4,5,	18:00
Булган-Гурван булаг	1,3,5,	08:00	2,4,6,	17:00
Булган-Рашаант	2,4,6,	09:00	3,5,7,	16:00

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		фургон	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Булган	Орхон	296	15500	8640		
	Булган	318	14400	8640		
	Гурван булаг	276			9500	5700
	Дашчилан	229			8000	4800
	Баяннуур	199			7000	4200

Булган-Рашаант	11000	6600
----------------	-------	------

Улаанбаатар- Дархан

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Дархан автобус	Өдөр бүр	10,11,12,14,15,16,18,19	Өдөр бүр	12:30 14:30 15:30 17:30 18:30 19:30 20:30 22:30
Дархан микро	Өдөр бүр	12,14,18,20	Өдөр бүр	12;14;18;20

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		микро	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Дархан	Дархан	219	8000	5100	8500	5100
	Шарын гол	238			8500	5100

Улаанбаатар- Баян хонгор

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Баян хонгор автобус	1,3,4,5,6,7,	08:00	1,3,4,5,6,7,	22:00
Баянхонгор фургон	Өдөр бүр	12:00	Өдөр бүр	06:00

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		микро	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Баян хонгор	Өлзийт	613	27000	16200	23000	13800
	Баян хонгор	630	28000	16800	13500	14100

Улаанбаатар- Архангай

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Эрдэнэ Булган	Өдөр бүр	08:00	Өдөр бүр	20:00
Эрдэнэ Булган	2,6,	09:00	3,7,	19:00
Хашаат	1,5,	09:00	1,5,	23:00
Эрдэнэ мандал	1,4,	08:00	3,6,	03:00
Цэцэрлэг	4,	08:00	6,	03:00

Тариф

Чиглэл	Дамжсин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		микро	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Архангай	Хотонт	394	17000	8400		
	Цэнхэр	464	19000	11400		
	Эрдэнэ булган	493	20000	12000		
Хашаат	Хашаат	328		9600	14000	8400
Эрдэнэ мандал	Өлзийт	375	16000	11700		
	Хайрхан	460	19500	13200		
	Эрдэнэ мандал	510	22000	9600		
Цэцэрлэг	Өлзийт	375	16000	11700		
	Хайрхан	460	19500	13200		
	Эрдэнэ мандал	510	22000	9600		
	Цэцэрлэг	570	24000	14400		

Улаанбаатар- Хөвсгөл

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Хөвсгөл	Өдөр бүр	15:00	Өдөр бүр	09:00

Тариф

Чиглэл	Дамжсин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		фургон	
			хүн	хүүхэд	хүн	хүүхэд
Хөвсгөл	Мөрөн сум	671	24500	14700		

Улаанбаатар- Ховд

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь
--------	-----------------------------

	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Ховд	1,3,5,	13:00	1,3,7,	10:00

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		хүн	хүүхэд
			хүн	хүүхэд		
Ховд	Ховд сум	1487	55000	33000		
	Дарви	1274	47000	28200		
	Зэрэг	1341	30000	30000		

Улаанбаатар-Завхан

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Завхан	1,3,5,	12:00	2,4,6,	17:00

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		хүн	хүүхэд
			хүн	хүүхэд		
Завхан	Улиастай	1023	37500	22500		
	Тэлмэн	899	33000	19800		
	Тосонцэнгэл	838	31000	18600		
	Их уул	795	20000	17400		

Улаанбаатар-Дундговь

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Сайнцагаан	Өдөр бүр	08:00	Өдөр бүр	15:00
Адаацаг	1,4,	08:00	2,5,	17:00
Эрдэнэдалай	2,5,	08:00	3,6,	17:00

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		хүн	хүүхэд
			хүн	хүүхэд		

Дундговь	Дэлгэрцогт	216	10000	6000	
	Сайнцагаан	260	12000	7200	
	Адаацаг	213	9500	5700	
	Эрдэнэдалай	275	11800	11800	

Улаанбаатар-Өвөрхангай

Чиглэл	Үйлчилгээний цагийн хуваарь			
	УБ-с хөдлөх		УБ-т ирэх	
	гараг	цаг	гараг	цаг
Өвөрхангай	1,2,3,4,5,6,	08:00, 14:00	Өдөр бүр	15:00
Арвайхээр			2,5,	17:00
Батөлзий	1,3,5,	08:00	3,6,	17:00
Хужирт	1,3,5,	08:00		
Баян-Өндөр	1,5,	08:00		
Хархорин	Өдөр бүр	09:00 13:00		
Есөнзүйл	1,5,	08:00		
Бүрд	1,5,	08:00		

Тариф

Чиглэл	Дамжин өнгөрөх буудал	Зай	Зорчигчийн тариф			
			Автобус дунд оврийн		хүн	хүүхэд
			хүн	хүүхэд		
Өвөрхангай	Өвөрхангай					
	Арвайхээр	431	16000	9600		
	Батөлзий	400	16500	9900		
	Хужирт	454	18600	11600		
	Баян-Өндөр	331	12200	7300		
	Хархорин	365			16000	9600
	Есөнзүйл	360			12000	7200
	Бүрд	344			13000	7800

3.3.1 ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ ӨНДӨРТЭЙ БҮС НУТАГ

2009 оны гэмт хэргийн байдал:

Цагдаагийн байгууллага 2009 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 79515 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оныхоос 1415 нэгжээр буюу 1.7 хувиар буурч, 4 гомдол, мэдээлэл тутмын нэгд эрүүгийн хэрэг үүсгэж шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд энэ онд 20373 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 331 хэргээр буюу 1,6 хувиар буурчээ.

Бүх гэмт хэргийн 55.6 хувь нь Нийслэл хотод, бүртгэгдэж, өмнөх оныхоос 2.9 хувиар өсч,

- 43.3 хувь нь аймгуудад,
- 0.6 хувь нь Төмөр замын салбарт,
- 0.1 хувь нь Иргэний агаарын тээврийн салбарт,
- 0.4 хувь нь бусад газарт бүртгэгдсэн нь өмнөх оны түвшинд байна.

Гэмт хэргийн гаралт

- Нийслэлд 4.0
- Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багахангай дүүрэгт 9.4 хувиас 7.6 дахин их
- Иргэний агаарын тээврийн салбарт 26.7
- Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Завхан, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, аймагт 0.7-11.8 хувиар тус тус өсөв.

Харин Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Увс, Ховд, Хэнтий аймагт 5.0-30.5%, Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Багануур, Налайх дүүрэгт 2.8-13.3%, төмөр замын салбарт 38.7% тус тус буурав.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн:

- 38.6% хөнгөн
- 49.1% хүндэвтэр,
- 10.4% хүнд
- 1.9%-ийг онц хүнд ангиллын гэмт хэрэг тус тус эзэлж байгаа ба хөнгөн ангиллын гэмт хэрэг өмнөх оны түвшинд, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 1.6, хүнд ангиллын гэмт хэрэг 9.6 хувиар тус тус буурч, онц хүнд ангиллын гэмт хэрэг 15.3 хувиар өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт:

№	Нутаг дэвсгэр	Хувь
1	Сүхбаатар	95.0
2	Баян Өлгий	84.6
3	Дундговь	72.7
4	Дархан-уул	69.5
5	Булган	66.7
6	Өмнөговь	72.7
7	Завхан	69.5

8	Баянхонгор	66.7
9	Увс	65.4
10	Сэлэнгэ	65.3
11	Төв	64.6
12	Архангай	63.4
13	Ховд	61.4
14	Хөвсгөл	60.9
15	Дорноговь	57.1
16	Орхон	55.8
17	Говь-сүмбэр	53.3
18	Дорнод	52.6
19	Өвөрхангай	52.1
20	Хэнтий	50.4
21	Говь Алтай	50.0
22	Налайх дүүрэг	61.2
23	Сүхбаатар дүүрэг	56.6
24	Багануур дүүрэг	53.2
25	Баянзүрх дүүрэг	52.7
26	Чингэлтэй дүүрэг	52.7
27	Баянгол дүүрэг	51.3
28	Хан-уул дүүрэг	50.9
29	Сонгино хайрхан дүүрэг	40.7

2010 оны эхний хоёр сарын гэмт хэргийн байдал:

Цагдаагийн байгууллага 2010 оны эхний 2 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 9140 гомдол, мэдээлэл хүлээн авсаны 5907 нь гэмт хэргийн талаархи гомдол мэдээлэл байна.

Улсын хэмжээнд энэ оны эхний хоёр сард 3175 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 191 хэргээр буюу 5.7 хувиар буурчээ.

Бүх гэмт хэргийн 51.6% нь Нийслэл хотод бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 3,3% буурч

- 42.0% нь Аймгуудад
- 0.9% нь Төмөр замын салбарт
- 0.3% нь Улсын Мөрдөн Байцаах Газарт
- 0.3% нь Хэрэг Бүртгэх Газарт
- 3.0% нь Замын Цагдаагийн Газарт
- 0.8% нь Халаасны Хулгайн Гэмт Хэрэгтэй Тэмцэх Тасагт
- 0,1% нь Авлигатай Тэмцэх Газар
- 0.3% нь УЕП-ын Мөрдөн байцаах албанд
- 0.7% нь ТЕГазарт бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн гаралт Нийслэлд 11.4, Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, дүүрэгт 5.8-34.2 хувиар, Өмнөговь, Архангай, Төв, Сэлэнгэ, Өвөрхангай, Булган, Дорнод, Дархан-Уул, Хэнтий, Баян-Өлгий, Дорноговь, Ховд, Дундговь, Баянхонгор, Говьсүмбэр, Сүхбаатар, аймагт 2.2-41.7 хувиар тус тус буурав. Харин Хөвсгөл, Увс, Говь-Алтай, Завхан, Орхон аймагт 2.0-54.7 хувиар, нийслэлийн Хан-Уул, Налайх, Баянгол дүүрэгт 1.4-25.8 хувиар, төмөр замын салбарт 20.0 хувиар тус тус өсөв. Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 38.1 хувийг хөнгөн, 49.8 хувийг хүндэвтэр, 10.4 хувийг хүнд, 1.7 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг тус тус эзэлж байгаа ба хөнгөн ангиллын гэмт хэрэг өмнөх оны үеийнхээс 3.4 хувиар өсч, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 12.0, хүнд ангиллын гэмт хэрэг 9.5 онц хүнд ангиллын гэмт хэрэг 27.0 хувиар тус тус буурчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт:

- Баянхонгорт 55.0%
- Өвөрхангайд 44.4%
- Өмнөговьд 40.0%
- Ховдод 37.5%
- Дархан-Уулд 33.3%
- Дорноговьд 31.6%
- Архангайд 30.4%
- Завханд 30.0%

- Говь-Алтайд 25.0%
- Орхонд 27.5%
- Дундговьд 23.5%
- Хэнтийд 15.9%
- Сэлэнгэд 13.6%
- Дорнодод 12.0%
- Хөвсгөлд 8.3%

Баян-Өлгийд Говьсүмбэрт, Сүхбаатарт, Төвд, Увсад тус бүр 0%, Нийслэлийн Налайхад 42.9%, Чингэлтэй, Багануурт тус бүр 40.0%, Баянзүрх Дүүрэгт 39.4%, Сонгинохайрхан Дүүрэгт 24.3%, Баянгол Дүүрэгт 20.1%, Хан-Уул Дүүрэгт 14.1%, Сүхбаатар Дүүрэгт 0%, Төмөр замын салбарт 14.3%, Замын цагдаагийн газар 28.0%, УМБГ, ХБГ, ХХГХТТ 0% байна.

2008 онд Улсын мөрдөн байцаах албанд ирсэн хэргийн төрөл, газар нутаг

Аймаг дүүрэг	Төрөл	Шүүн таслах ажлын эсрэг	Өмчийн эсрэг	Албан тушаалын эсрэг	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	Хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг	Замын хөдөлгөөн, аюулгүй байдлын эсрэг	Бүгд
Архангай		1			1	4		6
Баян-Өлгий						5	1	6
Баян-хонгор		2	2				1	5
Говь-Алтай						5		5
Булган					1	3		4
Говьсүмбэр								
Дархан-уул			2		2	6		10
Дорно говь		1				8	1	10

Дорнод				1	6		7
Дундговь						1	1
Завхан					2		2
Өвөрхангай					5	1	6
Өмнө-говь					2		2
Орхон	2				6		8
Сүхбаатар	1				1		2
Сэлэнгэ	1	2		1	3	2	9
Төв					10		10
Увс					5	1	6
Ховд			1		4	2	7
Хөвсгөл				1	1		2
Хэнтий				1		1	2
Улаанбаатар хот	4	27	2	13	88	15	143
Багануур					1		1
Багахангай дүүрэг		1			1		2
Баянгол дүүрэг		5			12	2	19
Налайх дүүрэг		2		1	4		7
Баян-зүрх дүүрэг	2	5	1	4	16	3	31
Сонгино хайрхан дүүрэг	1	1			13	2	17
Сүхбаатар дүүрэг		4		1	20	3	18
Хан-Уул дүүрэг		3		2	7	2	14
Чингэлтэй дүүрэг	1	6	1	5	14	3	30

Нийт	12	33	3	21	160	26	255
------	----	----	---	----	-----	----	-----

Улаанбаатар хотод гарсан хүний эрүүл мэнд, бие эрхтэн, амь насанд халдсан хэргүүд

(Дүүргээр ангилав. 2009 он, 2010 оны эхний 2 сарын байдлаар)

Дүүрэг	Төрөл	Хүн амь санаатай	Хүн амь санаандгүй	Бусдын бие махбодид халдсан	Хүн амь санаатай	Хүн амь санаандгүй	Бусдын бие махбодид халдсан
Баянгол		1		32			43
Баянзүрх				55		1	57
Сүхбаатар		1		37			56
Сонгинохайрхан		3		39			45
Хан-уул				16			18
Чингэлтэй		1		34			38
Багануур		1		11			10
Налайх				6			7
Багахангай				1			
Нисэх							
Төмөр зам				4			2
Нийт		7		231		1	461
2009 он				2010 оны эхний 2 сар			

Нэмэлт: дээрэм танхайн сэдэлтэй, хүний бие махбодид хохирол учруулсан, амь насанд санаатай болон санаандгүй халдсан хэргүүдийн 53,3 хувь нь 22-06 цагын хооронд болдог.

Улаанбаатар хотод хүчингийн хэрэг 2009 оны байдлаар жагсаахад:

1. Сонгинохайрхан 4
2. Баянгол 3

3. Хан-уул	3
4. Чингэлтэй	2
5. Баянзүрх	2
6. Сүхбаатар	1

2010 оны эхний 2 сарын байдлаар:

1. Хан-уул	3
2. Баянзүрх	2
3. Сонгинохайрхан	2
4. Сүхбаатар	1
5. Чингэлтэй	1
6. Баянгол	1

ЦЕГ-ын албан ёсны веб хуудас болон ЦЕГ, нийслэлийн ЦГ-ын мэдээнд дурдагдсан дээрхи мэдээллүүд зөвхөн ЦЕГ болон цагдаагийн хэсгүүд дээр бүртгэгдэж, тогтоогдсон хэргүүд байна. Албан бус мэдээгээр Улаанбаатар хотод гарч буй хулгай дээрэм, хүн амь, хүчингийн болон бусад төрлийн гэмт хэргийн тал хувь нь цагдаад мэдэгдээгүй байдаг байна.

Нийслэлд гарч буй гэмт хэргүүдийн талаас илүү хувь буюу 68,8% нь гудамж талбайд, мөн 46,9% нь шөнийн цагт буюу 22-06 цагийн хооронд гарч байна. Дүүргүүдэд гарч байгаа хэргүүдийн ихэнхийг гэр хороололууд буюу

<i>Сонгинохайрхан Дүүргийн</i>	<i>Баянгол Дүүргийн</i>
<ul style="list-style-type: none"> ➤ Баянхошуу ➤ Харанхуй ➤ Орбит ➤ Зүүнсалаа ➤ Зурагт ➤ Толгойт 	<ul style="list-style-type: none"> ➤ Гандан ➤ 6-р бичил хороолол
<i>Сүхбаатар Дүүргийн</i>	<i>Чингэлтэй Дүүргийн</i>
<ul style="list-style-type: none"> ➤ 5-н буудал 	<ul style="list-style-type: none"> ➤ Хайлааст

➤ 32-р тойрог	➤ Чингэлтэй ➤ 100-н айл ➤ Дөлгөөн нуур ➤ Баянбүрд ➤ Дэнжийн 1000
<i>Баянзүрх Дүүргийн</i>	<i>Хан-Уул Дүүргийн</i>
➤ Дамбадаржаа ➤ Дарь Эх ➤ Амгалан ➤ Улаанхуаран ➤ Гачуурт	➤ Нисэх ➤ Яармаг ➤ 19-р хороолол

гэх мэт нийслэлийн гэрэлтүүлэг муу, цагдаагийн үйл ажилгаа хангалттай хүрдэггүй газруудад гарч байна.

3.3.2 ХҮНИЙ НАЙМААНЫ ГЭМТ ХЭРГИЙН ЗОЛИОС БОЛОХ ЭРСДЭЛ

Монголд хүн худалдах гэмт хэргийн нөхцөл байдал ямар байна вэ?

Дэлхийн өнцөг булан бүрт ертөнцтэй танилцах гэж ирсэн бяцхан хүүхдүүд өлсөж нас барж байхад, нөгөө талд нь баячууд тэдэнтэй адил хүүхдүүдийн эд эрхтнээр өөрсдийгөө сэлбэн амьд явж, цэнгэлд умбаж байгаа нь амьдрал үнэхээр шударга бус мэт ээ.

- Хүний наймаа гэж юу вэ?
- Хүн худалдалах гэмт хэргийн үүсэл суурь
- Хүн худалдах гэмт хэргийн хор уршиг
- Хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдэж болох арга зам
- Хүн худалдах гэмт хэргийн шалтгаан
- Хүн худалдах гэмт хэргийн нөхцөл байдал
- Хүн худалдах гэмт хэргийн ирээдүйн хандлага
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх арга зам

Хүний наймаа гэж юу вэ?

Хүн бид төрөхдөө яг ижил эрхтэй төрдөг билээ. Гэвч хэн нэгэн нийгэмд эзэлсэн өөрийн давуу байдал болон ёс суртахууны доголдолоороо далайлган бусдын эрхийг зөрчин, хүмүүсийн тайван амьдралд заналхийлж байдаг. Үүний жишээ бол дэлхий нийтийг айдаст

автуулж буй Алан хядлага, Хар тамхи, Хүйтэн зэвсгийн наймаа, Хүн худалдаалах гэмт хэргүүд юм. Эдгээрээс сүүлийн жилүүдэд өсөлтөөрөө толгой цохих болсон нь “ Хүний Наймаа” ажээ.

Хүний наймаа гэгч хүний жам ёсны эрхийг ноцтой зөрчиж хүний мөн чанарыг алдагдуулсан, нөгөө талаар хүний ёс суртахуунгүй байдлын дээд илрэл болсон эзэндээ хамгийн бага зардал, хамгийн бага эрсдэлээр хамгийн их орлогийг оруулж өгдөг найдвартай бизнес болжээ гэж судлаачид үзэж байна.

Өөрөөр хэлбэл шунахайн сэдэлтэй болон эд хөрөнгөндөө эрдсэн ухамсаргүй хүмүүсийн балмад үйл ажилагааны илэрхийлэл, бусдыг хүчээр боолчлох аястай

- Нөхцөл байдлыг овжин ашигладаг
- Далд /эрх мэдэл, ов мэх, арга заль ихээр ашигладаг/
- Ул мөрөө хялбар балладаг
- Эрсдэл багатай
- Их хэмжээний ашиг богино хугацаанд авчирдаг
- Дэлхий нийтэд сүлжээ байдлаар тархсан
- Жижиг бүлгээр ажиллахыг шаардаг
- Олж илрүүлэхэд маш бэрхшээлтэй¹

зэрэг онцлог шинжүүдтэй үлэмж хэмжээний хор хохиролтой гэмт хэрэг мөн.

Хүн худалдаалах гэмт хэргийн үүсэл суурь

Энэ нь түүхэн шинэ үзэгдэл биш бөгөөд боолын нийгэм , феодализмд хүний наймаатай ижил төрлийн үзэгдэл байсан. Орчин үеийн “цагаан боол” хэмээн нэрлэгдсэн энэхүү гэмт үзэгдэл нь XIX-р зуунаас үүдэж эмэгтэйчүүдийг эмзэг байдлаар нь далимдуулан эрхийг нь зөрчиж эд бараатай зүйрлэн худалдах болжээ.²

Хүн төрөлхтөн уг гэмт хэрэгтэй хийх тэмцлээ 1899 оноос эхэлж, бэлгийн мөлжлөгийн зорилгоор эмэгтэйчүүдийг худалдахын эсрэг бага хурлыг Лондонд хийж байжээ. Түүнээс хойш 1904-10 онуудад олон улсын гэрээ батлагдаж 1921 онд Эмэгтэйчүүд хүүхдүүдийг худалдаалахыг хориглосон олон улсын конвенци дэлхийн II дугаар дайнаас өмнө 5 гэрээ, 1949 онд “хүнийг дамжуулан худалдах болон бусдын биеийг үнэлүүлэн ашиглахыг хориглох олон улсын гэрээ” тус тус батлагджээ.

2000 оны 12 сард 41 зүйл бүхий “үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенци” /Палермо-ийн протокол/³ баталсан нь өдгөө дэлхийн улс орнуудын хууль тогтоомжид тусгагдан хэрэгжиж байна.

Монгол улсын хувьд феодализмын үед Хятад улс руу эмэгтэйчүүд хүүхдүүдийг худалдаж байсан гэх тохиодол байдаг.

Жишээ нь: Анх XV-р жаранд Түшээт хан аймгийн Ганжуур гүнгийн хошууны Соном гэгч худалдаачин өөрийн зарц Цэвэлийг 8 настай охины хамт хиймэл диваажинг үзүүлнэ хэмээн хуурч, Хятад данжаадад худалдсан байна.

Түүнээс хойш 1921 он хүртэл Хятад руу монгол эмэгтэйчүүдийг гаргаж байсан баримтууд байдаг. Социалист нийгэмийн үед чөлөөтэй зорчих эрхгүй байсны ачаар энэ асуудал биднээс харьцангуй хол байсан. 1990 оны ардчилал гарснаар дахин сэргэж илүү нууцлагдмал нарийн аргаар үйлдэгдэх болсон.⁴

Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг

Хүн худалдаалах гэмт хэрэг нь дээр дурьдсанчлан хүний жам ёсны эрхийг/амьд байх, амьдрах, эрүүл байх, чөлөөтэй зорчих, оршин байх, итгэл үнэмшилтэй байх.../ ноцтой зөрчиж, нийгэм, улс төр, иргэдийн амьдралд үлэмж хор учруулдаг хүн төрөлхтөний тэвчишгүй мунхаг үйлдэл болохыг онцолж байна.

Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэрэг ихэссэнтэй холбоотой манай нийгэмд айдас хүйдэс, улс орны хөгжилд уруудал доройтол, хөрш зэргэлдээ орнуудад болгоомжлол зэрэг сөрөг үзэгдлүүдийг авчирч байна.

Хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдэж болох арга зам

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үйлдэгдэж болох арга замын хувьд нарийн зохион байгуулалтай, арга ов мэхтэй тул илрүүлэх боломж тун хомс байдаг.

Судалаачид, цагдаагийн байгууллага болон хүний эрхтэй тэмцэх төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаагаар:

- **Танил тал болон найз нөхдөөр дамжуулан судалгаа хийх тандах, ажиглах, танилцах, ажил санал болгох зэргээр хохирогч болох хүмүүсээ сонгодог** /18-25 насны эмэгтэйчүүд, боловсрол нимгэн, гэр бүлгүй, эрүүл, зүс царай сайн, ядуу амьдралтай, ажил хайж байгаа, биеэ үнэлэгч, оюутнууд, бүжигчид, тэнэмэл хүмүүс, хагас болон бүтэн өнчин, хараа хяналт сул, тэнэмэл хүүхдүүдийг сонгодог болохыг тогтоосон байна/
- **Хуурамч үрчлэлт, асрамжийн газраар халхавчилсан хүүхэд наймаалах гэмт хэрэг байгааг анхааруулж байна** /Нийслэлд ажиллаж байгаа 55 асрамжийн төвийн 6 буюу 10.9% нь улсаас үлдсэн 49 буюу 89.1% нь гадаадын иргэний санхүүжилтээр ажиллаж байгаа нь хардлага төрүүлж байгаа ажээ.⁵
- **Гадаадад суралцуулна, урлаг сурталчилах нэрийдлээр гадагш авч явж худалдах тохиолдол ч байна** /12 настай Монгол охиныг эцэг эхэд нь Германд нугаруулж, сургуульд суралцуулна гэж хуурч мэхлэн, хилээр гаргаад зодож албадан хөдөлмөрлүүлж байсныг илрүүлж гэмт хэрэгтэнг ялласан байна.⁶

- Мөн гадаадын хүнтэй гэрлэж амьдралын нөхцөл, орчиноо сайжруулах гэсэн хүмүүсийн сонирхол, хүслийг далимдуулан танилцан гэрлэж, гадаад руу аваачиж худалдах, гадаадын иргэнтэй гэрлэхийг зуучилах явдал их байна/ 2008 оны байдлаар зуучлах албаар дамжуулан БНСАУ-2362, Япон-296, БНХАУ-232, ХБНГУ-229, АНУ-8, Австрали-7, ОХУ-6 гэх мэт 76 орны 3485 иргэнтэй гэр бүл болсон бөгөөд бүгд нутаг руу нь явсан байна./ www.wedinter114.com/ www.hanawed.com гэсэн сайтууд дээр 16-47 насны 194 Монгол эмэгтэй Солонгос иргэнтэй гэр бүл болно хэмээн өөрийгөө танилцуулсан нь хүн наймаалагчдын хараанд өртөөгүй гэх баталгаагүй⁷
- Мөн гадаадад суралцуулна, ажилуулна, амраана, гэж хуурч худалдаалж болзошгүй юм
- Дотоодод / Алтны уурхай, Гадны хөрөнгө оруулалтай компани, Зам засварын бригадуудад хөдөөний болон ажил хайж байгаа эмэгтэйчүүд охидыг хуурч мэхлэн, хүчээр аваачиж биенийг нь үнэлүүлдэг үзэгдэл газар авсаар байна/
- Шөнө орой болон цөөн хүнтэй газраас хүчээр авч явах үзэгдэл ч байсаар байна.
- Шөнийн цэнгээний газар болон дэн буудлууд нь биеэ үнэлэх явдлыг хөхүүлэн дэмжиж ашиг олж буйг тэмдэглэж байна.

Хүн худалдах гэмт хэргийн шалтгаан

Эдүгээгийн даяаршсан дэлхийд энэ үзэгдэл Монголыг тойроогүй нь лавтай. Тэр тусмаа эдийн засгийн хөгжил буурай дэлхийн хоёр том гүрний дунд оршдог жижиг буурай орны хувьд энэ мэт асуудал нь нэлээд ноцтой ажээ. Эдийн засгийн дорой буурай байдал, улс төрийн бодлогын алдаа дутагдал, хуулийн хяналтгүй байдал, нийгмийн сөрөг үзэгдлүүд /согтуурал, мансуурал, биеэ үнэлэх явдал/ гадаад руу амьдралын боломж хөөсөн хүмүүсийн урсгал зэрэг нь уг гэмт хэргийн гарат ихсэх таатай боломжийг бүрдүүлж өгч байна.

Хууль зүйн ухааны доктор профессор Н.Жанцан энэ гэмт хэргийн үүсэх талаар:

1. Нийгэм, эдийн засгийн
2. Үзэл суртлын
3. Соёл хүмүүжлийн
4. Удирдлага, зохион байгуулалтын
5. Нийгэм, сэтгэл зүйн шалтгаанууд байна гэж ангилж үзжээ.⁸

*Цагдаагийн албан хаагчид болон иргэдээс санал асуулга авахад:*⁹

- Иргэдийн 96% нь ядуурал,
- 87% нь ажилгүйдэл
- 82.6% нь биеэ үнэлэх явдал ихэссэн

- 76.8% нь цагдаа хууль хяналтын байгууллагын урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй
- 60.2% нь иргэдийн өөрсдийн хөнгөмсөг байдал
- 40.6% нь хууль эрх зүйн орчин бүрдээгүй болон залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх газар хомс
- 28.6% нь иргэдэд энэ талын мэдээлэл хомс учраас гэжээ.

Харин цагдаа нарын судалгаагаар:

- 92.6% нь ядуурал
- 90% нь ажилгүйдэл
- 89.6% нь эдийн засгийн тогтворгүй байдал
- 80% нь иргэдийн хөнгөмсөг байдал
- 79.2% нь гадаад болон дотоодод бий болсон нөхцөл байдал
- 78.9 хувь нь хэвлэл мэдээллийн сөрөг нөлөөлөл
- 60% нь биеэ үнэлэх явдал ихэссэн
- 20% нь цагдаа хуулийн байгууллагын хяналт сул болон залуучуудын чөлөөт цага өнгөрөөх газар хомс гэсэн бол
- 40% нь иргэдэд мэдээлэл дутмаг гэж хариулсан байна.

Эдгээрээс үзвэл нийгэмд дэх ядуурал, ажилгүйдлийн улмаас гадагш гарч ажил хийх, мөнгө хуримтлуулах, иргэд олон болсон нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх бас нэгэн нөхцөлийг бүрдүүлж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх албанаас гаргасан нарийвчилсан судалгаанаас үзвэл:

- Зар сурталчилгаа 17%
- Бусдад хууртагдсан 13%
- Хүчинд автагдсан 3%
- Хохирогчдын эрсдэл бүхий байдал 19%
- Бусдад уруу татагдсан байдал 11%
- Биеэ үнэлдэг 12%
- Хилийн хяналт шалгалт сул 5%
- Иргэний бүртгэлийн хариуцлагагүй байдал 20% зэрэг шалтгаан нөхцөл байгааг илрүүлжээ.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн доголдол, иргэдийн хэнэггүй байдал, төрийн байгууллагуудын ажлын хариуцлага гэх мэт цогц хэмжээний хүчин зүйлс нөлөөлж байна. Иймээс энэ тал дээр хүмүүс илүү анхаарах нь зүйтэй болов уу.

Хүн худалдах гэмт хэргийн нөхцөл байдал

Монголоос хил давуулан худалдсан гэмт хэрэг:

1999 оны 6-р сард Монгол улсын 3 иргэн БНХАУ-ын иргэн Б-тэй хамтран хэсэг эмэгтэйчүүдийг БНХАУ-ын Эрээн хотод аваачиж биеийг нь үнэлүүлсэн. 2000 онд М гэгч Румын улс руу 18-25 насны 5 бүсгүйг Югославт бүжигчнээр ажилуулна хэмээн хуурч мэхлэн Румын улсад биеийг нь үнэлүүлсэн хэрэг гарсан нь энэ хэргийн¹⁰ эхний тохиодолуудаар бүртгэгдэж байсан. Ийнхүү орчин үеийн боолчлол гэж нэрлэгдэх хүн худалдах гэмт хэрэг нь зүс царайгаа хувьсган илүү нарийн зохион байгуулалттайгаар үйлдэгдэх болжээ.

2000 оноос энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх эрх зүйн тэмцэл эхэлсэн гэдэг. Анх 2002 онд ЭХ-д 124, 113 зүйл заалтыг оруулж 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулсан явдал нь хүн хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ.¹¹ Гэвч энэхүү заалтууд нь энэ төрлийн гэмт хэрэг улам бүр даамжирч байгаа энэ үед төдийлөн үр ашигтай биш байгаа гэж судлаачид үзэж байна. Ялангуяа хохирогчийг хамгаалах зүйл заалт эсвэл бүрэн хэмжээний хууль үгүйлэгдэж байгаа тухай ч дурьдсан байна.

Монгол улсын эрүүгийн хуулийн **124 зүйл**: Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах

113 зүйл: Хүн худалдах, Хүн худалдан авах¹² зэрэг зүйлээр зохицуулдаг билээ.

Зөвхөн:

- эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөр ашиглах бус
- эр эмгүй албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох,
- хүүхдүүдийг биеийг нь үнэлүүлэх эд эрхтэний “донор” болгох
- эмэгтэйчүүд хүүхдүүдийг порнограф-д ашиглах
- хүний наймаачдыг бэлтгэн гаргах зэргээр төрөл зүйл нь өргөжиж байгаа билээ.

Монголд нийгмийн шинэчлэлт өрнөх үед нийгмийн сөрөг үзэгдлүүд газар авч ядуурал, ажилгүйдэл, архидалт, БЗХӨ, гудамжны хараа хяналтгүй хүүхдүүд ихэссэн. Мөн гадаад руу мөнгө олох гэж гардаг явдал, худалдаа наймааны зорилгоор өмнөд хөрш рүү зорчих нь эрс нэмэгдсэн. Энэ нь хүн наймаалагчидад таатай нөхцөлийг бүрдүүлж байгааг эх сурвалжууд онцлон тэмдэглэсэн байдаг.

Дэлхийд жилд 4 сая гаруй эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаж 7-15 тэрбум долларын ашиг олж байна¹³ гэж үздэг.

Тэгвэл Монголд 2000 оны байдлаар 2 хэрэг бүртгэгдсэн бол 2009 онд 300 гаруй болж өсчээ. Энэ бол албан ёсын тоо, цаана нь шалгагдаагүй, илрээгүй маш олон хэргүүд бий.

2009 онд цагдаагийн газраас явуулсан судалгаанаас үзвэл 1000 гаруй монгол охин Макао, Сингапур, Бээжин, Солонгост биеэ үнэлж байгаа, үүнээс Макаоод 500 орчим, Эрээнд 200-300 орчим Бээжинд 300-500 орчим охид саун, массаж, шөнийн цэнгээний газар ажиллаж байгаагийн 70 хувь нь хүчирхийлэлийн золиос болж байгааг тэмдэглэсэн байна.¹⁴

Хүйсийн тэгш эрхийн төвийн санаачилгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны багийн судалгаагаар: 2002-2008 онуудад ЭХ-ийн 113 зүйлээр 4 хэрэгт 4 хүн, 124 зүйл 32 хэрэгт 53 хүн ял шийтгүүлжээ. ЦЕГ-ын мэдээгээр 2007 онд хүн худалдаалах, бусдыг биеэ үнэлэхэд нь зохион байгуулсан хэрэг огт бүртгэгдээгүй боловч 2008 онд 113 зүйл 9 хэрэг 124 зүйл 27 хэрэг бүртгэгдсэн нь далд нууц явагдсаныг гэрчилнэ. Ял шийтгүүлсэн хүмүүсийг авч үзвэл 65% нь эмэгтэйчүүд, насны хувьд 19-30 насны 9, 31-35 насны 18, 36-аас дээш насны 18 байна. Боловсролын хувьд дээд мэрэгжилтэй 8, тусгай дунд 4, бүрэн дунд 16, суурь боловсролтой 7, бага боловсролтой 2 байна. Нийт ажил сургуульгүй 19 хүн, гадаадын иргэн 3 байжээ. Харин хохирогчдыг насны ангиллалаар нь авч үзвэл нийт хохирогчдын 20% нь 21-26 насны, 30% нь 18-21 насны, 14% нь 26-30 насны, 11% нь насанд хүрээгүй хүмүүс байна гэсэн үзүүлэлт гарчээ.¹⁵

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчид нь дундаас дээш боловсролтой, насны хувьд харьцангуй залуу хүмүүс байгаа нь ёс суртахуун, ухамсар хэр доройтсоныг харуулж байна.

Харин хохирогчдын бараг 40 хувь нь 18-аас доош насныхан байгаа нь үнэхээр гашуудалтай дүр зураг юм.

Жишээ 1: Д-ын хэрэгт Макао руу гарсан 10 гаруй охидын 5-ынх нь сургийг гаргасан боловч хэргийн эцсийн шатанд 18 охины 5-нх нь хувь заяа хэрхсэн нь тодорхойгүй үлджээ. Эдгээр охидын хууль ёсны төлөөлөгчийг олж тогтоох боломжгүй иргэний бүртгэлд хамрагдаагүй, хаяггүй, бичиг баримтгүй байх тохиолдол гардаг ажээ. Үүнээс манай улсын хүн амын бүртгэл хангалтгүй байгаа нь харагдана. Гадаадад худалдагдсан хохирогч 10 эмэгтэйтэй Эрүүгийн Цагдаагийн Газар, Хүний эрх хөгжлийн төв, Тагнуулын Ерөнхий газраас тус бүр нэг ажилтан асуулга бэлдэн ярилцлага хийсэн байна. Үүнд дээрх хохирогчидын 9 нь 18-25 насны нэг нь 30 настай, тэд бүгд эрүүл, царай зүс сайтай, гэр бүлгүй, 5 нь хагас өнчин өссөн, бүгд Улаанбаатар хотод амьдардаг, тэд бүгд ажилд зуучлах зараар элссэн байх бөгөөд тэдгээрээс 4 нь ажилгүй байсан, 2 нь биеэ үнэлэгч, 2 оюутан, 1 нь бүжигчин, 1 нь тогооч байжээ. Боловсролын хувьд бүрэн дунд боловсролтой 4, дээд боловсролтой 1, бусад нь ЕБС-д хагас дутуу сурсан байв. 18-25 насны царай зүс сайтай ажилгүй, бүжигчин, оюутан, биеэ үнэлэгч нар өртөх эрсдэл өндөр байгааг анхааруулж байв.¹⁶

Жишээ 2: Макаоод худалдагдсан нэгэн эмэгтэй буцаж ирээд Монголоос 2 бүсгүйг авч явж худалдсан байгаа нь нэгэнтээ энэ гэмт хэргийн хохирогч болсон хүн гэмт хэрэг үйлдэгч болж хувирах явдал цөөнгүй тохиолддогийг харуулж байна.

Жишээ 3: Монгол улсын иргэн Эрдэнэчимэг, Энхжаргал нарт хууртагдан Макао худалдагсан эмэгтэйн өгсөн мэдүүлгээс үзвэл, анх дээрх нэр бүхий хоёр эмэгтэйтэй найз бүсгүйгээрээ дамжуулан танилцсан бөгөөд 10-р ангиа төгсөөд ажил хайж буй 80 гаруй охиныг Макао аваачиж худалдсан гэх бөгөөд, охидыг Макао руу гаргадаг 2 том бүлэг байдаг гэжээ.

2004 оны 8-10 сард Монгол улсын иргэн Дөлмаа 7 эмэгтэйг Макао руу худалдсан бөгөөд ахин 10 эмэгтэйг гаргахаар завдсан үйлдэл дээрээ баригдаж эрүүгийн хуулийн 113.3 зүйлээр 10 жил 10 хоногийн ял авчээ.¹⁷

Монгол улсын иргэн Ц. Энхчимэг 2 удаагийн үйлдлээр 3 охиныг БНХАУ-ын ӨМӨЗО-ы иргэдэд худалдаалах гэж байсан үйлдэлд Сонгинохайрхан дүүргийн шүүхээс 10 жилийн хорих ял оноожээ.

Дээрх жишээнүүдээс харвал хүн худалдах гэмт хэргийг үйлдэгчидийн тоонд эмэгтэйчүүд ихээр оролцож байгаа нь ихээхэн харамсалтай байна.

Дотоодод энэ төрлийн гэмт хэрэг багагүй үйлдэгдэх болсныг цагдаагийн, хэвлэл мэдээлэлийн болон хүний эрхийн байгууллагууд мэдээлсээр байна.

Хөдөө орон нутгаас охид эмэгтэйчүүдийг “өндөр цалинтай ажилд оруулна” хэмээн хуурч мэхлэн Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотод авч ирэн зочид буудал, саун, шөнийн цэнгээний газраар хүчээр биеийг нь үнэлүүлэн ашиг олдог арга газар авсаар байна.¹⁸

Жишээ 1: Иргэн П. Д гэгч нь 2007-2008 оны 1 сард Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Яргуй, Принц, Патая, Маскара, Тэнгис нэртэй саун массажны газрыг түрээслэн ажилуулж байхдаа С,Ж,Э,А,Я,Ц,Д нарыг хүлээн авахын ажилтанаар ажилуулан биеэ үнэлэхэд нь зуучилсан байна.¹⁹

Жишээ 2: М.Пүрэвбат гэгч 2006 оны 2 сарын 5-нд С,Д,Т нарын 3 эмэгтэйг гудамжинд явж байхад нь барьж авч Толгойтод аваачиж зодож, шалан дээр зоосон зүүн дээр суниалган танхайрсан байна. Мөн 5 охиныг 2007 оны 10 сараас 2008 оны 3 сар хүртэл оройн цагаар явж байхад нь хүргэж өгнө хэмээн хуурч бааранд оруулж үл таних хүмүүст өгч биеийг нь үнэлүүлж өдрийн цагаар гэрийн хорионд байлгаж байсан байна. 5 охиных нь нэгний хүүхэд нь зулбасан байна. М.П гэгчид 15 жилийн хорих ял оноосон байна.²⁰

Энэ мэтчилэн хүчээр авч явж биеийг нь үнэлүүлэх явдал олон байдаг ч тэр бүрт тохирсон хариуцлагыг гэмт этгээдэд оногдуулахгүй тохиолдол нь гэмт этгээдүүдийг давраах сөрөг талтай. Зарим цагдаагийн байгууллагынхан “хөнгөн явдалтай”, “өөрөөс нь болсон” гэх мэтээр хариулдаг нь ийм хэрэг далд байх боломжийг бүрдүүлж болзошгүй юм.

Жишээ 3: Насанд хүрээгүй Н-ийг 2006 оны 7 сарын 16 өдөр гэрлүүгээ явж байхад нь найз охиных нь үерхдэг залуу А гэгч хүргэж өгье хэмээн хуурч Хан-Уул дүүрэгт байрлах ХААИС-ийн урд байдаг айлд аваачин улмаар үл таних эрэгтэй, эмэгтэй хоёр охиныг

зодож биеийг нь үнэлүүлж мөнгийг нь өөрсдөө авч байсан гэсэн мэдүүлэг өгсөөр байхад 113-р зүйлээр бус 124-р зүйлээр шийдвэрлэж хэргийг буцаасан байна.²¹

Хүний наймааны нэг бүрэлдэхүүн хэсэг болсон хүүхэд худалдаалах гэмт хэрэг Монголд их гарч байгааг 1996 онд 4000-д хүрч байсан гудамж талбайгаар тэнүүчлэгч хүүхдүүд их цөөрсөн нь хардлага төрүүлнэ. Мөн цөөн үзэгдэх траншейнхан хүмүүжил, боловсролгүй хараа хяналтгүй байна. / Траншейныхан 2 охиныг хүч хэрэглэн, орилж хашхирвал нүүрийг чинь зүснэ, ална хэмээн сүрдүүлж хүчиндэн, Улаанбаатар зочид буудлын өмнө цагийн 6000, хоногийн 15000 төгрөгөөр биеийг нь үнэлүүлж хооронд нь зодолдуулж элэглэсэн байна./²²

Мөн 2009 оны байдлаар хичээлээсээ тарж яваад алга болсон хүүхдүүд, ор сураггүй болсон хүүхдүүдийн тухай мэдээ олон байсан нь үнэхээр эмзэглүүштэй. Тэдгээр нь чухам хаачсан хэрхэснийг төдийлөн мэдээлээгүй билээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн ирээдүйн хандлага

Дэлхийн болоод Монголд дээрх гэмт хэргийн нөхцөл байдал нэн хүнд болсон цаг үед цаашид хэрхэх бол гэдэг асуудал гарч ирнэ.

Монголын хувьд 2009 оны байдлаар 300 хол давсан энэ төрлийн гэмт хэргийг албан ёсоор бүртгэсэн байх юм. Нэг хэргийн цаана өчнөөн хүн байгааг тааварлах аргагүй. Улс орнуудыг хүлээн авагч, дамжин өнгөрүүлэгч, илгээгч хэмээн ангилан авч үздэг. Монгол одоогоор идэвхитэй илгээгч бас дамжуулагч орон болон хувирч байна.²³ Гадаадад гарах гэсэн олон мянган хүмүүсийн цуваа цаашид энэ төрлийн гэмт хэрэг багасах бус илүү даамжирч болзошгүйг харуулж байна. Мөн Монголын нийгмийн байдал, соёлын үнэлэмж, улс төрийн бодлого зэрэг нь гэмт явдлыг үүрлэх нөхцлийг бүрдүүлж байгааг бид харж байна. Тиймээс яг одоо бид тайван амьдралынхаа төлөө юу хийж чадах вэ? гэдгээ ойлгоод арга замыг хэрэгжүүлж, хийж эхлэх нь зүйтэй болохыг хүний эрхийн төрийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллагууд үзэж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх арга зам

Өнөөдөр дэлхийн бусад улс оронд уг нарийн зохион байгуулалтай гэмт хэрэгтэй тэмцэхдээ:

- Оновчтой бодлого, хамтын ажиллагаа /Policy and Cooperation/
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ / Prevention/
- Үр нөлөөтэй шийтгэлийн систем / Prosecution/
- Хохирогчийг хамгаалж, нийгэмшүүлэх /Protection/

гэсэн зарчмаар ажиллаж байгаа билээ.

1. Монгол улс энэ чиглэлээр 2005 оны 11 сарын 30-нд “ Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталжээ.²⁵ Үүнд:

- Олон улсын хэмжээний гэрээ баримт бичгүүдийг дотоодын нөхцөлд зохицуулан хэрэгжүүлэх
- Хүн худалдах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөр ашиглахаас хамгаалах, тэднийг садар самуунд уруу татах дотооддоо болон хил давуулан худалдах гэмт хэрэг, учрах хор хохирол, гарах үр дагаварын талаархи эцэг эх, иргэний нийгэм, хүүхэд залуучуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх
- Эдгээр гэмт хэрэгтэй тэмцэхэд бусад оронтой хамтран ажиллах, туршлага солилцох
- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх нийгэмшүүлэх арга хэмжээнд олон нийтийн оролцоо, саналыг хүлээн авч ажиллах зорилтуудыг тавьжээ.

2. Манай улсад уг гэмт хэрэгтэй тэмцэх ажил ерөнхийдөө иргэний нийгэм болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжиж ирсэн гэж судлаачид үзэж байгаа юм. Тиймээс нэн даруй шинээр ажлын байр бий болгох, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, өртөх шинж бүхий бүлгийг хамгаалах, хяналтанд оруулах, үндэсний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай гэжээ.

3. Хууль сахиулах байгууллага болон шүүхээс хүн худалдах гэмт хэргийн талаар явуулж буй үйл ажиллагаанд:

- Гэмт хэрэгтэнг баривчлах, шийтгэх
- Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх

Одоогоор мөрдөгдөж буй Эрүүгийн хуулиар 113 зүйл, 124 зүйлээр зохицуулж байгааг илүү боловсронгуй болгох шаардлагатай байгааг дурджээ.

4. Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх салбарт хамгийн их доголдож буй чиглэл нь хохирогчийг хамгаалах тогтолцоо юм. Хохирогчийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд:

- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Сэтгэл зүйн зөвөлгөө
- Хууль зүйн туслалцаа
- Эх оронд нь аюулгүй буцаах

- Хохирогчдыг мэргэжлийн сургалтанд хамруулах, ажлын байраар хангах зэрэг багтана.

Энэ чиглэлээр төдийлөн арга хэмжээг авч чадахгүй байгааг цохон тэмдэглэж байна. Дээрх 4 чиглэлээр үйл ажиллагаагаа нягт нямбай боловсруулж хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг тэмцвэл үр ашгаа өгөх боломжтой гэж үздэг юм байна.

Энэхүү мэдээллийг бэлтгэх явцад “хүний наймаа” гэгч энэхүү хорт аюул манай нийгэмд ямар их хор хөнөөл учруулж байгааг хэлэх нь илүүц юм. Хамгийн аймшигтай нь Монголд маань нөхцөл байдал туйлын эрсдэлтэй байгаа тул хүн бүр, иргэн бүр энэ аюулын эсрэг санаа бодлоо нэгтгэн тэмцэх, төр засаг, иргэний нийгмийн байгууллагууд, судлаачидын хамтын үйл ажиллагаа үгүйлэгдэж буйг тэмдэглэхийг хүслээ.

Хүн худалдах гэмт хэрэгтэй холбоотой эх сурвалж:

1. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл
Орхон аймаг, Эрдэнэт хот 2008-12-08
2. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл
Дорно говь, Замын үүд сум 2009-05-/08-07/
3. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл
Ховд аймаг, Ховд хот 2008-03/30-31/
4. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл УБ хот 2008
5. Хүний наймаатай тэмцэх үндэсний зөвлөлдөх уулзалт УБ хот 2009
6. ХХГХ-эргийг шийдвэрлэх судалгааны тайлан УБ хот 2009
7. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хууль эрх зүйн зохицуулалт /бусад орны хууль тогтоомжоос/ УБ хот 2005 он
8. Хүн худалдаалах гэмт хэрэг /Суралцагсдын гарын авлага/ УБ хот 2009

Хүний эрхийг хамгаалах байгууллагууд:

1. Хүний эрхийн үндэсний комисс/ХЭҮК/
2. Ерөнхийлөгчийн тамгийн газар /ЕТГ/
3. Хүний аюулгүй байдлын судалгааны төв /ХАБСТ/
4. Шевьярын Хөгжлийн Агентлаг /ШХА/
5. Хүйсийн Тэгш Эрхийн Төв ТББ/ХТЭТ/
6. Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн /ХЗҮХ/
7. Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МЭС/
8. Нийслэлийн Цагдаагийн Газар /НЦГ/
9. Цагдаагийн Ерөнхий Газар /ЦЕГ/
10. Монголын оюутны холбоо /МОХ/

Ашигласан материал:

1. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл
Орхон аймаг, Эрдэнэт хот 2008-12-08
2. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл
Дорно говь, Замын үүд сум 2009-05-/08-07/
3. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл
Ховд аймаг, Ховд хот 2008-03/30-31/
4. ХХГХ-тэй тэмцэх нь илтгэлийн эмхтгэл УБ хот 2008
5. Хүний наймаатай тэмцэх үндэсний зөвлөлдөх уулзалт УБ хот 2009
6. ХХГХ-эргийг шийдвэрлэх судалгааны тайлан УБ хот 2009
7. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хууль эрх зүйн зохицуулалт бусад орны хууль тогтоомжоос/ УБ хот 2005 он
8. Хүн худалдаалах гэмт хэрэг /Суралцагсдын гарын авлага/ УБ хот 2009

- ¹ “Хүний наймаатай тэмцэх нь” үндэсний зөвлөлдөх уулзалт /УБ 2009 / Илтгэгч МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш Г.Эрдэнэбат
- ² “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 7
- ³ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 10
- ⁴ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 8
- ^{5,7} “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 25
- ⁶ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 24
- ⁸ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 17
- ⁹ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 19
- ¹⁰ “Хүний наймаатай тэмцэх нь” үндэсний зөвлөлдөх уулзалт /УБ 2009 / Илтгэгч МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш Г.Эрдэнэбат
- ¹¹ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/
- ¹² “Бэлгийн хүчирхийлэл, Хүчингийн гэмт хэргийн хууль эрх зүйн зохицуулалт /УБ2005/ 124 нүүр
- ¹³ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/
- ¹⁴ “Хүний наймаатай тэмцэх нь” үндэсний зөвлөлдөх уулзалт /УБ 2009 / Илтгэгч Улсын Ерөнхий Прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Х.Батчимэг
- ¹⁵ “Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт”/УБ2009/ Судалгааны тайлан нүүр 8-9
- ^{16,18} “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/ нүүр 23
- ¹⁷ “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлагаас /УБ 2009/
- ¹⁹ “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь” /Ховд аймаг2009-03-30,31/ нүүр 49
- ²⁰ “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь” /Ховд аймаг2009-03-30,31/ нүүр 47
- ²¹ Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт”/УБ2009/ Судалгааны тайлан
- ²² “ Хүний наймаатай тэмцэх нь” үндэсний зөвлөлдөх уулзалт /УБ 2009 / Илтгэгч Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, шүүгч Б.Сарантуяа
- ²³ “ Хүний наймаатай тэмцэх нь” үндэсний зөвлөлдөх уулзалт /УБ 2009 / Илтгэгч Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүн, доктрант П.Оюунчимэг
- ^{24,25} “Хүний наймаатай тэмцэх нь” үндэсний зөвлөлдөх уулзалт /УБ 2009 / Илтгэгч МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш Г.Эрдэнэбат

3.3.4.1 Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс

Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь дараахь чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

- 1. Нийслэл хотод үйлдэгдсэн хүнд, онц хүнд гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх,**

Нийгмийн хэв журам хамгаалах албадын уялдаа холбоог зохион байгуулах ажлыг удирдаж хяналт тавих.

2. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчтай холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллах
3. Хэн болох нь тогтоогдоогүй цогцос, сураггүй алга болсноор бүртгэгдсэн хүмүүсийн судалгааг гарган эрэн сурвалжлах ажиллагааны явцад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах
4. Нийслэл хотод үйлдэгдсэн ижил төстэй гэмт хэргийн үйлдлийн арга, үйлдсэн этгээдийн талаархи судалгааг нэгтгэн гаргаж, нөхөн илрүүлсэн хэргийн мэдээнд хяналт тавьж, үр дүнг тооцох дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийг мэдээллээр ханган, холбож ажиллах
5. Нийслэл хотод үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэв журмын хэлтэстэй хамтран ажиллах, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах
6. Нийслэлийн хэмжээнд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй буюу, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь оргон зайлснаар түдгэлзүүлсэн гэмт хэргийн нэгдсэн судалгааг гаргаж, шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллана.
7. Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн онц хүнд гэмт хэргийн газарт шуурхай очиж хэргийн газрын үзлэгийг удирдан явуулж, үзлэгт оролцож байгаа цагдаагийн алба хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тухайн хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох хойшлуулашгүй ажиллагаа зохион байгуулна.
8. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас гэмтэж бэртэн, ГССҮТөвд ирж үйлчлүүлж байгаа иргэдийг бүртгэн харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх
9. Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн талаархи мэдээллийг иргэдээс үнэлж авах, мэдээллийн нууцлалыг хадгалах
10. Нийслэл хотод үйлдэгдсэн халаасны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна,
11. Иргэд аж ахуйн нэгж байгууллагын нохдыг гаршуулан тэжээж харуул хамгаалалтын болон бусад зорилгоор ашиглахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх чиглэлээр төлбөртэй сургалт зохион байгуулна.

1. Прокурорын байгууллагын тогтолцоо

Прокурорын байгууллага нь:

- Улсын ерөнхий прокурорын газар;
- Аймаг, нийслэлийн прокурорын газар;
- Сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газар;
- Тээврийн прокурорын газраас бүрдэнэ.

Тээврийн прокурорын газар нь дагасан прокурорын газар мөн.

2. Прокурорт гомдол гаргах

Дараах асуудлаар прокурорт гомдол гаргана.

- Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хууль зөрчсөн, захиргааны журмаар хэрэглэх таслан сэргийлэх арга хэмжээг буруу хэрэглэсэн, захиргааны шийтгэл хууль бусаар ногдуулсан, захиргааны журмаар хэрэглэх албадан болон түр саатуулах ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй, захиргааны хэрэг бүртгэх эрхтэй төрийн захиргааны байгууллагад албан тушаалтан хууль зөрчсөн зэрэг асуудлаар прокурорт гомдол гаргана.
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, тэдгээрийн гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг прокурорт гаргана.
- Хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан прокурорын байгууллагад гомдол гаргаж болно.
- Цагдан хорих байрны нөхцөл журмын талаархи гомдлыг прокурорт гаргана.

3. Прокурорын байгууллагад өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээж авах харьяалал

Хэрэг материалын талаар гаргасан хүсэлтийг тухайн хэрэг, материалыг шалгах ажиллагаанд хяналт тавьж буй прокурорт гаргана. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг тухайн хэрэгт хяналт тавьж буй прокурорт гаргана.

Прокурорын үйл ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлыг дээд шатны прокурорт гаргана.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгсдийг цагаатгах асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг Улсын ерөнхий прокурорын газарт энэ ажлыг хариуцсан хяналтын прокурорууд, бусад прокурорын газарт аймаг нийслэлийн прокурорууд шалгаж шийдвэрлэнэ.

4. Прокурорт хандаж гаргасан хүсэлт гомдлыг хянан шийдвэрлэх тухай

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нь тодорхой байцаан шийтгэх ажиллагаа явуулах, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулах тухай гомдол, хүсэлт гаргасан бол дор дурдсан хугацаанд хянан шийдвэрлэж хариу өгнө.

- Шууд шийдвэрлэж хариу өгнө.
- Шууд шийдвэрлэх боломжгүй бол хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор шийдвэрлэж хариу өгнө.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын шийдвэр үйл ажиллагаанд гаргасан гомдлыг дор дурдсан хугацаанд хянан шийдвэрлэж хариу өгнө.

- Хүлээн авсан албан тушаалтан хүлээн авснаас хойш 72 цагын дотор шийдвэрлэх хариу өгнө.
- Нэмэлт материал шалгах буюу бусад арга хэмжээ авах бол ажлын 7 хоногт шийдвэрлэнэ.

Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэрийн талаар гаргасан гомдлыг дор дурдсан хугацаанд хянан шийдвэрлэж хариу өгнө.

- Захиргааны таслан сэргийлэх арга хэмжээ, албадан болон түр саатуулах ажиллагааны талаар гарсан гомдлыг 24 цагийн дотор
- Бусад асуудлаар гаргасан шийдвэрийг 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Ял эдлүүлэх байгууллага, ял эдлүүлэх ажиллагааны талаар гаргасан гомдлыг дор дурдсан хугацаанд хянан шийдвэрлэж хариу өгнө.

- Хорих, хорихоос өөр төрлийн ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой гомдлыг 14 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө.
- Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих байрны нөхцөл журамтай холбоотой гомдлыг 48 цагийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө.

ÍÓ-í àð°íòèé ìðíèóðíðúí ààçðààñ èðäýàèéá òçëýýí àâ÷ óóèçàð òààèéí óóàààðü

Ä/Ä	Àëááí òòøààè, íýð.	°ã°ð	Öàã
1.	Óèñúí àð°íòèé ìðíèóðíð Ì.Àèðàíðóýã	Ñàð áçðèéí 1, 3 ààðü 7 ðííàèéí Ëðàããà	15:00-17:00
2.	Óèñúí àð°íòèé ìðíèóðíðúí ìðèí÷ Á.Öýðýíáàèðàà	Ñàð áçðèéí 2, 4 ààðü 7 ðííàèéí Áààñàí	11:00-13:00

3.	Óēñúí àð°íðeé ìðíeóðíðúí ìðeíā÷ ×.Í°íðáàð	Ñàð á¿ðeéí 1, 3 ààõü 7 õíñāeéí Äāāāā	11:00-13:00
4.	Óēñúí àð°íðeé ìðíeóðíðúí ðõñeàð, Õýðýā ýððeýõ āàçðúí āàðāā Á.Æàðāāēñāeóāí	Ëõāāāā	15:00-17:00
5.	Óēñúí àð°íðeé ìðíeóðíðúí ðõñeàð, Ì°ðā°í āāeóāāð àeðeēāāāāíā õýíāeð ðāāeð õýeðñeéí āàðāā Ë.Áíeā	Ï¿ðýā	11:00-13:00
6.	Óēñúí àð°íðeé ìðíeóðíðúí ðõñeàð, õýðýā á¿ðāýõ àeðeēāāāāíā õýíāeð ðāāeð õýeðñeéí āàðāā Ä.Áāýíeāðāāe	Ïýāíāð	11:00-13:00
7.	Óēñúí àð°íðeé ìðíeóðíðúí ðõñeàð, Ø¿¿õýā ð°ðeēā ð°e°e°õ õýeðñeéí āàðāā Á.Áàòíðøeð	Äāāāā	15:00-17:00
8.	Óēñúí àð°íðeé ìðíeóðíðúí ðõñeàð, ße ýāe¿¿eýõ àeðeēāāāāíā õýíāeð ðāāeð õýeðñeéí āàðāā Õ.Àðeóíáíeā	Ëõāāāā	11:00-13:00

Òāeēāāð:

- Óēñúí àð°íðeé ìðíeóðíð, ð¿¿íeé ìðeíā÷ áíeí ðõñeàðóóā íü áýýð āàðeāāāñāí ðóāāāðeéí āāāó ððāýāeēā ð¿eýýí āā÷ óeçāíā.
- Àeāāí àeēúí à÷āāeēúā ðāðāāeçāí 1 ð¿íeé óeçāð ðóāāòāā 15-20 ìeíòāāñ õýððýõā¿e áāeāāe çíðeíí.
- Äýýðõýýñ áóñāā ðíeēíeāíeā Óēñúí àð°íðeé ìðíeóðíðúí āàçàðð āàðāāñāí ððā°e āñāeúā Ïýāýeýe eāāeāāāāíü ð°āeéí àeðeðāí °āð á¿ð ð¿eýýí āā÷ çíðeð æóðííí āāāó øeēāýðe¿eíý.

Дэлгэрэнгүйг www.gpo.mn вэб хуудаснаас авна уу.

Авилгалтай тэмцэх газрын үйл ажиллагааны талаар мэдэхийг хүссэн иргэд www.iaac.mn гэсэн вэб хуудаснаас авч болно.

4. Нийгмийн хамгаалал, эргэн нийгэмшилт

4.1 Буцах, эргэн нийгэмших боломжгүй газрууд (байгалийн гамшиг, өлсгөлөн гэх мэт)

Одоогоор монголд ийм газар байхгүй байна.

4.2 Байр, орон сууц

Монгол Улсын Засгийн газрын тухай 1 хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газар Женевийн конвенцийн хамаарах хүрээнд дайнд нэрвэгдэгсдэд туслах, зэвсэгт мөргөлдөөн үүссэн нөхцөлд хэлмэгдэгсдэд болон байгалийн гамшиг, гэнэтийн осол, сүйрэл, нийтийг хамарсан гоц аюулт халдварт өвчинд нэрвэгдэгсдэд яаралтай тусламж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх бэлтгэл сургалт зохион байгуулах, эсхүл хүмүүнлэгийн бусад арга хэмжээг хэрэгжүүлэх талаар мэдээлэл, сурталчилгаа хийхтэй холбогдсон зардлыг МУЗН-тэй жил бүр гэрээ байгуулах замаар улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэсэн заалт байдаг¹. Гэвч одоог хүртэл МУЗН-д засгийн газраас үүнд зориулж ямарч санхүүжилт өгөөгүй байна. Гамшгийн тухай хуульд гамшгийн үеийн аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүч хэрэгсэл дайчлан гаргаж, хүн ам, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлж болно. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар тухай бүрт нь батална гэж заасан байдаг². Гамшиг тохиолдсон бүс нутгийн иргэдэд хэрхэн өмчийг эргүүлэн олгох буюу нөхөн төлбөр өгөх тухай заасан зохицуулалт байхгүй байна.

Харин газрын тухай хуулинд **“Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах”** тухай зааж өгсөн байдаг. Тухайлбал: улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай байгуулах, улсын чанартай зам, шугам сүлжээ, барилга байгууламж барих зэрэг тохиолдлуудад нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэрийг Засгийн газар гаргана хэмээн заажээ³. Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлэн авахад газар өмчлөгчид олгох нөхөх олговрыг улсын төсвөөс гаргана.

4.2.1 Өмч эргүүлэн олгох буюу нөхөн төлбөр (Хуучин зөрчилтэй буюу гамшиг тохиолдсон бүс нутагт)

4.2.2 Нутагтаа эргэн ирж буй хүмүүст зориулсан байр орон сууцны хөтөлбөр (байгаа бол)

Одоогоор монгол улсад ийм хөтөлбөр байхгүй.

¹ Монгол Улсын Засгийн газрын тухай 1 хуулийн 19 дүгээр зүйл

² “ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ” Монгол улсын хууль, 2003 оны 06 дугаар сарын 20-ний өдөр, <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=1304>

³ Монгол улсын “Газрын тухай хууль”, 2002 оны 6 сарын 07-ны өдөр, 32-р зүйл, <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=5616>

4.2.3 Орон сууц, хаус барих боломжууд

4.2.3.1 Газар өмчлөх нөхцлүүд

Монгол улс 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр баталсан хуулиараа гэр бүлийн хэрэгцээнд, иргэн, түүний гэр бүлийн гишүүн-Монгол Улсын иргэнд дундаа хамтран өмчлөх хэлбэрээр нэг удаа газар үнэгүй өмчлүүлэхээр шийдвэрлэж, хэрэгжүүлж байсан⁴. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газар нь түүний байршил, зориулалтаас хамааран дор дурдсан хэмжээтэй байна:

Гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрын		
Байршил		хэмжээ /га/
1	Нийслэлд	0.07 хүртэл га
2	Аймгийн төвд	0.35 хүртэл га
3	Сумын төв, тосгонд	0.5 хүртэл га
4	Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт /сумын төвөөс бусад/ ⁵	0.07 хүртэл га

Энэхүү хуулинд 2008 оны 5 дугаар сарын 22-нд нэмэлт өөрчлөлт оруулж Монгол улсын иргэн бүр дээрх хэмжээний газрыг өмчлөх эрхтэй болсон. Мөн Монгол улсын иргэн Монгол улсын нутаг дэвсгэрийн хаана ч газар эзэмшиж болохоор тусгагдсан. Өөрөөр хэлбэл хүссэн хот, аймаг, сумын газар нутагт газар өмчлөх эрх нээлттэй болсон.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т заасны дагуу 2008 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө өмчлүүлсэн газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлнэ⁶. 2008 оны тавдугаар сарын нэгнээс 2013 оны тавдугаар сарын нэгэн хүртэл газар хувьчлах хугацааг таван жилээр сунгаж байгаа юм. Тухайн иргэний хувьчилж авах газар 0.07га-аас илүү гарсан тохиолдолд тухайн жилдээ газрын албанаас гаргасан үнийн дагуу төлбөрийг төлж өмчлөлдөө авч болно. Харин 0.07 га-аас бага байгаа тохиолдолд дахин нэмж олгохгүй. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар өмчлөх эрх эдлэхгүй.

Газар өмчлөх аргачлал:

1-р алхам:

⁴ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль: <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=1901>

⁵ 2008.05.22-ны өдрийн хуулиар орсон нэмэлт

⁶ Энэ зүйлийг 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн

- Газар өмчлөхийн тулд иргэн та эхлээд дүүргийнхээ газрын албанд хандана.
- Газар эзэмшихийг хүссэн өргөдөлдөө авах гэж байгаа газрынхаа байршлыг тодорхой бичээд, дүүргийнхээ газрын албаны газар зохион байгуулагчид өгч, газар авах зөвшөөрөл аваад, кадастрын зураг хийлгэнэ.
- "Газар эзэмшигчийн гэрчилгээ" 45 хоногийн дотор гарна.
- "Газар эзэмшигчийн эрхийн гэрчилгээ"-нд үндэслээд дүүргийн газрын албанаас судалгаа явуулаад зөвшөөрөл олгоно.
- Иргэний үнэмлэхээ нотариатаар батлуулаад, өргөдлөө кадастрын зурагтайгаа хавсарган оршин суугаа дүүргийнхээ Газрын албанд өгөөрэй

Үүний дараа өмчлөх шийдвэр гаргуулж авахын тулд доорх материалыг бүрдүүлнэ.

2-р алхам: Газар өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх:

Бүрдүүлэх бичиг баримт:

1. Өмчлөгч, хамтран өмчлөгч нарын иргэний үнэмлэхний хуулбар /насанд хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар/ нотариатаар гэрчлүүлсэн байна.
2. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх шийдвэр, гэрчилгээ /эх хувь/
3. Газар өмчлүүлэх тухай захирамжийн хуулбар
4. Газрын кадастрын зураг /эх хувь, хуулбар 1%/
5. Газрын хянан баталгааны хуудас /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/
6. Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /бүртгүүлэхийг хүссэн өргөдөл, хэдэн хүний өмч, талбайн хэмжээ, газрын үнийн талаар тодорхой бичнэ/ өргөдлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.
7. Хорооны Засаг даргын тодорхойлолт

Үйлчилгээний хөлс:

1. Баталгаажуулахад – 2500Т /яаралтай – 5000Т/
2. Хувийн хэргийн үнэ -2500Т
3. Гэрчилгээний үнэ - 5000Т.

- Та батлагдсан загварын дагуу мэдүүлэг⁷ авч бөглөөд бүрдүүлсэн баримт бичиг, мөнгө тушаасан баримтын хамт тухайн үл хөдлөх эд хөрөнгө оршин байгаа дүүргийн мэдүүлэг хүлээн авах цонхонд өөрийн биеэр хүлээлгэн өгнө.
- Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг баталгаажуулахад ажлын 5 хоногт, яаралтай хураамж төлсөн бол ажлын 8 цагт бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ
- Та баталгаажсан гэрчилгээгээ олгох цонхноос өөрийн биеэр ирж, иргэний үнэмлэхээ үзүүлэн авна.

3-р алхам: "Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ" авах

Танд өмчлүүлэхээр захирамж гарсан газраа Улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай. "Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ" авахын тулд дүүргээсээ нийслэлд явуулна. Нийслэлийн Засаг даргын захирамжийг үндэслэн Нийслэлийн газрын алба дүүргүүдэд шийдвэрүүдийг гаргаж өгнө. Бусад шийдвэрийг дүүргийнхээ газрын албанаас авна. Хянан баталгааны дүгнэлт, шийдвэр, кадастрын зурагтайгаа нотариатаар батлуулсан бичиг баримтаа хавсаргаад, Үл хөдлөх хөрөнгийн газарт өгнө. Тухайн газраас гэрчилгээ бэлэн болсон тухай мэдэгдэж "Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ" иргэн таны гар дээр очно⁸.

Гадаадад байгаа иргэн, хүүхэд, өнчин хүүхэд, цэргийн албан хаагч, хорих ял эдэлж байгаа, эрх зүйн чадамж нь шүүхээр хязгаарлагдсан болон сэтгэцийн өвчтэй иргэд тус бүр өөрийн хууль ёсны болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан газраа авах боломжтой⁹.

Гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн газар өмчилж эрхээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Монгол Улсын харьяатаас гараагүй, Монгол Улсын иргэн гэдгийг нотлох баримт бичигтэй бол газар өмчилж авах эрхтэй. Гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэн газар өмчилж авах эрхээ өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой юм. Итгэмжлэлийг “Нотариатын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлд зааснаар тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газраар гэрчлүүлэн ирүүлснээр итгэмжлэгдсэн төлөөлөгч нь гадаадад оршин сууж байгаа иргэний нэр дээр газар өмчилж авахыг хүссэн өргөдөл гаргах эрхтэй болно¹⁰.

Гадаад улсын иргэн Монгол улсын иргэнээс хүүхэд үрчилж авсан тохиолдолд уг хүүхдийн газар өмчлөх эрх хадгалагдах уу?

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” болон “Харьяатын тухай хууль”-д зааснаар уг хүүхдийн газар өмчлөх эрхийг Монгол улсын төр хадгалах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, гадаад улсын иргэнд үрчлэгдсэн Монгол хүүхэд үрчилж авсан хүнийхээ

⁷ <http://gazar.ub.gov.mn/images/maygt/3.pdf>

⁸ <http://sakura.mn/mn/%D0%93%D0%B0%D0%B7%D0%B0%D1%80-%D3%A9%D0%BC%D1%87%D0%BB%D3%A9%D1%85-%D0%B0%D1%80%D0%B3%D0%B0%D1%87%D0%BB%D0%B0%D0%BB.html>

⁹ www.realestate.blog.baniig.net

¹⁰ http://www.gazar.ub.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=327&Itemid=74

иргэний харьяаллыг дагаж тухайн улсын иргэн болж, Монгол улсын харьяатаас гардаг эрх зүйн зохицуулалттай. Иймд нэгэнтээ тухайн хүүхэд Монгол улсын харьяатаас гарсан тул “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-д зааснаар гадаад улсын иргэн газар өмчлөх эрхгүй болно.

4.2.3.2 Зах зээлийн ханшийн мэдээлэл (газар, барилгын материал гэх мэт)

Газрын суурь үнэлгээг тэдгээрийн зэрэглэл, байршил, инженерийн хангамж, нийгэм, эдийн засгийн болон инженер, геологи, байгаль орчны нөхцөл, ашиглах зориулалтыг харгалзан Засгийн газар тогтооно гэсэн хуулийн зохицуулалттай¹¹.

Засгийн газраас тогтоосон журмын дагуу Барилга хот байгуулалтын Сайдын 2007 оны 136-р тушаалын хавсралтаар "Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал"-ыг баталсан байна. Энэхүү аргачлалд зааснаар Улаанбаатар хотын газрын суурь үнэ нь 8800-13200 төгрөг бөгөөд уг үнийг газрын бүсчлэл, эзэмшил ашиглалтын төрлийг харгалзан засварлах итгэлцүүрээр үржүүлж газрын үндсэн үнийг тогтоодог. итгэлцүүрийг хэрэглэхдээ төвөөс гадагшлах тутам буурах зарчмыг баримтална:

- нийслэл, улсын зэрэглэлтэй хотод 1,0-0,3;
- аймгийн зэрэглэлтэй хотод 1,0-0,5;
- сумдын төв, бусад суурин 1,0-0,6¹².

Гэвч зах зээлийн үнэ ханш нь хотын аль бүсэд хамаарч байгаагаасаа шалтгаалан харилцан адилгүй байна. Тухайлбал инженерийн шугам сүлжээ орсон, хотын төвийн, газруудад газрын үнэ харьцангуй өндөр (зарим мэдээллээс үзвэл 1) хот, тосгон, бусад суурин газрын газрын суурь үнэлгээ, байршил, инженерийн хангамж, нийгэм, эдийн засгийн болон байгаль, экологийн нөхцөлийг харгалзан үзнэ; 2007 оны байдлаар Улаанбаатар хотод 1м² газрын үнэний хамгийн дээд хэмжээ нь 140 000 төг, хамгийн доод хэмжээ нь 2070 төгрөг байсан байна¹³.

Газар зуучилж худалдаалдаг компаниудын талаарх мэдээллийг доорх хаягийн дагуу орж үзэх боломжтой.

- ГХГЗЗГазар: <http://www.e-land.gov.mn/>
- Нийслэлийн газрын алба-1: <http://www.gazar.ub.gov.mn/>
- Нийслэлийн газрын алба-2: <http://www.cityland.mn/>
- Газрын менежментийн үндэсний төв: <http://www.e-gazar.mn/>
- Газрын харилцааны шинэтгэлийг дэмжих төв: <http://www.gazar.org/>

¹¹ Монгол улсын Газрын төлбөрийн тухай хууль, 1997 оны 04 сарын 04, 5-р зүйл,

<http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=1356>

¹² <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?tblenum=&vstart=0&vcount=10&tabclick1=2&vedit=true&vlawaddid=416>

¹³ <http://www.e-gazar.mn/>, Улаанбаатар хотын газрын нөхөн төлбөрийн үнэлгээнд масс үнэлгээг ашиглах боломж “Нормативт үнээс зах зээлийн жишиг үнэ рүү” Доктор Пүрэвцэрэнгийн Мягмарцэрэн МУИС, ГФ

- [Барилга.мн:](#)
- [Нийслэлийн БХБТГазар: http://www.cud.ub.gov.mn/](http://www.cud.ub.gov.mn/)
- [Газрын үндэсний портал](#)
- [Актив зууч](#)
- [Вендо](#)
- [Тэнхлэг зууч](#)
- [Осмо](#)
- [Дельта зууч](#)
- [Номин зууч](#)
- [Торгон зууч](#)
- [Сакура](#)
- [Улаанбаатар зууч](#)
- [Үйлс агентлаг](#)
- [Мастер пропертис](#)
- [Ерөө зууч](#)
- [Айда](#)
- [Фүжи бик](#)
- [Тун зоос](#)
- [Реалтор](#)
- [Монголиан пропертис](#)
- [Му home](#)
- [Экас](#)
- [МЯК](#)
- [Хакуба](#)
- [Ричмонд](#)
- [ҮХХ-ийн ONLINE их дэлгүүр](#)
- [Хөтөч зууч](#)
- [Гүүд зууч- Эрдэнэт](#)
- [Гал голомт](#)
- [Педро Маргинесийн агентлаг](#)
- [Greeno](#)

Барилгын үндсэн материалын үнэ ханш¹⁴

Нэр төрөл		Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Бөөний үнэ
Элс, цемент, тоосго				
1	Хятад цемент 4.25	1тн	112000	110000
2	Эрэл цемент 4.25	1тн	115000	112000
3	Эрэл цемент 4.50	50кг	7250	7250
4	Хөтөл цемент 4.00	50кг	7250	7250
5	Элс	1шуудай	1000	800
6	Элс	1портер	35000	35000

¹⁴ http://www.barilga.mn/index.php?sel=content&menu_id=5

7	Хана материал/тоосго/	1ш	130	
8	Хятад тоосго 80	1ш	155	150
9	Хятад тоосго 108	1ш	160	150
Нэр төрөл		Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Бөөний үнэ

Модны захад зарагдаж буй модон материал

1	Нарсан палк 4м x 15см x 15см	1ш	15000	15000
2	Хар модон палк	1ш	19000	18500
3	Нарсан банз 5см	1 куб	110000	105000
4	Нарсан банз 3см	1 куб	110000	105000
5	Прүс 5 x 5см /9ширхэг/	1боодол	11000	10000
6	Прүс 5 x 7см /6ширхэг/	1боодол	11000	10000
7	Банз /богино/ 2см /20ш/	1м3	85000	83000
8	Банз /богино/ 3см /20ш/	1м3	95000	93000
9	Нарсан Палк	1ш	14000	12000

Хотын ойролцоох газрын зах зээлийн үнийг сонирхож үзвэл, манай аялал жуулчлалын гол бүс нутаг болох Тэрэлжид 1 га газар байршлаасаа хамааран 15-30 сая, Цонжин болдогт мөн байршлаасаа хамааран 5-15 сая төгрөг орчим байна.

Иргэн өмчилсөн хашаа байшиндаа барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барьж байгуулж болох уу? “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн үзэл баримтлалын гол амин сүнс нь иргэд өмчийнхөө газрыг иргэний гүйлгээнд оруулж зохих журмын дагуу банк болон бусад этгээдэд барьцаалж зээл авах, худалдах, түрээслэх, арилжих замаар амьжиргаагаа дээшлүүлэх эрх зүйн боломж олгосонд оршино. Энэхүү боломжийг дээрхи хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7 дахь заалтаар зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, газар өмчлөгч иргэн холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журам, шаардлагад нийцүүлэн өмчийнхөө газарт барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээ барих, түүнийг ашиглах эрхтэй байдаг¹⁵. Түүнчлэн, гэр хорооллын нэг өрхийг төвийн усан хангамжид холбоход 5.6-16.1 сая төгрөг, дулааны шугамд холбоход 2.8-5.6 сая, цахилгаанд холбоход 0.28-0.56 сая төгрөг шаардлагатай гэсэн судалгааны мэдээлэл байна¹⁶.

4.2.3.3 Зээл, мөнгөн тэтгэмж болон бусад хэлбэрийн тусламжууд

Үл хөдлөх хөрөнгө худалдан авахад мөнгөн тэтгэмжийн асуудал байдаггүй. Харин арилжааны банкнуудаас урт, богино хугацаатай зээл авч болно. Тухайлбал: Голомт банк авч буй орон сууцныхаа 30%-ийг төлсөн бол жилийн 17.4%-18%-ийн (сарын 1.45%-1.5%-) хүүтэй зээлийг 15-20 жилийн хугацаатайгаар авах боломжтой. Иргэдээ орон сууцжуулах талаар төрөөс явуулж буй

¹⁵ http://www.gazar.ub.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=327&Itemid=74

¹⁶ <http://gerhoroolol.blog.gogo.mn/read/entry93219>

бодлогын нэг нь төрийн албан хаагчдад зориулсан хөнгөлөлттэй зээл юм. Үүнд эхний ээлжинд 4000 төрийн албан хаагч хамрагдах ба 40 хүртэлх сая төгрөгийг ¹⁷ (2010.03.01-ний байдлаар хугацаа болон хүү нь хараахан тодорхой болоогүй байна.)

Зөвхөн нийслэлд гадаадын зээл тусламжаар 631,4 сая ам.долларын өртөг бүхий 37 төсөл хэрэгжиж байгаагаас хөрөнгө оруулалтын 176,9 сая ам.доллар нь буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа хэлбэрээр, 454,7 сая ам.доллар нь хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгогджээ. Үүний 59 хувь буюу 374,6 сая ам.доллар орон сууц, гэр хорооллын салбарт чиглэж байгаа аж¹⁸. Гэвч эдгээр төслүүдээс хувь хүнд чиглэсэн тусламж маягаар хэрэгжих үйл ажиллагаа байхгүй юм байна. Мөн Азийн хөгжлийн банкнаас гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

4.2.4 Үл хөдлөх хөрөнгө худалдан авах

4.2.4.1 Хууль эрх зүйн орчин, нөхцлүүд

Монгол улсын Үндсэн хуулинд зааснаар хүн бүр хувийн өмчтэй байх эрхтэй бөгөөд эдгээр асуудлыг олон хуулиар зохицуулж өгсөн байдгийн голлох хууль нь эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай¹⁹ хууль юм. Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авахдаа заавал гэрээ байгуулахаар хуульчилсан бөгөөд худалдагч нь газар, барилга, байгууламж байр буюу бусад үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх үүрэг хүлээсэн гэрээ байгуулна. Үл хөдлөх эд хөрөнгө худалдах гэрээ нь заавал бичгийн хэлээр байгуулагдах, үл хөдлөх эд хөрөнгийн эрх шилжүүлэхэд улсын бүртгэлд заавал бүртгүүлэх, хуульд заасан тохиолдолд орон сууцны байр ашиглагчдын өмнөх эрх хадгалагдах зэрэг онцлогтой байна. Мөн доор дурдсан хуулиудаар газрын харилцааг зохицуулна.

1 [АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ \(Шинэчилсэн найруулга\)](#)

2 [БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ](#)

3 [БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ](#)

4 [МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ БАРИЛГЫН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/](#)

5 [ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ](#)

6 [МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ](#)

¹⁷ http://www.postnews.mn/index.php?cp=news&task=view&news_id=5871

¹⁸ <http://gerhoroolol.blog.gogo.mn/read/entry88518>

¹⁹ <http://uhh.mn/news/show/572>

ЖУРМЫН ТУХАЙ

- 7 МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ
- 8 ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
- 9 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ
- 10 ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/
- 11 КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ
- 12 ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ

4.2.4.2 Тодорхой хүмүүст тулгарч болзошгүй бэрхшээлүүд (жишээ нь: ганц бие эмэгтэйчүүд, нийгмийн цөөнх, гэх мэт)

Манай улсад ойролцоогоор 130 мянга гаруй өрх гэр хороололд амьдардаг гэх тооцоо бий. Дээрээс нь жил бүр 5000 гаруй өрх гэр хороололд шинээр суурьшдаг. Учир нь хамгийн хямд өртгөөр орон байртай болох ганц боломж нь энэ байдаг. Засгийн газраас хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр нь арилжааны банкаар дамжиж хувь хүний гар дээр очдог тул хүү өндөртэй, бүрдүүлэх материал олон болдог. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах, орон сууцтай болоход тохиолдож буй бэрхшээл нь зээл авахад барьцаалах хөрөнгө болон сард эргүүлэн төлөх мөнгөний тогтмол, өндөр орлогын эх үүсвэр юм. Ихэнх банк, санхүүгийн байгууллага моргейжийн зээлийг өгөхдөө өрхийн орлогыг өнрдөөр тогтоодог. Гэтэл бодит амьдрал дээр энэ нь ялангуяа ганц бие хүмүүс болон өрхийн орлого багатай хүмүүст ихээхэн хүндрэлтэй. Тухайлбал: орон сууцны зээл авахын тулд өрхийн орлого 800 000 төгрөгнөөс дээш байх, эхний ээлжинд авах байрныхаа үнийн дүнгийн 30%-50%-ийг бэлнээр тушаах г.м шаардлагыг банкууд тавьдаг. Гэтэл өрх толгойлсон, төсвийн байгууллагад үйлчилгээний ажил хийж буй (ТҮ-3-аар цалинжиж буй хүн дунджаар 150 000 орчим төгрөгний цалинтай) өрх толгойлсон, хүүхэдтэй эмэгтэй гэлтгүй жирийн дундаж амьдралтай айл өрхүүд энэ зээлийг авах боломжгүй байгаа юм²⁰.

4.2.4.3 Зах зээлийн ханшийн мэдээлэл

Манай улсын иргэд орон сууц болон уламжлалт гэр хороололд амьдарч байна. Орон сууцны үнэ ханш өндөр байгаагаас дийлэнхи иргэд хямд төсөр гэр хороололд амьдардаг.

Орон сууцны үнийн судалгаа 2009-2-1 ний байдлаар²¹

²⁰ Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 349.1 мянган төгрөг байна. Үндэсний Статистикийн Хороо, http://www.nso.mn/v3/index.php?page=news_more&id=313

²¹ http://www.gazar.org/index.php?module=menu&cmd=content&menu_id=47&id=285

Төвийн хэсэг				
Байршил		1өрөө сая төг	2өрөө сая төг	3өрөө сая төг
Бага тойрог	5 сургууль	38	44	66.5
	4 дэлгүүр	41	53	67
	Засгийн газар	43	60	74
	Их сургууль	42	56	77
1-р 40 мянгат		38	45	63
2-р 40 мянгат	Тоосгон 4 давхар	39	53	68
	Тоосгон 5 давхар	40		73
50 мянгат		37	45	55
11-р хороолол		40	51	73
Хөгжим бүжиг		44	52	67
5р хороолол	Угсармал 5 давхар	47	55	62
	Угсармал 9 давхар	50	65	70
7-х хороолол	Угсармал 5 давхар	32	46.2	66
6-р хороолол	Угсармал 9 давхар	30	55	68
	Угсармал 5 давхар	33	47	65
220 мянгат		44	59	70
Зүүн хэсэг				
Байршил				
13-р хороолол	Хавдар судлалаас хойш	38	63	75
	Хавдар судлалаас урагшаа	38	53	62

12-р хороолол	Сансар тунель орчим	40	43	75
15-р хороолол	15-р хороолол	39	49	53
16-р хороолол	16-р хороолол	47	53	65,3
Байршил		1өрөө	2өрөө	3өрөө
19-р хороолол		31	41	59
19-н нэхмэлийн шар		20	33	42
Баруун хэсэг				
Байршил		1өрөө	2өрөө	3өрөө
2-р хороолол	ТБД андууд	44	48	66
	Угсармал 9 давхар	40	49	70
	25-р эмийн сан	43	46	49
	Ханбүргэдэйн 5 давхар	25,5	45	55
	Богд ар	38	52	55
	Матери импекс орчим	25	42	56
3-р хороолол	Угсармал 5 давхар	28	45	61
	Угсармал 9 давхар	39	44	73
	Угсармал 12 давхар	33	43	70
	Хөгжил хотхон	46	58	63
4-р хороолол	Угсармал 5 давхар	42	54	66
	Угсармал 9 давхар	36,5	43	65
	Угсармал 12 давхар	45,5	56	73
10-р хороолол	Кюүкшүзан	38	56	66
	Угсармал 5 давхар	41	43	65

	Угсармал 9 давхар	40	45	65
	Угсармал 12 давхар	32	52	65
1-р хороолол	Саппоро, Хар хорин 9 давхар	40	49	63
	Угсармал 12 давхар	37	50	60
	Замын урд тал	38	47	65
	12 давхар шинэвтэр	38	50	63
	Драгон	35	52	56
Сот-ын байр		36	46	56
6-р хороолол		37	50	61
5-н шар	Угсармал 5 давхар	34	42	57
	Тоосгон 5 давхар	35	43	60
	5 шар 10 буудал орчмын	22	33	49
21-р хороолол	Угсармал 9 давхар	31	42	57
	Угсармал 5 давхар	31	35	48
	Тоосгон 5 давхар	35	40	53

УБ хотын оршин суугчдын 60 орчим хувь нь гэр хороололд амьдардаг. Гэвч гэр хороололд дэд бүтэц сайн хөгжөөгүйгээс оршин суугчдийн 58 хувь нь нийтийн тээврээр үйлчлүүлдэг ч тэдний ихэнх нь автобусны зогсоолоос сургууль, ажилдаа хүрэхэд 2-8 км явган алхдаг бөгөөд зөөврийн усан хангамжтай, бараг 90% нь түүхий нүүрс түлдэг. Түүнчлэн, гэр хорооллын нэг өрхийг төвийн усан хангамжид холбоход 5.6-16.1 сая төгрөг шаардагдах аж. Харин дулааны шугамд холбоход 2.8-5.6 сая, цахилгаанд холбоход 0.28-0.56 сая төгрөг шаардлагатай. Албан ёсны мэдээгээр бол гэр хорооллын иргэдийн 95 хувийн гэрэл цахилгаанд холбогдсон.²²

Монголын уламжлалт сууц болох гэр худалдан авахад хэмжээ, дулаалга, хамаарч 1 000 000- 2000 000 төгрөг байна. Гэвч гэр нь нүүдлийн ахуйд зориулсан орон сууц учраас бороо, үер, салхи, цас зэрэг байгалийн үзэгдлүүдэд эрсдэл ихтэй.

Харин хувийн хашаа байшин нь гэрийг бодоход илүү тохилог, эрсдэл багатай байдаг. Гэр хороололд хашаа байшин худалдаж авахад байршил болон барилга, газрын хэмжээ, байшингийн

²² <http://gerhorooolol.blog.gogo.mn/read/entry93219>

чанар, материалаас шалтгаалан 6 сая- 30 саяын хооронд үнэ ханштай байна²³. Тухайлбал: модон нэг давхар, банзаар барьж шавардсан байшин хямд бол балкаар барьж тоосгоор өнгөлсөн байшин илүү үнэтэй г.м Мөн автобусны буудал, худаг, сургууль, цэцэрлэг, төв замаасаа хэр ойр байгаагаасаа шалтгаалан үнэ өсч байгаа бол дээрх дэд бүтцээс холдох тутам үнэ нь хямдарч байна. Энгийн засалттай хувийн байшин барихад 18-29 сая төгрөг болж байна.

Үнэ ханштай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг доорхи сайтуудаас орж үзнэ үү.

Осмо: www.osmo.mn Лавлах утас: 1888

Миний гэр : www.myhome.mn

Тэнхлэг зууч www.zuuch.mn

Номин зууч <http://realtor.nomin.net/> 322-677, 9901-3893, 9903-9893, 9905-3893, 9908-3893

Барилга www.barilga.mn

Ерөө зууч www.eruuzuuch.mn

Назу www.nazu.mn

Тунамал www.tunamal.mn

Сакура www.sakura.mn

4.2.4.4 Зээл авах боломж

4.3.1.2 бүлгийг харна уу.

4.2.5 Байр, орон сууц хөлслөх

4.2.5.1 Тодорхой хүмүүст тулгарч болзошгүй бэрхшээлүүд (жишээ нь: ганц бие эмэгтэйчүүд, нийгмийн цөөнх, гэх мэт)

Түрээсийн төлбөр өндрөөс шалтгаалан ганц бие эмэгтэйчүүд, олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хүндрэл учирдаг. Тэд төвийн халаалттай байр хөлсөлж дийлдэггүйгээс захын гэр хороололд гэр, байшин хөлсөлдөг ч өвөл нь түлээ, нүүрсээ авч дулаан өвөлжихөд хэцүү болдог. Дээрх үнэ ханшаар байр, орон сууц хөлслөхөд ганц бие эмэгтэйчүүдэд болон орлого багатай хүмүүст түрээс нь өндөр байдгаас голдуу хотын захад гэр хорооллын хямд үнэтэй хашаа байшин, гэр түрээслэдэг.

Жилийн 6 сард нь халаалт шаарддаг учраас өдөрт олж буй бага зэргийн орлогоо түлшиндээ зарцуулахаас өөр сонголтгүй болдог. Хэдийгээр хотоос алслагдах тутам түрээсийн үнэ бага зэрэг хямдардаг ч нийгмийн суурь үйлчилгээ, дэд бүтцийн асуудал хүндрэлтэй бөгөөд хүүхдээ сургууль, цэцэрлэгт өгөх зэрэгт багагүй төвөг учирдаг. Мөн ажил хийхэд хүүхдүүдээ эзэнгүй орхиж явах, аюулгүй байдал, галын аюул г.м зүйлүүдэд ихээхэн эрсдэлтэй байдаг.

²³ http://1950.mn/www1/index.php?option=com_wrapper&view=wrapper&Itemid=48

4.2.5.2 Зах зээлийн ханшийн мэдээлэл

Ихэвчлэн хувь хүмүүс байр орон сууцаа хөлслүүлдэг учраас тогтсон үнэ ханшгүй, тохиролцох журмаар явадг. Мөн улирлаасаа шалтгаалан үнэ ханш өөрчлөгддөг. Түрээсийн байрны үнэ нь байршил, хэмжээ, чанар болон тавилгатай эсэхээсээ хамааран харилцан адилгүй байна.

Өнөөдөр зах зээлийн ханшаар дотоодын иргэнд 1 өрөө байр 200-300 мянган төгрөгөөр хөлслүүлж багйаа бол 2 өрөө 250-350 3 өрөө 500 хүртэл мянган төгрөгний ханштай байна. Хажуу өрөө байршлаасаа шалтгаалан 120-180 мянган төгрөгний үнэтэй байна. Хөдөө орон нутгаас орж ирсэн иргэд, орлого багатай хүмүүс, оюутнуудын хувьд үнэ ханш арай хямдыг нь бодож хашаа , гэр, эсвэл хашаа байшин хөлслөх сонирхолтой байдаг. Дунджаар хашаа байшингийн үнэ 80 мянган төгрөг байгаа бол, айлын хашаанд суувал 20-50 мянган төгрөгний түрээстэй байна. Үүнээс гадна сүүлийн үед гэр хороолол дунд баригдаж байгаа нийтийн байрны сарын түрээс дунджаар 80-160 мянган төгрөг байна²⁴

4.2.5.3 Мөнгөн тэтгэмж, тусламж

Өрх толгойлсон, олон хүүхэдтэй эцэг, эх, амьдарлын боломжшүй хүмүүс болон байгалийн гамшигт нэрвэгдсэн гэр бүлүүд оршин сууж буй хорооны засаг даргадаа өргөдөл гаргаж гэр хүсэж болно. Гэвч энэ нь тийм ч хурдан шийдэгдэхгүй. Өөр ямар нэгэн мөнгөн тусламж байхгүй.

4.2.6 Дунд хугацаанд амьдрах байр орон сууц (Хамгаалах байр, ТББ, сүм гэх мэт)

Тусгайлсан гэмт хэргийн хохирогчдын буюу гэр бүлийн болон хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод зориулсан хамгаалах байр улсын хэмжээнд 6 ажилладаг. Өөр энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага байхгүй.

4.2.7 Удаан хугацааны байр орон сууцтай болохоос өмнө амьдарч болох түр хугацааны байр орон сууц

Түрээсийн байр, эсвэл ах дүү, хамаатан садныдаа байхаас өөр сонголтгүй. Улсаас үзүүлэх энэ төрлийн ямар нэгэн байр сууц байдаггүй.

²⁴ http://www.mongoltown.com/bbs/?category=767&mid=News&sort_index=regdate&order_type=asc&page=7&document_srl=5279

4.3 Амьжиргаа

4.3.1 Ажлын байр

4.3.1.1 Ажилгүйдэл (албан ба албан бус мэдээлэл салбар болон нийгмийн бүлгээр)

Албан ёсны мэдээллээр ажилгүйдлийн түвшин 2009 оны 4-р улиралд улсын хэмжээнд 12.8 хувь, хотод 16.5 хувь, хөдөөд 7.9 хувьтай байна. Аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (ХХҮХ)-т бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2010 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар 36.0 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 3728 хүнээр буюу 11.6 хувиар нэмэгдсэн байна²⁵.

2009 он гараад Монголын хөдөлмөрийн зах зээл дээр бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өсөх, ашигт малтмал олборлолтын салбарт ажилгүйдэл нэмэгдэх, албан ёсны секторт шинээр ажилд авах нь зогсонги байдалд орох, гадаад улс орон дахь эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан ажиллах хүчний гадаад руу шилжих хөдөлгөөн буурах, ажиллагсад гадаадаас буцаж ирэх, гадаадад ажиллагсдаас ирэх мөнгөн гуйвуулгын хэмжээ багасах байдлаар хямралын нөлөө илэрч байна.

Ажил хайгсдыг боловсролын түвшнээр нь авч үзэхэд 71.4 хувь нь дээд, тусгай дунд, мэргэжлийн анхан шатны болон бүрэн дунд боловсролтой, харин 24.7 хувь нь бүрэн бус дунд, 3.1 хувь нь бага боловсролтой, зөвхөн 0.4 хувь нь боловсролгүй байна. Ихэнх хөгжиж буй орнуудад ажилгүй хүмүүс доогуур боловсролтой буюу боловсролгүй байдаг бол Монгол Улсад боловсролын түвшин ахих тусам ажилгүй байх магадлал өндөр байна. Өөрөөр хэлбэл, хямралын үед дээд болон бүрэн дунд боловсролтой хүн болгон ажилтай байж чадахгүй байна. Гэвч албан бус бүртгэлгүй ажилгүйчүүдийн тоо нь үүнээс бараг 2 дахин их юм. Ялангуяа хөдөө аймаг, сумдын төвүүдэд төрийн хэдэн байгууллагаас өөр ажилтай хүн байхгүй гэж хэлж болохоор байна. 2010 оны 4 сарын эхний байдлаар өнгөрсөн өвлийн зуднаар 6400 өрх огт малгүй болсон²⁶ урьдчилсан мэдээ гарснаас харахад ажилгүйдлийн хувь улам нэмэгдэх хандлагатай байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2010 оны эхний улирлын байдлаар 2.7 мянган хүн 2 төрлийн мэргэжлийн сургалтанд (Зураг 4) хамрагдсаны 52.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Сургалтанд хамрагдсан ажилгүй иргэдийн 9.8 хувь буюу 264 хүн сургалтын дараа ажилд зуучлагдан оржээ²⁷.

4.3.1.2 Хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүд (хамрагдах боломж, нөхцөл)

Хүн амын өсөлт болон ажиллах хүчний мэргэжлийн түвшин доогуур, өрсөлдөх чадвар сул, ажлын үнэлэмж бага зэргээс үүдээд ажилгүйдэл дорвитой буурахгүй байгаа юм. Хэдийгээр ажил олгогч эзэд шинээр ажлын байр бий болгож байгаа хэдий ч тэрхүү ажлын байрыг бүртгэх, мэдээлэх, иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх мэдээллийн ямар нэгэн тогтвортой үйл ажиллагаа явуулдаг сүлжээ байхгүй байгаа. Иймд хүн амын ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хөдөлмөрийн зах зээлийн харилцааг боловсронгуй болгох үндсэн дээр иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор олон төсөл, хөтөлбөрүүдийг улсын хэмжээнд болон нийслэлд хэрэгжүүлж байна.

²⁵ http://www.nso.mn/v3/index.php?page=news_more&id=313

²⁶ <http://www.shuud.mn/index.php?option=news&task=view&id=1111>

²⁷ http://www.nso.mn/v3/index.php?page=news_more&id=333 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо - АХ 03(16)

Засгийн газраас 2010 оныг "Бизнесийн шинэтгэлийн жил" болгон зарласан. Үүний дагуу зээл олгох хуулийг шинэчилсэн бөгөөд барьцаа хөрөнгөгүй зээл олгох асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ. Хөдөө орон нутагт дээд тал нь 50 сая, харин нийслэлд 100 сая төгрөгийн зээл олгох болсон бөгөөд нийт улсын төсвөөс 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг ХААН, Төрийн банк, Хадгаламж, Капитрон, Голомт, Хас банкаар дамжуулан зээлд хамрагдаж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгоно²⁸.

Монгол улсад төрийн хөдөмөр эрхлэлтийн алба 30 гаруй төрийн бус хөдөлмөр эрхлэлтийн алба нилээд олон байна. Төрийн бус хөдөлмөр эрхлэлтийн алба нь хуулийн дагуу лиценцэд үндэслээд хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг явуулдаг,²⁹ Нийслэлийн ЗДТГ-аас жил бүр 20 мянган ажлын байр бий болгох, 35-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалт үйлдвэрлэлийн хоёроос доошгүй төв байгуулж, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 16-35 насны залуучуудыг хамруулж, мэргэжил олгох зэрэг олон зорилтыг хөтөлбөрт тусгажээ. Хөтөлбөрийг НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар эцэслэн баталдаг.³⁰

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн алба ажиллуулж³¹ ажил хайгчдад зориулсан үйлчилгээ, хувийн хэвшлийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, ажлын байрны зарын нэгдсэн сонин www.job1941.mn онлайн хөдөлмөрийн бирж, ажлын зууч-1941 ажлын байрны төрөлжсөн лавлах, ажлын байрны үзэсгэлэн яармаг, хөдөлмөр зуучлалын үйлчилгээг зохион байгуулж байна. Гэвч энэ нь жилд 1-2 удаа л зохион байгуулагддаг учир хүртээмж муутай байдгаас ажил хайгчид ихэвчлэн Зар мэдээ (www.zarmedee.mn, www.zarsonin.mn), Шуурхай зар сонин (www.zar.mn)-гийн заруудад хандаж ажлын зарын дагуу ажлаа олдог. Гэвч энэ нь эргээд баталгаатай ажлын байр болоход хүндрэлтэй бөгөөд ихэвчлэн түр зуурын, баталгаагүй ажлын байр байх нь түгээмэл.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хувьд энэ онд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулж 5.9 тэрбум төгрөгийн зээл олгох аж. Санхүүжилт нь нийслэлийн төсвөөс гарах юм. Мөн зээлийн баталгаанд 2.5 тэрбум төгрөг, лизингийн зээл 750 сая төгрөг тусгасан байна. Ингэхдээ хамгийн дээд тал нь 20 сая төгрөгийн баталгаа гаргаж өгнө. Гэхдээ тухайн зээлдэгч зээлийн барьцааны 40 хувийг гаргах чадвартай байх хэрэгтэй юм.

Хөнгөлөлттэй зээл авахыг хүссэн иргэд төслөө бичиж, НЗДТГ-т өгөх шаардлагатай аж. Ерөнхийдөө банкуудын хувьд төр засаг болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч хөнгөлөлттэй зээл олгож байна. Хөдөө орон нутагт дээд тал нь 50 сая, харин нийслэлд 100 сая төгрөгийн зээл олгох болсон бөгөөд нийт улсын төсвөөс 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг ХААН, Төрийн банк, Хадгаламж, Капитрон, Голомт, Хас банкаар дамжуулан зээлд хамрагдаж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгоно.

²⁸ http://ezuuch.mn/index.php/component/components/com_comment/joscomment/templates/templates/index.php?option=com_content&view=article&id=3154:2010-04-08-11-47-52&catid=62:2009-04-05-11-26-17&Itemid=44

²⁹ [http://notebook.blogmn.net/29964/hudulmuriin-zah-zeeliin-zohitsuulalt-\(lyekts\).html](http://notebook.blogmn.net/29964/hudulmuriin-zah-zeeliin-zohitsuulalt-(lyekts).html)

³⁰ http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=2981&Itemid=31

³¹ http://www.monef.mn/index.php?option=com_content&view=article&id=10:2009-09-05-08-28-13&catid=12:-1941&Itemid=14

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилготой хөнгөлөлттэй зээлийн сарын хүү нь нэг хувь буюу жилдээ 12 хувийн хүү төлнө. Хөнгөлөлттэй зээлийн хувьд эхний нэг жилдээ хүүгээ төлөөд үндсэн төлбөрөө өгөхгүй. Энэ нь бизнес эрхлэгчдэд хөл дээрээ тогтох боломж олгож байгаа юм.

Аймаг дүүргийн төслийг авснаас хойш ажлын тав хоног дотор жижиг дунд үйлдвэрлэлийн газрын мэргэжилтэн, нэг сарын дотор аймгийн болон нийслэл дүүргийн комисс хуралдаж, "Таны төслийг дэмжлээ, эсвэл дэмжигдсэнгүй" гэж хариу өгнө. Яамнаас дэмжигдсэн төсөл банкинд очно.

Тухайн төслийн эзэн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан, үгүйг банк 14 хоногийн дотор хариу өгнө. Өөрөөр хэлбэл зээлдэгчийн барьцаа хөрөнгө зээлийн хэмжээнд хүрэх эсэхийг энэ хугацаанд судалж, шийднэ гэсэн үг³².

Ихэнх банкууд зээл хүсэгчдэд тавьдаг шаардлага, бүрдүүлэх материалууд нь бараг адил, доорх жагсаалтын дагуу байна. Үүнд: Тавигдах шаардлага:

1. Монгол улсын иргэн байх
2. Бизнесийн үйл ажиллагаа тогтвортой эрхэлсэн, эрхлэх гэж байгаа
3. Капитал банк болон бусад банк, банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр, зээлгүй байх
4. Зээлийн хүүгийн төлбөрөө эргүүлэн төлөх чадвартай байх
5. Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх
6. Бусад /Тухайн банкны шаардлагын дагуу/

Бүрдүүлэх материал: Зээл хүсэгч нь иргэн бол дараах баримт материалыг бүрдүүлнэ.

1. Зээл хүссэн өргөдөл / гар өргөдөл/
2. Зээлдэгчийн дэлгэрнгүй анкет /зурагтай /
3. Иргэний үнэмлэх / нотариатаар баталгаажсан хуулбар /
4. Засаг захиргааны тодорхойлолт
5. Барьцаа хөрөнгийн өмчлөгч болохыг нотлох баримт / гэрчилгээ/
6. Барьцаа хөрөнгийн ЭХЭУБГ-н лавлагаа
7. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
8. Өрхийн сарын орлого, зарлагын тооцоо

³² http://ezuuch.mn/index.php?option=com_content&view=article&id=2958:2010-03-20-09-58-19&catid=62:2009-04-05-11-26-17&Itemid=44

9. Зээлийн үр ашгийн тооцоо
10. Зээлийн эргэн төлөлтийн график
11. Зээлийн зарцуулалт
12. Эргэлтийн хөрөнгийн мэдээлэл
13. Цагдаагийн газрын тодорхойлолт
14. Бусад шаардлагатай материал /тухайн банкны шаардлагын дагуу/

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ХӨНГӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ БАНКУУД³³

1. Төрийн банк: Архангай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл.
2. Хас банк: Баянхонгор, Дархан-Уул, Увс, Төв, Өмнөговь.
3. Хадгаламж банк: Завхан, Говь-Алтай, Өвөрхангай, Дорноговь, Дундговь, Орхон.
4. ХААН банк: Булган, Говь-сүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод
5. Капитрон, Улаанбаатар, Голомт банкууд Улаанбаатар хотод тус тус олгоно

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд заасны дагуу “бизнес инкубацийн үйлчилгээ” гэж жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон эрхлэхийг хүссэн иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээний байр, орлоготой болоход нь мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх зэргээр дэмжлэг үзүүлж, аж ахуй эрхлэх таатай орчин бүрдүүлэхийг хэлнэ хэмээн зааж³⁴ одоогоор улсын хэмжээнд бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлдэг 30 төв үйл ажиллагаа явуулж байна.

БИЗНЕС ИНКУБАТОР, БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨВ,

АЖ АХУЙ ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮН³⁵

№	Аймаг, дүүрэг	Бизнес инкубатор төв	Бизнесийн хөгжлийг дэмжих төв	Аж ахуй эрхлэлтийн сургалтын төв
1	Архангай	-	Мэдлэгийн сүлжээ	Хоршооны мэдээлэл сургалтын төв

³³ http://www.sme.gov.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=9&Itemid=10&limitstart=10

³⁴ <http://www.mswl.gov.mn/index.php/mn/2009-05-04-05-54-49/2009-05-04-06-04-56/43-2009-05-03-13-49-47/274-2010-03-17-21-49-36>

³⁵ <http://www.mswl.gov.mn/index.php/mn/news-feeds/dummy-item/2010-02-23-15-30-14/266-2010-02-19-20-16-48>

2	Баян -өлгий	-	Менталика	-
3	Баянхонгор	-	МСҮТ	ХААХ Холбоо
4	Булган	-	МСҮТ	-
5	Говь-алтай	-	Говь Алтай ЖДҮТөв	Эрэмбэ
6	Дорнод	МСҮТ БИТ	-	1. Цэнүж 2. Талын жолоо
7	Дорноговь	-	Говийн хур ТББ БХДТөв	-
8	Дундговь	-	Аясал БХДТөв	-
9	Завхан	Манлай–од БИТ	ЖДҮТөв	Алтан жолооо
10	Өвөрхангай	Өвөрхангай БИТ	-	1. Хархорин 2. Дэлгэрэх бүтээмж
11	Өмнөговь	-	Амжилтын томъёо БХДТөв	-
12	Сүхбаатар	-	ХС БХДТөв	-
13	Сэлэнгэ	-	Туж БХДТ	-
14	Төв	-	Ган-Кавиркат БХДТөв	Эвт ААСТ
15	Увс	Увс МСҮТ БИТ	Тэмүүлэл БХДТөв	Бизнесийн хөтөч
16	Ховд	-	Бат- итгэл БХДТөв	-
17	Хөвсгөл	Хөвсгөл БИТ	-	Бяцхан элч ХХК
18	Хэнтий	-	Өндөрхаан БХДТөв	-
19	Дархан-уул	Дархан БИТ	Дархан ЖДҮТөв	-
20	Орхон	МСҮТ БИТ	Маргад БХДТөв	-
21	Говьсүмбэр		-	МСҮТ ААСТөв
22	Хан- Уул	-	1.Төгс шийдэл 2.Галхиат БХДТөв	1.Хөдөлмөрийн төв бирж 2. ХЭЗСХолбоо ХААЭА
23	Сонгино хайрхан	1.Технож БИТ 2.Сонгинохайрхан ЖДҮТөв	ХААН Банк БХДТ	Хөгжлийн шийдэл
24	Баянгол	Лемур БИТ	1.Монголын хүний нөөц менежментийн холбоо	1.Баянгол сургалтын төв 2.Хөдөлмөр хамгаалал

			2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн БХДТ	хөдөлгөөн ХААЭА
25	Чингэлтэй	Бизнес талант	1.ЖБЭХ БХДТөв 2.ЕУАЗ БХДТөв	1.Футур 2.Улс төр менежментийн сургууль
26	Сүхбаатар	-	1.МАОЭНХолбоо 2. Эм Би Ай Си БХДТөв	1.Нийслэлийн хөдөлмөрийн газар 2.ШУТИС Текс Маш ХХК ХААЭА
27	Баянзүрх	Баянзүрх ЖДҮТөв	Чөлөөт урсгал	Хоршооллын СМТөв
28	Багануур	-	-	Ивээлт зөн ААСТ
29	Багахангай	-	-	-
30	Налайх	-	Налайх МСҮТ	-


4.3.1.3 Ажлын байрны нөхцөл (хамгийн бага/дундаж ажлын хөлс цалин, ажлын цаг, аюулгүй байдал гэх мэт)

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг цагаар тогтооно³⁶ хэмээн хуульчилж Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг цагт 614 төгрөгөөр (сарын 108000 төгрөг) тогтоосон. Энэхүү хэмжээ нь эдийн засаг, нийгмийн байдлаас хамааран өөрчлөгдөнө хэмээн хуульчилсан боловч бараг сүүлийн 10 жилд өөрчлөгдөөгүй. Бүх ажил олгогч, албан байгууллага хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур олгох ёсгүй бөгөөд Засгийн газраас тогтоосон энэхүү журмыг бүх байгууллага дагаж мөрдөх үүрэгтэй. Одоо шинээр боловсруулж буй хуулийн төслөөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ цагийн 640 төгрөг байхаар тооцоолж байна³⁷.

Сарын дундаж цалингийн түвшин улсын хэмжээнд (мянган төгрөгөөр)

³⁶ <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=1469>

³⁷ http://www.ubtimes.mn/index.php?option=com_content&task=view&id=13692&Itemid=126



Эх сурвалж: Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Laborstat тоо баримт. www.ilo.org

Нийслэл дэх албан бус секторт ажиллагсдын сарын дундаж орлогын өөрчлөлт
(мянган төгрөгөөр)

	2009.4	2009.9	2009.12
Гурвалжингийн гүүр	90-210	120-150	90-150
Ачаа тээврийн компаниудын ачаа ачих	240	240-270	180-210
Амгалан дахь Ботаникийн цемент ачих буулгах	240-900	81-87	Мэдэх боломжгүй
Барс зах	150-300	300-450	180-300
Нарантуул зах	150-180	210-240	240-300
100 айлын барилгын материалын зах	150-300	300-450	150-300

Эх сурвалж: Монгол дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газрын тайлан. www.worldbank.org.mn

Ажлын цаг

Монгол улс 1998 оны 1-р сарын 1-ээс эхлэн ажлын таван өдөртэй долоо хоногт шилжсэн билээ³⁸. Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтан өдөрт 8 хүртэл цаг, харин 7 хоногт 40 хүртэл цаг ажиллах ёстой. Ажилтан ажлын цагтаа багтаан ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг хийж гүйцэтгэх үүрэгтэй. Ажилтныг илүү цагаар ажиллуулсан тохиолдолд ажил олгогчоос нэг бол нөхөн амрах, эсвэл илүү ажилласан цагийн хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлж олгох ёстой. Харин бүх нийтээр амрах баярын өдрүүдэд ажилтныг ажиллуулсан бол нөхөн амрах, эсвэл илүү ажилласан цагийн хөлсийг 2.0 дахин нэмэгдүүлэн олгодог. Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллах явдал цөөнгүй байдгаас ямар шалтгаанаар илүү цаг ажиллуулж болох вэ гэдгийг хуульчилж өгсөн байдаг.³⁹

Насанд хүрээгүй хүн (14-15 насны ажилтан 7 хоногт-30 цаг хүртэл, 16-17 насны ажилтан 36 цаг хүртэл), хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн хөхүүл болон жирэмсэн эмэгтэйчүүд, ажлын цагийг нь богиносгосон ажилтнуудын ажлын цагийг нь хорогдуулсан ажлын цагаар бус бүтэн ажилласан цагаар тооцдог. Харин зарим хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд уртасгасан цагаар ажиллуулдаг боловч илүү цагийн хөлсийг тооцож олгодоггүй гэсэн гомдол ажилчдаас их гардаг. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай оёдлын үйлдвэр, тоосгоны үйлдвэр, үйлчилгээний (цайны газар, баар,саун, массажны газар г.м) газруудад энэ байдал түгээмэл тохиолддог.

Ажлын байрны аюулгүй байдал

Ажил олгогч ажилтнуудыг хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллуулах нь тэдний үүрэг бөгөөд хэрэв тэд энэ үүргээ биелүүлээгүйгээс ажилтны эрүүл мэнд, амь нас хохирвол ажил олгогч хууль зүйн хариуцлага хүлээдэг⁴⁰.

Хэвийн бус нөхцөлд буюу хүнд, хортой, халуун, газар доорхи нөхцөлд ажиллаж байгаагаас хамаарч ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, нэмэгдэл амралт болон бусад баталгаагаар хангагдах ёстой⁴¹ байдаг.

Хэдийгээр Монгол улс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг⁴² зааж өгсөн ч өнөөдрийг хүртэл олон салбарт, тэр дотроо барилга, уул уурхай, замын салбарт ажилладаг компаниуд үүнийг биелүлдэггүйгээс олон арван хүн эрүүл мэнд, амь насаараа хохирч байна. Ялангуяа уул уурхай, барилга болон жижиг компаниуд, хувийн аж ахуйн нэгжүүд дээр аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал алдагдаж, үйлдвэрлэлийн ослоуд гарах явдал их байдаг. Жилээс жилд үйлдвэрлэлийн ослоор амь насаа алдаж байгаа хүмүүсийн тоо буурахгүй, нэмэгдэх хандлагатай байгааг мэргэжлийн байгууллагууд анхааруулдаг.

4.3.1.4 Түр/цагийн ажлын байр

Монголд ажлын байрны энэ систем муу байдаг. хүн бүр л цагийн ажил хийхийг хүсдэг ч тэр бүр байдаггүй нь гол асуудал болоод байгаа билээ. Энэ төрлийн ажлын байр нь залуучууд, оюутнуудад

³⁸ <http://www.mswl.gov.mn/index.php/mn/2009-05-04-05-54-49/2009-05-04-06-04-56/43-2009-05-03-13-49-47/280-2010-03-17-23-50-23>

³⁹ http://www.e-hutuch.gov.mn/index.php?pageID=15&mid=38&sel_news=312

⁴⁰ http://www.e-hutuch.gov.mn/index.php?pageID=15&mid=38&sel_news=317

⁴¹ http://www.e-hutuch.gov.mn/index.php?pageID=15&mid=38&sel_news=318

⁴² <http://www.mswl.gov.mn/index.php/mn/component/content/article/20--/118-law-osh>

их хэрэгцээтэй байгаа талаар байнга асуудал гардаг. Гэвч хааяа нэг кампанит ажил маягаар цөөн тооны цагийн ажил гардаг ч тэр нь маш богино хугацаанд хэрэгжээд дуусдаг, жижиг төсөл хэлбэрээр байдаг тул түр ажил хайгчдын эрэлтийг хангаж чаддаггүй. Тухайлбал: Нийслэлийн хөдөлмөрийн бирж оюутан залуусыг цагийн ажлаар хангах хөтөлбөр хэрэгжүүлээд 900 орчим оюутныг түр ажлын байраар хангажээ. Гэвч энэхүү төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж нь зүгээс оюутанд олгосон цалингийнхаа 50 хувийг хөтөлбөрийн сангаас нөхөн авах юм. Өнөөдрийн байдлаар 40 орчим албан байгууллага, аж ахуй нэгжтэй Нийслэлийн хөдөлмөрийн газар хамтран ажиллах гэрээ байгуулжээ.⁴³ Гэвч эдгээр ажлууд нь төсөл хөтөлбөр хэлбэрээр богино хугацаатай хэрэгжээд өнгөрдөг тул тогтвортой байдлаа хадгалж чаддаггүй.

Харин бусад цагийн ажил хийхийг хүссэн хүмүүст тохиолдлын чанартай, кампанит ажил хэлбэрээр зохион байгуулагддаг цэвэрлэгээ, суваг шуудуу ухах зэрэг ажлаас өөр зохион байгуулалттайгаар хийх тогтвортой түр цагийн ажил байхгүй байна.

4.3.1.5 Зарим мэргэжлийн дутмаг байдал (өндөр эрэлт)

Эрчимтэй хөгжиж байгаа уул уурхай, барилгын салбарт шинэ үеийн мэргэжлийн өндөр ур чадвартай дотоодын ажиллах хүчний хомсдол, тэдгээрийг бэлтгэх мэргэжил, техникийн бааз байхгүйгаас тухайн орон зайг гадаадаас ажиллах хүчин, мэргэжилтэн авч нөхөж байгаа нь гал унтраах төдий болж, үндэсний мэргэжилтнүүдийг бэлтгэх, дадлагажуулж чадваржуулах, ур чадвар, шинэ техник технологийг эзэмшиж, тогтвортойгоор үйл ажиллагаа явуулахад төрийн цогц бодлого дутагдаж байгааг харж болох юм. Засгийн газар болон уул уурхай, барилга, замын томоохон компаниудын мэдэгдэж байгаагаар монголд энэ төрлийн нарийн мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна гэж үзсэн. Тухайлбал: давхар зам тавих мэргэжилтэй ажилтан, нарийн төмөр зам тавих мэргэжилтэй ажилтан, газрын тос олборлох газрын гүний өрөмдлөг дээр⁴⁴ ажиллах мэргэжилтэн, барилгын нарийн мэргэжлийн инженерүүд, техникийн ажилтнууд болон барилга, уул уурхайн салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай байна хэмээн 2010 онд гадаадаас 2396 ажилчин авахаар Засгийн газраас тогтоол гаргасан⁴⁵. Гадаадаас авч буй ажиллах хүчний тоо нь жилээс жилд буурч, харин Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд чухал шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудын тоо хоёр дахин нэмэгдэж байгаа ч хангалттай хэмжээний үзүүлэлт биш юм. Зөвхөн 2007 онд 79 орны нийт 18504 гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосны 75 хувийг техникийн анхан болон дунд шатны мэргэжлийн ажилчид эзэлжээ⁴⁶. Хөдөлмөр эрхлэж байгаа гадаадын иргэдийг эдийн засгийн салбараар авч үзвэл: Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарт 8209 буюу 44.4 хувь, барилгын салбарт 3963 буюу 21.4 хувь, боловсруулах үйлдвэрийн салбарт 1765 буюу 9.5 хувь, боловсролын салбарт 746 буюу 4.0 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагааны салбарт 1006 буюу 5.4 хувь нь тус тус ажиллаж байсан байна.

⁴³ <http://news.gogo.mn/r/59335>

⁴⁴ <http://news.tulakh.mn/?p=50424>

⁴⁵ <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vprinttxt=true&vlawid=59275>

⁴⁶ <http://www.zaluuchuud.com/zaluusiin-bolobsrol/--.html>

Хөдөө аж ахуйн салбарт өндөр ашиг шимтэй мал сонгон үржүүлэх чадварлаг мал зүйч, сайн агрономич, эзэмшсэн техниктээ эзэн болдог механикжуулагчид эрэлт ихтэй байна⁴⁷. Мөн хүүхдийн эмч дутагдалтай байгаа талаар эрүүл мэндийн яамнаас мэдээлсэн.

4.3.1.6 Холбогдох мэдээлэл (Ажил зуучлалын албад, сонин сэтгүүл гэх мэт)

Ажил эрхлэлтийг дэмжих талаар төрөөс олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсээс гадна ажилгүй иргэдийг дүүргүүдийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс болон зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн хөдөлмөр зуучлалын албадаар дамжуулан бүртгэж ажилд зуучлан оруулж байна.

Жижиг Дунд Үйлдвэрийг Дэмжих Газрын салбаруудын хаяг

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар

Засгийн газрын 11-р байр 2 давхар Бага тойруу Улаанбаатар-15170,

Чингэлтэй дүүрэг Монгол улс

Утас: 976-51-261569, 262534,266272,266413,262453

Факс: 976-11-320918

Жижиг Дунд Үйлдвэрийг Дэмжих Сонгинохайрхан төв

<u>Утас:</u> Төвийн захирал	99099401, 70186273.
Төвийн багш	96004417, 96686947.
Төвийн ня-бо	99086855,70186272.
Төвийн жижүүр	70186274

Е-мэйл: info@jdu.mn

Хаяг: Сонгинохайрхан дүүрэг 15-р хороо, 1-р хороололын арын зам дагуу байрлах “Өнөр-хорооллын гудамж-54” өөрийн байр

Завхан төв

Завхан аймаг, Улиастай сум, Жинст баг, өөрийн байр,

Утас: 01462221999, 0146222168,

Факс: 01462-22199,

Е-mail: gundsambuu_za@yahoo.com

⁴⁷ http://www.dornod.biz/index.php?option=com_content&view=article&id=1898%3A2010-03-12-16-14-15&Itemid=56

Дүүргүүдийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсүүдийн утасны дугаар, хаяг:

Багануур дүүрэг⁴⁸

Нэрс	№	Албан тушаал	утас	e-mail
Т. Отгонболд	1	Дарга	22322	Otgoo_hu@yahoo.com
Ц.Отгонжаргал	2	Ахлах мэргэжилтэн	22161	Otgoo_en@yahoo.com
Б.Мягмарчимэд	3	Аж ахуйн нярав	22315	
Г.Гантуяа	4	ХЭДСан, үйл ажиллагааны ня-бо	21883	Gantuya_gotov@yahoo.com
Д. Сарантуяа	5	Халамжийн сан хариуцсан мэргэжилтэн	21883	Dashka_saraa@yahoo.com
Т.Саранчимэг	6	Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн	22551	Dsubd_99@yahoo.com
Ж.Балжмаа	7	Халамж хариуцсан мэргэжилтэн	22551	Baljmaa_j@yahoo.com
П.Занабазар	8	Хөдөлмөр эрхлэлт сургалт хариуцсан эргэжилтэн	22551	zanaa_san@yahoo.com
Д.Одмандах	9	Хүн ам гэр бүлийн асуудал хариуцсан эргэжилтэн	22551	odmandahd@yahoo.com
Д. Төгсгэрэл	10	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэд хариуцсан мэргэжилтэн	22551	tugsuu82@yahoo.com
С.Болортуяа	11	1, 2-р хороо хариуцсан мэргэжилтэн	20568	Suu_boolo@yahoo.com
Т.Нансалмаа	12	3-р хороо хариуцсан мэргэжилтэн	22105	Nansan01@yahoo.com
П.Үзмээ	13	4-р хороо хариуцсан мэргэжилтэн	22654	Uzmee0214@yahoo.com
М.Нарантуяа	14	Архив, бичиг хэрэг, даргын туслах	22325	Bn_baigal@yahoo.com
Жижүүр		22316		

Хан-Уул дүүрэг

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөл

⁴⁸ http://baganuur.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=16&Itemid=27&limitstart=5

№	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Д.Ганбаатар	Зөвлөлийн нарийн бичгийн дарга	344477-822
2	Б.Гэрэлмаа	Жижиг зээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	344477

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс⁴⁹

№	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Б.Бадамсүрэн	Хэлтсийн дарга	345153
2	Н.Ганбат	Мэргэжилтэн	
3	Х.Оюунбилэг	мэргэжилтэн	342590
4	Д.Энхтуяа	Нягтлан бодогч	344366
5	Г.Энхтуяа	Ахлах мэргэжилтэн	344366
6	Х.Пүрэвдорж	Ажилгүйдлийн бүртгэл, зуучлалын мэргэжилтэн	344366

Сонгино хайрхан дүүрэг Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс⁵⁰

№	Нэр	Албан тушаал	Утас
1	С.Чойноров	Хэлтсийн дарга	634405
2	Г.Маамуу	Ахлах мэргэжилтэн	63371
3		Ахлах мэргэжилтэн	631733
4	Г.Нарантуяа	Мэргэжилтэн	633141
5	Ж.Сүрэнжав	Мэргэжилтэн	633141

Сүхбаатар дүүрэг⁵¹

Нэр	Албан тушаал	Утасны дугаар
М.Оюунчимэг	Хөдөлмөр, халамж, үйлчилгээний дарга	350577

⁴⁹ http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=259&Itemid=168

⁵⁰ http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=334&Itemid=211

⁵¹ http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=214&Itemid=157

*Чингэлтэй дүүрэг*⁵²

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс :

Утас – 50880190

Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга:

Утас - 312717

Хаяг, байршил: 6-р хороо өөрийн байр, 5-р сургуулийн ард

*Багахангай дүүрэг*⁵³

Д/д	Овог нэр	Албан тушаал	Холбогдох утас
1	О. Содовжамц	Хэлтсийн дарга	99092685
2	Б. Баярсайхан	Ахлах мэргэжилтэн	99245477
3	Ц. Мягмарсүрэн	Нягтлан бодогч	99237643
4	Ж. Энхтуул	Мэргэжилтэн	99722803
5	Ч. Нина	Нярав	99147703
6	Ж. Чулуунаа	Сувилагч	99849262
7	Б. Хишигдулам	Тогооч	99735374
8	Д. Мөнхбат	Жолооч	99736742

*Баянгол дүүрэг*⁵⁴

№	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Д.Золжаргал	ХХҮХэлтсийн дарга	77330707
2	Д.Зоригт	Дэд дарга	77330708

⁵² <http://daatgal.mn/pages/directory>

⁵³ http://bagakhangai.ub.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=98:2009-08-13-10-33-25&catid=92:2009-08-13-09-26-13&Itemid=122

⁵⁴ <http://www.bgd.mn/index.php?action=menudata&id=68>

3		Даргын туслах	77330707
4	Д.Дэлгэрбат	Хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	77330710
5	Г.Энхтуул	Бичиг хэрэг архивын эрхлэгч	
6	Э.Уянга	Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан	70125781
7	Р.Нямжав	Мэргэжилтэн	77330709
8	М.Отгонбаяр	Мэргэжилтэн	77330705

Налайх дүүрэг

№	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Н.Мөнхцэцэг	Хөдөлмөр эрхлэлт, халамж, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан зохион байгуулагч	23442 22522
2	Э.Пүрэв-Очир	Жижиг, дунд үйлдвэр, нийтийн болон ахуйн үйлчилгээ хариуцсан зохион байгуулагч	23562 22414

Зөвшөөрөл бүхий хувийн Хөдөлмөр зуучлалын албадын хаяг:⁵⁵

Нийслэл:

1.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн алба

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44а, 410 тоот Утас: 318896, 325635

2.

Жий ХХК-ны ХЗА

Хаяг: Рокмон цогцолбор, 1006 тоот Утас: 324351, 331309

3.

Гэр санаачлага

⁵⁵ http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=593

Утас: 462236, 99780505

4. _____
Си Эй Эм Эл ХХК-ны ХЗА
Утас: 314039, 99098093
5. _____
Хангал Бумбат ХХК-ны ХЗА
Хаяг: Сүхбаатар дүүрэг, СТӨ, 11 давхар, 1107 тоот Утас: 312157, 99148344
6. _____
Ариуннаяд ХХК-ны ХЗА
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 45-р байр Утас: 99246079
7. _____
Монголын оюутны хөдөлмөрийн бирж
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 34-р байр Утас: 315111, 99121657
8. _____
Бат алтан боломж ХЗТөв
Хаяг: Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Аэрогеодезийн байр Утас: 99857596, 96674553
9. _____
Хамтын хүч ХЗТөв
Хаяг: Баянгол дүүрэг, 4-р хороо, Монгол түлхүүр компанийн байр Утас: 687565, 99248815
10. _____
Лейбор Маркет ХЗА
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу, Барилгын биржийн 201 тоот Утас: 353316, 353366
11. _____
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ХЗА
Хаяг: Баянгол дүүрэг, 2-р хороо, 26-р байр Утас: 99152896, 242819
12. _____
Барилгын салбарын ХЗА
Хаяг: Чингэлтэй дүүрэг, Урт цагаан Утас: 99123448, 99855040
13. _____
Гартаам ХЗТөв
Хаяг: Чингэлтэй дүүрэг, марс худалдааны төв, 4 давхар Утас: 329340, 319293
14. _____
Ирмүүн ХЗТөв

Хаяг: Баянгол дүүрэг, 9-р хороо, 3-р хороолол, Дархан плаза-308 тоот Утас: 99120917, 361796

15. Хүний нөөцийн ундарга ХЗА

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Итгэлт орших төв, 504 тоот Утас: 331298

16. Кареер март ХЗА

Хаяг: Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол, 39-23

17. Монгол Гарц ХЗА

Утас: 330622, 99612626

18. Хөдөлмөр хамгаалал хөдөлгөөний дэргэдэх ХЗА

Хаяг: Баянгол дүүрэг, 17-р хороо, дорно Дахины гүн ухаан судлалын ДС-ын байр Утас: 91169439, 99695224

19. Алтан аяга ХЗА

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Онол ДС-ын байр Утас: 96006008

20. Тидиси ХЗА

Хаяг: Сүхбаатар дүүрэг, ШУМТ-ийн 114 тоот Утас: 96671389

21. Азтай алхам ХЗА

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, УБ банк Утас: 88810081

22. Боломж ХЗА

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, 9-р байр, 34 тоот Утас: 682653, 91994886

<http://www.egov.mn/Web.aspx?Page=Labor%20market&Lang=mn-MN> Бүртгэлтэй хувийн хөдөлмөр зуучлалын албадын танилцуулга

Орон нутагт:

№.	Нэр	Хаяг	Утас	Факс
1.	<u>Хөдөлмөр зохицуулалтын алба</u>	Татварын хэлтэс, 7-р баг Найрамдлын хороо, Цагдаагийн хэлтсийн дэргэд байр, 0 тоот	22637	

2.	<u>Монболд</u>	2-р хороо, Төмөрчний гудамж, Энхтайван найрамдалын ордон байр, 4 тоот		
3.	<u>Хөдөлмөр зохицуулалтын алба</u>	Баруун-Урт, Шарга, сумын төвд байр, 204 тоот	414	246
4.	<u>Барилгачин залуучуудын хөдөлгө</u>	14-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, 15-р х-л 64 байр, 37 тоот	459878 91913229	
5.	<u>Хөдөлмөр эрхлэлтийн алба</u>	1-р хороо, Нацагдоржийн гудамж, тамгын газрын байр байр, 236 тоот тоот	21127 22322	
6.	<u>Хөдөлмөр эрхлэлтийн алба</u>	Аймгийн төвлөрсөн, Ховд гол, сумын төв байр, өөрийн байранд тоот	2/22/1947	
7.	<u>Хөдөлмөр эрхлэлтийн алба</u>	Сайншанд, 2-р баг / Сайншанд /, ЗДТГ-ын төв байр байр, 0 тоот	3132 99261441	200
8.	<u>Баянтэгш импекс</u>	1-р хороо, Хувьсгалчдын өргөн чөлөө, Хишигдэлгэрэх ХХК-ийн байр байр, 0 тоот		
9.	<u>Хөдөлмөр эрхлэлтийн алба</u>	Сүмбэр, 2-р баг / Сүмбэр/, Аймгийн ЗДТГ-ын байр байр, 0 тоот		
10.	<u>ЧД ХЗАлба</u>	4-р хороо, Баруун сэлбэ гудамж, 0 байр, 0 тоот		
11.	<u>Хөдөлмөр НХВГ газар</u>	4-р хороо, Сүхбаатарын гудамж, дээд шvvх ард талд байр, 0 тоот	327906 324321	
12.	<u>Хөдөлмөр эрхлэлт алба СБД</u>	6-р хороо, Сүхбаатарын гудамж, ЗДТГ азрын байр, өөрийн байр тоот	324233	
13.	<u>VЭ-ийн холбоо</u>	Аймгийн төв, Алтайн хороо, VЭ-ийн байр байр, өөрийн байранд тоот	24933	
14.	<u>Шинэчлэл 21 зуун</u>	2-р хороо, Их тойруу, аэрогеодезийн УВГ байр, 402 тоот	99259940	
15.	<u>Инакссес</u>	3-р хороо, 19-р хороолол, 22 байр, 3 тоот	95152058	
16.	<u>Хиромэ</u>	Бусад, Хандгайт, оргил худалдааны төв байр, 0 тоот	315788 99171025	
17.	<u>Хөдөлмөр эрхлэлтийн алба</u>	Даланзадгад, Далан баг, НХVT-ийн байранд байр, 0 тоот		
18.	<u>Монголын Ургамал Хамгаалалт</u>	5-р хороо, Төмөрчний гудамж, усны бодлогын хврээлэн байр, 0 тоот	326970	
19.	<u>Хөдөлмөр эрхлэгчийн алба</u>	Зуунмод, Номт / 1-р баг Зуунмод/, ЗДТГ азрын байр байр, 0 тоот	22350	
20.	<u>Хvмvvn сан</u>	5-р хороо, Баруун сэлбэ гудамж, 13 байр, 10 тоот	312322	976- 312322

40.	<u>Санхам</u>	4-р хороо, Бага тойруу, БЗТЦВТ байр, 0 тоот		
41.	<u>Ги Жи Би</u>	6-р хороо, 6-р хороолол, 40 байр, 0 тоот		
42.	<u>Бугат трейд</u>	Улаангом, 7-р баг Найрамдлын хороо, Даатгал компаний байр байр, 0 тоот		

http://www.lavlav.mn/modules.php?name=Company&op=list_item&query=&searchtype=contains&cid=21&&perpage=30&pg=2

www.ezar.mn/

www.zarsonin.mn/

www.mongolnews.mn/

www.mea.mn/

www.niielmiintoli.mn/

www.dailynews.mn/

www.zar.aalz.mn/

www.dandaa.mn/

www.dornod.biz/

www.darkhanbiz.mn/

www.unegui.mn/

www.zarmedee.mn/

Лавлах утаснууд

1616	Сонгодог лавлах
1617	УВ лавлах
1891	Шар утас
1902	Шинэ долгион 107,5-н шидэт утас
1904	Мэдээлэл лавлагаа, зар сурталчилгааны үйлчилгээ
1907	Орон сууцны талаарх мэдээлэл лавлагаа

1910	FM зар мэдээ
1911	Барилгын лавлагаа
1916	Мэдээлэл лавлагаа:
1923	Бизнесийн мэдээлэл, лавлагаа:
1926	Алсын хараатай лавлах
1927	Мөрөөдлийн утас
1932	Миний лавлах
1939	Сити лавлах
1941	Ажлын зууч:
1948	Тожоо
1950	Бүх төрлийн мэдээлэл, лавлагаа
1960	Мастер зууч
1962	Санхүүгийн лавлах
1984	Оллоо мэдээлэл лавлагаа

4.3.2 Гадаадын улс оронд эзэмшсэн мэргэжлийн зэргүүдийг үнэлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг газруудын мэдээлэл, холбогдох мэдээлэл

Энэ талаар манай улсад ямар нэгэн үйлчилгээ үзүүлдэггүй юм байна. Харин саяхан хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч буй өндөр боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн Монгол Улсын иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах болон хилийн чанадаас мэдлэг, туршлага, боломжоо улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх асуудалд чиглүүлэн ажиллах эрх зүй, эдийн засгийн таатай нөхцлийг бүрдүүлэх замаар эх орны хөгжил, бүтээн байгуулалтад хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийг татан оролцуулах зорилго бүхий “Зөгийн үүр” хөтөлбөрийн төслийг Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос боловсруулан хэлэлцүүлж байгаа нь нааштай үр дүнгээ өгнө гэж үзэж байна. Хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ЗГХЭГ, холбогдох яамд, их сургуулиуд болон ТББ-ууд, гадаадад төгсөгчдийн холбоод зэрэг олон талын төлөөллүүд ажилласан⁵⁶.

⁵⁶ http://www.ndic.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=161%3A2010-05-25-06-42-36&catid=50%3A20&Itemid=137&lang=mn

4.3.3 Боловсрол ба мэргэжил дээшлүүлэх, дахин үргэлжлүүлэх мэдээллүүд (хамрагдах боломж, үнэ өртөг)

4.3.3.1 Төрийн, засгийн газрын

Өөрийн эх орондоо боловсрол, мэргэжлээ ахиулан суралцах, мэргэжлийн дагуу тодорхой чиглэл сонгон авч үргэжлүүлэх, судалгаа хийх, өдөр, оройн, эчнээ ангиар баклавр, магистр, докторантурт суралцах замаар мэргэших, боловсролын зэргээ ахиулах боломж бүрэн нээлттэй байдаг. 2009-2010 онд манай улсад 146⁵⁷ (115 нь Улаанбаатарт, 31 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна) их дээд сургууль, коллежид 164773 оюутан суралцаж байна. Нийт оюутнуудын 80 орчим хувь нь хувийн зардлаар, үлдэх хэсэг нь төрийн сангийн зээл болон төрөөс үзүүлэх буцалтгүй тусламжаар суралцдаг. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ төрийн өмчийн сургуульд 587.4, төрийн бус өмчийн сургуульд 629.8 мянган төгрөг байна⁵⁸.

Харин гадаад улсад Засгийн газрын тэтгэлгээр эсвэл түүний шугамаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн дагуу чиглэсэн зорилготойгоор зохион байгуулдаг мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдах, хамтын ажиллагаатай гадаад орнуудын холбогдох сургуулиудад солилцооны журмаар очиж мэргэжил дээшлүүлэх өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулиудад суралцан боловсролын зэргээ ахиулах боломжтой. Гадаад орны Засгийн газар, олон улсын байгууллагын тэтгэлгээр суралцах хувьсгийг хоёр талын гэрээ, хэлэлцээрт заасан нөхцлийн дагуу сонгон шалгаруулж элсвүлдэг. Энэ шугамаар жил бүр гадаадын 10 гаруй оронд (БНЧУ, Герман, Япон, БНСУ, БНХАУ, Турк улс, Лаос, ОХУ, Кипр, Украин, Словак, Польш, Вьетнам, Казастан, Унгар, Энэтхэг, Австри, Нидерланд зэрэг) хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу оюутан суралцуулахаар илгээж байна.

Суралцуулах орон, мэргэжлийн чиглэл, хувийн тоо, бүрдүүлэх бичиг баримт, шалгалтын хуваарь, сонгон шалгаруулах нөхцлийг жил бүрийн эхний хагас жилд багтаан шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” гэх мэт өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарладаг. Шалгалтын тухай зарлалыг мөн БСШУЯ-ны үүдний самбар болон <http://www.mecs.gov.mn> сайтын “зар мэдээ”, “мэдээлэл” гэсэн хэсгүүдээс унших болон хэвлэн авч болно. Сонгон шалгаруулалт ихэвчлэн 1-6 сард явагддаг⁵⁹. Хоёр улсын Засгийн газар болон яамд хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу магистрантур, докторантурт суралцуулах сонгон шалгаруулалтад тухайн зарлагдсан мэргэжлийн чиглэлийн дагуу бакалавр /докторантурт бүртгүүлэх хувьсцаг магистраас доошгүй/-аас доошгүй боловсролтой /сургалтын голч дүн нь 3,25-аас доошгүй байна/, мэргэжлээрээ 2 ба түүнээс жил ажилласан, судалгаа шинжилгээний ажлын дадлага, туршлагатай, гадаадад суралцах хэлний бэлтгэлтэй хувьсгийг оруулдаг.

4.3.3.2 Хувийн хэвшлийн

⁵⁷ http://www.mecs.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=331&Itemid=113

⁵⁸ http://www.mecs.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=331&Itemid=113

⁵⁹ http://www.education.mn/index.php?option=com_content&task=view&id=17&Itemid=27

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод тодорхойлсноор боловсрол ба мэргэжил дээшлүүлэх, дахин үргэлжлүүлэхэд төр хувийн хэвшилтэй хамтран ажиллана гэж заасан⁶⁰. Гэхдээ энэ ажил одоо дөнгөж эхлэлийн шатандаа явж байна⁶¹. Харин хувиараа төлбөрөө төлөөд явахыг хүсэгчдэд зориулсан гадаад улсад хэлний сургалтууд, баклавр, магистр, докторын шатны сургалтанд зуучилдаг хувийн хэвшлийн компаниуд олон байдаг боловч эдгээр БСШУЯ-наас зөвшөөрөл олгодоггүй. Тиймээс түүнд тавих хяналтын тогтолцоо байхгүйгээс суралцагчдаас зуучлалын өндөр төлбөр авах, хөрөнгийн барьцаа шаардах, анх тохиролцсон сургууль нь өөрчлөгдөх зэрэг хүндрэлүүд гардаг. Гэвч одоогоор үүнийг зохицуулах ямар нэгэн зохицуулалт хийгдээгүй байна.

4.3.3.3 Олон улсын байгууллагын эсвэл ТББ-үүдийн

Олон улсын байгууллагууд жил бүр өөрсдийн тусгай шалгуурын дагуу төрийн байгууллагын ажилтнуудыг дахин мэргэшүүлэх, мэргэжлийн зэргийг нэмэгдүүлэх чиглэлээр тэтгэлгүүд зарладаг. Тухайлбал Японы JDS⁶² хөтөлбөр 2011-2012 оны хичээлийн жилд төрийн албанд 2 жилээс дээш ажилласан ажилтнуудад зориулсан магистрын тэтгэлэг, чадавхийг бэхжүүлэх, жижиг үйл ажиллагааг дэмжих Монгол-Австралийн зорилтот хөтөлбөрийн газар⁶³ төрийн бус байгууллагын ажилтнуудад зориулсан магистрын тэтгэлэг зарладаг. Харин ТББ-ууд болон олон улсын байгууллагаас тогтмол, байнгын чанартай биш сургалтууд мэргэжлийн сонгогдсон бүлгүүдэд зориулан явуулдаг. Гэхдээ энэ сургалтууд нь ихэвчлэн албан байгууллагуудын захиалгаар ажиллагсдад нь зориулан явуулдаг тул бусад хүмүүс хамрагдах боломжгүй байдаг.

4.3.4 Шинэ бизнес эхлэх, эрхлэх

4.3.4.1 Хууль эрх зүйн орчин, нөхцлүүд (Улсын бүртгэл, компанийн дүрэм журам, маягтууд, хөрөнгийн доод хэмжээ гэх мэт)

Монгол улсын иргэд өөрийн улсын нутаг дэвсгэрт шинээр бизнес эхлэхэд хууль эрхзүйн орчныг бүрэн бүрэлдүүлж өгсөн байдаг. Үүнд Хязгаарлагдмал хувьцаат компани, нөхөрлөл, хоршоо, Үүсгэн байгуулж буй аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээс шалтгаалахгүйгээр бүх төрлийн хариуцлагын хэлбэрийн аж ахуйн нэгжүүд доорхи материалуудыг нийтлэг бүрдүүлнэ. Үүнд:

Аж ахуйн нэгж байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх бичиг баримт⁶⁴

Үүнд:

1. Нэрийн сонголтын баталгаажуулалт – Улсын бүртгэлийн албанд хандаж, өөрсдийн сонгосон оноосон нэр нь улсын хэмжээнд давхардаж буй эсэхийг шалгуулан, давхардаагүй

⁶⁰ www.mongolembassy.org/MDG-based-NDS.doc

⁶¹ <http://bolovsrol.dayar.mn/ncvet>

⁶² <http://shuud.mn/index.php?option=news&task=view&id=7009&PHPSESSID=359f931e812806ae7b744ad203f6ff66>

⁶³ www.cabsaf.mn

⁶⁴ <http://www.egov.mn/Web.aspx?PageID=512>

тохиолдолд баталгаажуулна. Хэрэв давхардсан бол өөр оноосон нэрийн хувилбар гарган шалгуулна.

2. Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бол холбогдох байгууллагаас авсан зөвшөөрөл – Аж ахуйн нэгжийн эрхлэх гэж буй үйлдвэрлэл, үйлчилгээ нь «Тусгай зөвшөөрөл шаардагдах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн тухай хууль» -д тусгай зөвшөөрөл авахаар заасан бол хуульд заасны дагуу холбогдох байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.
3. Улсын бүртгэлийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт – Аж ахуйн нэгж байрлах нутаг дэвсгэрийн орон нутгийн төсвийн орлогын дансанд «Тэмдэгтийн хураамжийн тухай хууль» -д заасны дагуу компани, нөхөрлөл 10000 төгрөг, хоршоо 6000 төгрөг, банк, даатгалын байгууллага 20000 төгрөг, улс төрийн нам, олон нийтийн байгууллага 10000 төгрөг тус тус тушаана.
4. *Эхлэлтийн тайлан тэнцэл* – Аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулж буй хөрөнгийн нэр, төрлийг балансын дансуудад харуулсан «эхлэлтийн тайлан тэнцэл» -ийг гаргана.
5. Аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулах өргөдлийн маягт –Тус маягтыг Улсын бүртгэлийн албанаас авч, 2 хувь үйлдэнэ.
6. Үүсгэн байгуулагчдын анкет – Анкетийн маягтыг Улсын бүртгэлийн албанаас авч болох бөгөөд анкетанд зургаа наасан байна. Түүнчлэн анкетанд иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана.
7. Байрны түрээсийн гэрээ –Аж ахуй нэгжийн оршин байрлаж буй хаягийг баталсан бичиг баримт болгож байрны түрээсийн гэрээг хавсаргана.

Түүнээс гадна: Үүсгэн байгуулж буй аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээс шалтгаалан дараахь материалуудыг нэмж бүрдүүлнэ.

Үүнд:

Хоршооны хувьд:

1. Бүх гишүүдийн хурлын протокол
2. Хоршооны дүрэм

Нөхөрлөлийн хувьд:

1. Нотариатаар баталгаажуулсан үүсгэн байгуулах гэрээ / Нөхөрлөл компани тухай хуулийн 20-р зүйлийн 2 дахь хэсэг, 28-р зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу/
2. Гишүүдээс тухайн нөхөрлөлд оруулсан хөрөнгийн талаар холбогдох байгууллагаас гаргуулсан баталгаа.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд:

1. Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл (УБ-03) (3 хувь, гарын үсгийн хэв маягийг нотариатаар гэрчлүүлсэн байна)
2. Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас (УБ-09)
3. Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр (2 хувь)
4. Хуулийн этгээдийн дүрэм (гэрээ) (2 хувь) /Компанийн тухай хуулийн 16-р зүйлд заасны дагуу/
5. Хуулийн этгээдийн харилцах данс нээсэн тухай мэдэгдэл (УБ-10)
6. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх бол эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар

7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
8. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн анкет (2 хувь)
9. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч нарын иргэний үнэмлэхийн, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын хуулбар (2 хувь)
10. Эхлэлтийн тайлан тэнцэл (3 хувь)
11. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг бүртгэх өдөр түүний өөрийн хөрөнгө нь нэг сая төгрөг ба түүнээс дээш байна⁶⁵.
12. Харьяалагдах татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн тодорхойлолт (ТБ-04)
13. Бусад холбогдох баримт бичиг (хөрөнгийн жагсаалт, бэлэн мөнгө тушаасан баримт, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар гэх мэт)
14. Баримт бичгийг хийж хадгалах, архивын шаардлага хангасан хавтас (1 ширхэг)
15. Гишүүдээс тухайн компанид оруулсан хөрөнгийн талаар холбогдох байгууллагаас гаргуулсан баталгаа
16. Дүрмийн санд хөрөнгө хүлээн авсан тухай гишүүдийн үйлдсэн акт
17. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьд ГХОГХА-ын даргын тушаал болон сертификатын хуулбар

Хувьцаат компанийн хувьд:

1. Үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр (тогтоол, протокол)
2. Хувьцааг нийтэд санал болгож худалдахыг зөвшөөрсөн Үнэт цаасны хорооны тогтоол
3. Компанийн нотариатаар баталгаажуулсан дүрэм / Компанийн тухай хуулийн 16-р зүйлд заасны дагуу/.
4. Хувьцааны төлбөрийг эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийж байгаа бол эдгээр зүйлийн үнэн зөвийг тодорхойлсон шинжээчийн дүгнэлт
5. Ерөнхий захирал болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн анкет
6. Хувьцааны захиалга дүрмийн сангийн төлөвлөсөн хэмжээгээр бүрэн хийгдсэн тухай хөрөнгийн биржийн тодорхойлолт. Хувьцааны тархалтын мэдээ.
7. Хувьцааны төлбөр хийгдсэн баримт.
8. Хувьцаат компанийг бүртгэх өдөр түүний өөрийн хөрөнгө нь 10 сая төгрөг ба түүнээс дээш байна⁶⁶.

Мөн бусад зохицуулалтыг компанийн тухай хуулиас⁶⁷ дэлгэрүүлэн авах боломжтой.



4.3.4.2 Зээл, мөнгөн тэтгэмж тусламжууд, хамрагдах боломж (хүүгийн хэмжээ, зээлдүүлэгчид гэх мэт)

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төрөөс болон олон улсын хандивлагч байгууллагуудаас олон арга хэмжээг авч байна. 2005 онд “Жижиг, дунд үйлдвэрийг

⁶⁵ http://www.cgdc.org.mn/mongolian/index.php?option=com_content&view=article&id=12%3A2010-04-27-08-11-31&catid=8%3Acompanylaw&Itemid=5&limitstart=3

⁶⁶ http://www.cgdc.org.mn/mongolian/index.php?option=com_content&view=article&id=12%3A2010-04-27-08-11-31&catid=8%3Acompanylaw&Itemid=5&limitstart=3

⁶⁷ http://www.citizenmongolia.com/index.php?option=com_content&view=article&id=223%3A2009-06-27-18-18-13&catid=76%3A2009-06-23-12-44-30&Itemid=273&lang=mn

дэмжих хөтөлбөр” батлаж⁶⁸, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжүүдийг бий болсон. Энэ хөтөлбөрийн хүрээнд 2009 оныг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих жил болгон төрөөс 30.8 тэрбум төгрөгийг жилийн 12%-ийн хүүтэй, 3 жилийн хугацаатай арилжааны банкуудаар дамжуулан олгож байна.

Тухайлбал:

1. Төрийн банк: Архангай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл.
2. Хас банк: Баянхонгор, Дархан-Уул, Увс, Төв, Өмнөговь.
3. Хадгаламж банк:Завхан, Говь-Алтай, Өвөрхангай, Дорноговь, Дундговь, Орхон.
4. ХААН банк: Булган, Говь-сүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод
5. Капитрон, Улаанбаатар, Голомт банкууд Улаанбаатар хотод тус тус олгоно.

Иргэд энэ хөтөлбөрт хамрагдахын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хүссэн төслүүдийг хүлээн авах хугацааг хэвлэл мэдээллээр олон нийтэд нээлттэй мэдэгдсэн хугацаанд⁶⁹ сум, дүүрэг, аймгийн “Төсөл сонгон шалгаруулах комисс”-г төслөө илгээнэ.

Үүнээс бусад тохиолдолд арилжааны бүх банкууд бизнесийн олон төрлийн зээлийг сарын 1.6%-3.1%-ийн хүүтэй (жилийн 19.2%-37.2%) зээлдүүлдэг. Гэвч энэ нь хүү өндөртэй, барьцаа шаарддаг, хугацаа богино байдгаас бизнес эрхлэгчдэд хүндрэлтэй байдаг. Зээлийн талаархи мэдээллийг http://www.mba.mn/mon_membership.php сайтаас авна уу.

4.3.5 Нийгмийн хамгаалал

Нийгмийн хамгааллын тогтолцооны гол зорилго нь өвчлөх, өтлөх, осолдох, гэмтэх, ядуурах, орлогогүйдэх зэрэг хүмүүний амьдралын нийгмийн шинжтэй эрсдлээс ард иргэдийг хамгаалах үүргийг нийгмийн өмнөөс гүйцэтгэх⁷⁰, төрийн нийгмийн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар иргэдийн амжиргааны доод түвшингийн баталгааг хангах, хүн ам зүй, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт гэх мэт төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх гэсэн гурван үндсэн үүргийг нийгмийн хамгааллын систем гүйцэтгэдэг. Манай улсын хувьд:⁷¹

- Нийгмийн даатгал
- Нийгмийн халамж
- Нийгмийн бодлого дахь хамгааллын асуудлууд гэсэн гурван түвшинд хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын хувьд аль болохоор бүх нийтийг хамарсан, нээлттэй байх зарчим үйлчилдэг. Харин одоо нийгмийн халамжийн чиглэлээр 5 хууль хэрэгжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, тэжээгчээ алдсаны, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж, бүтэн өнчин хүүхдийг асрамжилсны г.м олон төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Дээрх асуудалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны www.mswl.gov.mn сайтаас авна уу.

⁶⁸ http://www.sme.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=11:2009-11-10-15-47-07&catid=4:2009-11-10-13-56-08&Itemid=5

⁶⁹ http://www.sme.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=90:2010-02-23-09-03-47&catid=4:2009-11-10-13-56-08&Itemid=5

⁷⁰ http://www.open.government.mn/index.php?option=com_weblinks&catid=37&Itemid=69

⁷¹ <http://www.finance-mongolia.com/archives/86>

4.3.5.1 Ажилгүйдлийн тэтгэмж, хамрагдах боломж

1997 оны 1 сараас эхлэн ажилгүйдлийн тэтгэмжийг⁷² олгож эхэлсэн.

Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд төлсөн, түүний дотор сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд оршин суугаа газрынхаа хөдөлмөр эрхлэлтийн албанаас авах эрхтэй.

Ажилгүй болсон даатгуулагч ажлаас халагдсаны дараа 14 хоногийн дотор хөдөлмөр эрхлэлтийн алба (ажилтан)-нд доорхи баримт, бичгийн хамт бүртгүүлнэ. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийн алба (ажилтан)-ны маягтын дагуу гаргасан өргөдөл;
2. Баталгаажсан нийгмийн даатгалын дэвтэр (сар бүрийн шимтгэл төлөлтийг нийгмийн даатгалын улсын байцаагчаар баталгаажуулсан, ажилд авсан болон халагдсан тушаал бичигдсэн, тамга тэмдгээр баталгаажсан, шилжилт хөдөлгөөн хийгдсэн);
3. Ажлаас халсан тухай шийдвэр зэргийг бүрдүүлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмжийг:

- Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын орлогын дунджаас дараах хувиар бодож олгоно

Шимтгэл төлж ажилласан хугацаа /жилээр/	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	45
5-10 хүртэл жил	50
10-15 хүртэл жил	60
15 ба түүнээс дээш жил	70

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг оршин суугаа газрынхаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс /ХХУХ/ эсвэл нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.

4.3.5.2 Өвчлөл, группын тэтгэмж, хамрагдах боломж

⁷² <http://www.ndaatgal.mn/content.php?mid=1&file=address11-5>

Сүүлийн үед монголын нийгэмд гарч буй нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн нөлөөгөөр хүн амын өвчлөл болон нас баралтын бүтцэд өөрчлөлт гарч байна. Тухайлбал сүүлийн 10 жилийн өмнөх үетэй харьцуулахад зүрх судасны өвчлөл 2 дахин нэмэгдэж, хорт хавдраар өвчлөгсдийн 84% нь хожуу оношлуулснаас эмчилгээ авч чадахгүй байна. Монголын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгаан болж буй цусны даралт ихсэх, зүрхний шигдээс, тархины цус харвалт, чихрийн шижин, элэг, ходоод, улаан хоолой, умайн хүзүүний болон хөхний хорт хавдар өвчнүүд байна. Мөн халдварт болон амьсгалын замын, бөөр шээсний замын өвчлөлүүд улирлын байдалтайгаар нэмэгддэг. Судлаач эмч нарын мэдэгдэж байгаагаар сүүлийн жилүүдэд хорт хавдраар өвчлөгсдийн нас залуужиж, хүрээ нь улам тэлж байгаа болон осол гэмтэлд өртөгсдийн тоо мөн өсч байгаа.

Групп, тэтгэмж: Хүндээр өвчилж хөдөлмөр эрхлэх чадвараа түр болон бүрмөсөн алдсан бол ажил мэргэжлийн нөхцөл байдлаас шалтгаалж эрүүл мэндээ алдсан болон ердийн өвчнүүдээр гэж хоёр ангилан групп тогтоодог. Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн чадвараа 70%-аас дээш алдсан иргэдэд халамжийн тэтгэмж олгодог. Мөн өвчлөлийн зэрэг, гэр бүлийн орлогын байдлаас шалтгаалан тухайн хүнд:

- протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслэлийн хангамж;
- сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт;
- эх орны рашаан сувиллын зардлын хөнгөлөлт зэргийг үзүүлдэг.

Группэд орохын тулд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношлогоо хийлгэсэн оношин дээрээ тулгуурлан мэргэжлийн эмч нарын зөвлөгөөний хурлаар орж шийдвэрлэдэг.

4.3.5.3 Гэр бүлийн тэтгэлэг, хамрагдах боломж

Нийгмийн халамжийн хуулинд заасны дагуу амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно. Үүнд:⁷³

- гурав хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа;
- байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа;
- гурав ба түүнээс дээш тооны бага насны хүүхэдтэй /14 хүртэлх насны/ өрх толгойлсон эх /эцэг/-д жилд нэг удаа;
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд болон гэнэтийн аюул, ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлж нэг удаа олгоно.

Мөн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж дараахь төрөлтэй байна.

- амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж;
- орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт
- халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт;

Нийгмийн халамжийн хуулиар нөхцөлт мөнгөн тэтгэмжийг ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд, “Эхийн алдар”

⁷³ <http://legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=6216>

нэгдүгээр (8 буюу түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд 100 000 төг), эсхүл хоёрдугаар (5-7 хүүхэд төрүүлж өсгөсөн ээжид 50 000 төг) зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламж, эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам олгох тэтгэмж олгодог⁷⁴.

Гэр бүлийг дэмжих зорилгоор төрөөс шинэ гэр бүлд зориулсан мөнгөн тусламжийг (500 000 төг) анх гэр бүл болж буй залуу гэр бүлүүдэд зориулан нэг удаа олгож байсан боловч энэ жил түр зогсоогоод байна. Өөр нийт гэр бүлийг дэмжсэн тэтгэлэг одоогоор байхгүй.

4.3.5.4 Нийгмийн хамгааллын тогтолцоонд хэрэгждэг бусад тэтгэлэг, тэтгэмж

Нийгмийн хамгааллын тогтолцоонд хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авах эрхтэй байдаг. Нийгмийн хамгааллын тогтолцооны хамгийн том бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг нь нийгмийн даатгал⁷⁵ юм. Хэрэв нийгмийн даатгалын тухай хуульд заасан болзол, журмын дагуу тэтгэмжийн даатгалд шимтгэл төлж даатгуулсан бол уг сангаас дор дурдсан тэтгэмжийг авах эрх эдэлнэ

Даатгалын хэлбэр	Заавал даатгуулах	Сайн дураар даатгуулах
Даатгуулагч иргэн	<ul style="list-style-type: none"> - Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, - Төрийн албан хаагчид - Аж ахуйн нэгж байгууллагын болон иргэний малыг тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу маллаж байгаа малчин 	<ul style="list-style-type: none"> - Заавал даатгагдсанаас бусад хувиараа хөдөлмөр эрхлэх замаар ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, эзэд - Чөлөөт уран бүтээлчид - Хувийн аж ахуйтан малчид, тариаланчид - Хоршооны гишүүд - Лам санваартангууд гэх мэт
Шимтгэлийн хэмжээ	Хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын 1.0 хувиар шимтгэл төлнө / Үүнээс: 0,5 хувийг даатгуулагч өөрөө, 0,5 хувийг ажил олгогч хариуцан төлнө /	Хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлогын 1.0 хувиар шимтгэл төлнө.

⁷⁴ <http://legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=6216>

⁷⁵ <http://www.ndaatgal.mn/content.php?mid=1&file=address11-2>

Хаана, хэнд хандах	Тухайн байгууллагын нягтлан бодогч , санхүүгийн ажилтанд	Харьяа нутаг дэвсгэрийн Нийгмийн даатгалын байгууллагын байцаагчид
<ul style="list-style-type: none"> • <i>Та тэтгэмжийн даатгалд даатгуулсанаар :</i> <ul style="list-style-type: none"> - <i>Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж</i> - <i>Жирэмсний болон амаржсаны тэтгэмж</i> - <i>Оршуулгын тэтгэмж авах эрхтэй</i> 		

Мөн жирэмсэн болон амаржсан эхчүүдэд олгох тэтгэмж байдаг. Эх жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам тэтгэмж авах эрхтэй бөгөөд хэрэв эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.⁷⁶ Даатгуулагч жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сарын хугацаанд даатгалын шимтгэл төлсөн, үүнээс сүүлийн 6 сард нь дээрх шимтгэлийг тасралтгүй төлсөн тохиолдолд жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах боломжтой.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг:

- Заавал даатгуулагч эхэд шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 100 хувь тооцож 4 сарын хугацаанд
- Сайн дураар даатгуулагч эхэд шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 70 хувь тооцож 4 сарын хугацаанд олгоно.

Бүрдүүлэх материал:

- Нийгмийн даатгалын дэвтэр
- Эмнэлгийн хуудас

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ердийн өвчнөөр өвчилж, эсвэл ахуйн осолд орж хөдөлмөрийн чадвараа түр алдахаас өмнө 3 сар буюу түүнээс дээш хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэлээ төлсөн, хүүхдээ жирэмсний 7 сар хүртэл хугацаанд тээж дутуу төрүүлсэн, эсвэл үр хөндүүлсэн хүмүүст олгоно.

Шимтгэл төлж ажилласан жил	Тэтгэмж бодох хувь
5 хүртэлх жил	50%
5 — 14 жил	55%
15 ба түүнээс дээш жил	75%

⁷⁶ <http://legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=6216>

Бүрдүүлэх материал:

- Нийгмийн даатгалын дэвтэр
- Эмнэлгийн хуудас

Оршуулгын тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч ердийн евчин, ахуйн ослын улмаас нас барсан тохиолдолд оршуулгын тэтгэмж 148,500 төгрөгийг олгоно. Харин даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно.

Бүрдүүлэх материал:

- Нас барсан даатгуулагчийн хөдөлмөрийн дэвтэр
- Нас барсан даатгуулагчийн даатгалын дэвтэр
- Нас барсны гэрчилгээ
- Өргөдөл

4.3.5.5 Буцаж ирж буй хүмүүст зориулсан онцгой тусламж, тэтгэмжүүд

Энэ төрлийн үйлчилгээ байхгүй.

4.3.6 Олон нийтэд үйлчилгээ тусламж үзүүлдэг хандив тусламжийн байгууллага (үйлчилгээ, холбогдох мэдээлэл)⁷⁷

Одоогоор олон нийтэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг газарт христийн янз бүрийн урсгалын сүмүүд голлох байр суурийг эзэлж байна. Харин төрийн байгууллагаас авч болох тусламжийн талаар дээрх бүлгүүдэд дурдсан байгаа. Төрийн байгууллагын тусламжийн дийлэнхи нь нэг удаагийн бадаг тул анхан шатны туслалцааг ихэвчлэн сүмээр дамжин олж авдаг.

Мөн олон улсын байгууллагууд олон нийт рүү чиглэсэн үйлчилгээг төрийн байгууллагатай хамтарсан, эсвэл ТББ-тай хамтарсан хэлбэрээр зохион байгуулдаг.

4.3.7 Амьдралын өртгийг тооцоолох зах зээлийн үнийн ханш (бензин тосны үнэ, өргөн хэрэглээний хоол хүнсний материалууд г.м)

⁷⁷ Тодорхой салбарт тусламж үзүүлдэг хандив тусламжийн байгууллагын мэдээлэл 5-р хэсэгт бий

Зах зээлийн үнэ ханшийн талаарх мэдээллийг сар бүр үндэсний статистикийн хорооноос тооцон гаргадаг⁷⁸. Дээрх мэдээллээс харрахад хүнсний барааны үнэ улирлын байдлаас шалтгаалан тогтмол өөрчлөгддөг бөгөөд ялангуяа жил бүрийн 2-р сараас хойш (цагаан сарын дараа) махны үнэ, 7—р сараас хойш гурилын үнэ нэмэгддэг. Жил бүр мах, гурилын үнэ нэмэгдсэнээр хүнсний гол нэрийн (сүү, будаа, элсэн чихэр, ургамлын тос, өндөг г.м) болон өргөн хэрэглээний барааны үнэ дагаж өсөн, тогтворгүй байдалтай байдаг.

Манай улс дотоодынхоо хэрэгцээний шатахууны 90 гаруй хувийг ОХУ, 10 гаруй хувийг БНХАУ-аас авдаг. Сар бүрийн төгсгөлд ОХУ-ын Роснефть компаниас ирдэг үнийн саналаас хамаарч дотоодын зах зээл дэх шатахууны үнэ хэлбэлздэг. Одоогийн байдлаар⁷⁹ Улаанбаатар хотод 5 шатахуун түгээх станцаар (Жаст ойл, Петровис, Магнай трейд, Сод монгол, Шунхлай) АИ-95 бензин 1420 төг, АИ-76, 80 бензин 1160 төг, АИ-92,93 бензин 1350 төг, Дизель түлш 1280 төгрөгний үнэ ханштай байгаа бол Юнигазад газ 1060 төгрөгний үнэтэй байна. Харин орон нутгуудад УБ хотоос хэр алслагдсан байдлаас шалтгаалан дээрх үнэ 25-185 төгрөгөөр нэмэгдэж очдог.

Аймаг	АИ-80	АИ-92	Дизель түлш
Архангай	1225	1455	1405
Баян-Өлгий	1300	1500	1400
Баянхонгор	1265	1465	1435
Булган	1220	1405	1340
Говь-Алтай	1330	1500	1420
Дорноговь	1390	1480	1420
Дорнод	1320	1430	1400
Дундговь	1270	1400	1340
Завхан	1280	1480	1450
Өвөрхангай	1245	1445	1415
Өмнөговь	1355	1465	1465
Сүхбаатар	1310	1440	1400
Сэлэнгэ	1200	1395	1315

⁷⁸ <http://www.nso.mn/v3/>

⁷⁹ 2010 оны 07 сарын 28-ны байдлаар

Төв	1195	1385	1305
Увс	1170	1480	1350
Ховд	1330	1480	1420
Хөвсгөл	1230	1400	1350
Хэнтий	1210	1400	1330
Дархан	1190	1380	1300
Орхон	1205	1405	1325
Говьсүмбэр	1280	1380	1340

*Эх үүсвэр: ҮСХ-ны мэдээ, 2010 оны 07 сарын 28

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.nso.mn/v3/files/UNE100728.pdf> сайтаас авна уу.

4.4 Эрүүл мэнд

4.4.1 Бүс нутгаар хүн амын эрүүл мэндийн байдал (халдварт өвчин, тахал г.м)

Манай улсын хүн амын дунд өвчлөл, ялангуяа халдварт өвчнөөр өвчлөх явдал багагүй хувьтай байдаг. 2008 онд улсын хэмжээнд 33 төрлийн цочмог халдварт өвчний 43793 тохиолдол бүртгэгдсэн.

2008 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчнүүдийн 40.0 % бэлгийн замаар дамжих халдвар, 24.0% вирүст гепатит, 9.0 % сүрьеэ, 8.0 % гэдэсний халдварт өвчнүүд, 8.0 % гар, хөл, амны өвчин, 7.0 %-ийг амьсгалын замын халдварууд эзэлж байна.

2008 онд цочмог халдварт өвчний шалтгаант нас баралтын 165 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 23 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт нас баралтын 64.0% сүрьеэ, 16.0% вирүст гепатит, 7.0%-ийг менингококкт халдварын шалтгаант нас баралт эзэлж байна.

Гэдэсний халдвар: 2008 онд улсын хэмжээнд вируст гепатит А, цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллын халдвар, балнад, суулгалт халдвар, гар хөл амны өвчин зэрэг 7 төрлийн гэдэсний халдварт өвчний 15945 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 36.4%-ийг эзэлж байна. Гэдэсний замын халдварт өвчний 58.3%-ийг вируст гепатит А, 20.1%-ийг гар хөл амны өвчин, 14.7%-ийг цусан суулга, 5.2%-ийг хүнсний гаралтай бактерт хордлого, 1.3%-ийг сальмонеллэз, 0.2%-ийг суулгалт халдвар, 0.03%-ийг балнад тус тус эзэлж байна.

Вируст гепатит: Улсын хэмжээнд вируст гепатит өвчний 10404 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 23,7%-ийг эзэлж, өмнөх оноос 375 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт вируст гепатитын өвчлөлийн 89.9%-ийг вируст гепатит А, 8,7% вируст гепатит В, 1,4 %-ийг вируст гепатит С тус тус эзэлж байна. Вируст гепатит өвчнийг нийгмийн байдлаар авч үзвэл өвчлөгсдийн 38.0 % сурагчид, 21.9 % цэцэрлэгийн хүүхэд, 21.6 % гэрийн хүүхэд, 5.4 % ажилгүйчүүд, 4.6 %-ийг оюутнууд тус тус эзэлж байна.

Вируст гепатит А өвчнөөр 2-9 насны хүүхдүүд, вируст гепатит В өвчнөөр 15-29, вируст гепатит С 20-44 насны хүмүүс зонхилон өвчилж байна.

Цусан суулга: Бүртгэгдсэн нийт халдварт өвчний 5.3 хувь, гэдэсний халдварт өвчний 14.7 хувийг цусан суулга өвчин эзэлж, өвчлөлд 0-4 насны хүүхдүүд илүүтэй өртсөн байна.

Хүнсний гаралтай бактерт хордлого: Дээрх хугацаанд нийт 838 тохиолдол бүртгэгдсэн.

Гар, хөл, амны өвчин: 2008 оны 5 дугаар сард Монгол улсад гар, хөл, амны өвчний анхны тохиолдол илэрч, улмаар, улсын хэмжээнд нийт гар, хөл, амны өвчний 3210 тохиолдол бүртгэгдэж, өвчлөгсдийн 83.5% (2680 тохиолдол)-ийг 0-9 насны хүүхдүүд эзэлж байна.

Амьсгалын замын цочмог халдвар: Амьсгалын замын 9 төрлийн цочмог халдварт өвчний 7299 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 16.7%- ийг эзэлж, өвчлөлийн дотор сүрьеэ (57.8%), салхинцэцэг (28.2%), гахай хавдар (7.7%) -ын халдвар зонхилох хувийг эзэлж байна.

Сүрьеэ: Монгол улсад сүрьеэ өвчний илрүүлэлт, эмчилгээний чанар сайжирч, нас баралтын түвшин буурч байгаа боловч өвчлөлийн түвшин нэмэгдэж байна.

Сүрьеэ өвчин нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын амьжиргааны түвшинтэй шууд хамааралтай байдаг. Манай орны хувьд 1990-ээд оноос эхэлсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үр дагаварууд болох инфляци, ажилгүйдэл, ядуурал, шилжилт хөдөлгөөн зэрэг нь уг өвчний тархалтад нөлөөлж байна. ДЭМБ-ын судалгаагаар Номхон Далайн Баруун бүсэд багтдаг сүрьеэгийн өвчлөл өндөртэй 7 орны 3 дугаарт Монгол улс орж байна. Сүрьеэгээр өвчлөгсдийн 71.0 хувь нь 15-49 насны хөдөлмөрийн насны хүмүүс байгаа бөгөөд хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд 53.0 хувь, эмэгтэйчүүд 47.0 хувийг эзэлж байна.

Гахай хавдар: Улсын хэмжээнд 2008 онд гахайн хавдрын өвчлөлийн нийт 560 тохиолдол бүртгэгдэж, өвчлөлд 0-19 насныхан илүүтэй өртөн, үүнээс 66.8 хувь нь сурагчдын дунд зонхилон тохиолдож байна.

Салхин цэцэг: Улсын хэмжээнд 2008 онд салхин цэцэг өвчний өвчлөл нийт 2061 тохиолдол бүртгэгдсэн.

Бэлгийн замаар дамжих халдвар: БЗДХалдварт өвчний 17648 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 40.3 %-ийг эзэлж, өнгөрсөн онтой харьцуулахад 5419 тохиолдлоор ихэссэн байна. БЗДХ-ын дотор трихомониаз 36.9%, заг хүйтэн 34.8%, тэмбүү 28.2 %-ийг тус тус эзэлж байна.

2008 онд жирэмсэн эмэгтэйчүүдэд хийсэн 69059 үзлэгийн дүнгээс үзвэл тэмбүү 1137(1.6 %), заг хүйтэн 564(0.8%), трихомониаз 1062(1.5%) тус тус илэрсэн байна⁸⁰.

Монгол улсын нийт хүн амын дундах Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), дархлалын олдмол хомсдол (ДОХ)-ын тархалтын түвшин 1.0 хувиас бага байгаа нь зүүн Ази, Номхон далайн бусад зарим орнуудтай харьцуулбал ХДХВ, ДОХ-ын тархалт багатай 5 улс орны тоонд багтдаг хэдий ч ХДХВ-ын бүртгэгдсэн тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна. ХДХВ-ын халдварын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэн бөгөөд 2010 оны байдлаар нийт халдвар авсан 76 тохиолдол бүртгэгдээд байна. Бүртгэгдсэн бүх тохиолдол бэлгийн замаар халдварлагдсан нь тогтоогдсон байна⁸¹. ХДХВ/ДОХ-той хүмүүсийн 82.0 хувь нь эрэгтэйчүүд, 18.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Халдвар тээгч эрэгтэйчүүдийн 84% нь гей, эмэгтэйчүүдийн 55% нь биеэ үнэлэгч байна⁸².

⁸⁰ <http://www.doh.gov.mn/images/pdf/sma/uzuulelt/2008mng.pdf>

⁸¹ <http://www.shuud.mn/index.php?option=news&task=view&id=6935&PHPSESSID=383047e3d177c3bf21d30f06d9fa66ec>

⁸² <http://www.eruulmend.info/component/content/article/57-2010-03-25-14-36-47/157-doh.html>

4.4.2 Бүс нутгуудын ундны ус, эрүүл ахуй, халаалтын систем (шаардлагатай бол)

Монгол улс цэвэр усны нөөцөөрөө дэлхийд дээгүүр ордог ч манай орны цэвэр усны нөөц ойрын жилүүдэд багасч байгаа нь хүний зохисгүй үйлдэлтэй холбоотой. Манай орны хувьд усны бохирдол бага байснаас ихэнхдээ байгалийн гол мөрөн, гүний усыг ууж хэрэглэдэг. Гэвч ой модыг их хэмжээгээр огтлон гүний усны нөөцийг багасгаж байгаагийн зэрэгцээ уул уурхайн салбар албан, албан бус байдлаар эрс нэмэгдсэнээр орон нутгуудын гол, мөрөн ширгэх, бохирдох явдал нэмэгдсээр байна. Монгол Улсад нийтдээ 5097 гол горхи, 9582 булаг шанд бүртгэгдсэнээс, 372 гол горхи, 1158 булаг шанд ширгэсэн дүн гарчээ. Үүнээс шалтгаалан хөдөөгийн малчид, иргэдэд ундны усны асуудал хомсдолд орж эхлээд байна.

Монгол жилийн дөрвөн улиралтай бөгөөд бараг 8 сарын туршид халаалт хэрэглэдэг. Халаалтын системийн хувьд нийслэл Улаанбаатар хотод байрлах орон сууцнууд төвийн дулааны системтэй, харин орон нуаг, гэр хороолол, амины сууцнууд хувийн халаалтын системтэй. Энгийн галлагаа буюу түүхий нүүрс, модыг голчлон хэрэглэдэг. Сүүлийн жилүүдэд утаагүй түлш, шахмал түлшийг хэрэглэж агаарын бохирдол бууруулахыг төрөөс бодлогоор дэмжиж байгаа боловч үнэ өндөр, халаалтын чанар муу зэргээс шалтгаалан түүхий нүүрсний хэрэглээ өндөр хэвээр байна. Үүнээс шалтгаалан өвөлдөө утааны асуудал тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэхүү утаанаас шалтгаалан агаар дахь хүхэрлэг хий, азотын хий нь байх хэмжээнээс даруй 3-4 дахин их болж гамшгийн хэмжээнд хүрдэг⁸³.

Улаанбаатар хотын хөрсний бохирдолт 95 хувь буюу байх ёстой хэмжээнээсээ 10-16 дахин их буюу дөрөвдүгээр зэргийн бохирдолттой байна гэсэн дүгнэлт гарчээ.

4.4.3 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо (сэтгэцийн халамж үйлчилгээ орно)

Засгийн газрын харьяанд Эрүүл мэндийн яам нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог хариуцан ажилладаг.

2000 онд батлагдсан сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулиар⁸⁴ хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, сэтгэцийн өвчтэй буюу сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүн эмнэлэг, нийгэм, сэтгэл зүйн тусламж авах нөхцөлийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх үүрэг, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

Сэтгэцийн халамж үйлчилгээний хувьд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах иргэдэд төрөлжсөн халамжийн үйлчилгээ үзүүлэх⁸⁵ болон эрүүл мэндийн үйлчилгээ, группын мөнгө зэргийг олгохоор хуульчилсан байна.

4.4.3.1 Эрүүл мэндийн дэд бүтэц бүс нутгаар (эмнэлэг, тоног төхөөрөмж г.м)

⁸³ <http://galuu.com/24tsag/2007/02/27/5567>

⁸⁴ <http://eruul-mend.dayar.mn/news/show/603>

⁸⁵ <http://legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=6216>

Эрүүл мэндийн яам эмнэлэг болон түүнд ажиллагсдын асуудлыг хариуцан ажилладаг⁸⁶. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдийг 1, 2, 3-р шатлалын дагуу үйлчилгээ, эмчилгээ үзүүлэхээр зохион байгуулсан байдаг.

1-р шатлалын эмнэлэгт өрхийн, сумын зэрэг анхдагч үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүд, 2-р шатлалд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, 3-дагч шатлалд клиникийн эмнэлгүүд, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлшүүд орно.

Одоо улсын хэмжээгээр эрүүл мэндийн 1500 шахам байгууллага ажиллаж байгаагаас төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг болон төв 15, нэгдсэн эмнэлэг 32, сум дундын эмнэлэг 13, хөдөөгийн буюу сумын эмнэлэг 334, өрхийн эмнэлэг 178, эрүүл мэндийн төв 12, БГХӨЭСТ-13, хувийн эмнэлэг 466, түргэн тусламжийн станц 35, цусны төв ба станц 26, эмийн сан 319 тус тус ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарт 6162 их эмч, эмнэлгийн тусгай дунд боловсролтой 13185 мэргэжилтэн, нийтдээ 30000 шахам хүн ажиллаж, эмнэлгийн 17877 ор бүхий хүчин чадалтай боллоо⁸⁷.

Монгол Улсын иргэнд түүний эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамааран эмнэлгийн дараахь тусламж, “үйлчилгээний төлбөрийг төр хариуцна. Үүнд:

- эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ;
- сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэгийн эмчилгээ, халдвар судлалын
- үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл
- жирэмсэн, төрөх, төрсний дараахь үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар
- байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол болон нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;
- аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар, эсхүл их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ.
- удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал
- эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ.

4.4.3.2 Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж, тавигдах шаардлагууд

Манай улсын иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг анхан гатны нэгж болох өрхийн эмнэлгээр дамжуулан үнэ төлбөргүй авах эрхтэй. Улаанбаатар хотын 9 дүүргийн иргэд иргэд доорхи байдлаар харьяа эмнэлэгтээ үзүүлж, эмчилгээ, үйлчилгээ авах эрхтэй.⁸⁸ Харин орон нутгийн иргэд харьяаллын дагуу өрхийн болон сум, аймгийн эмнэлгүүдэд үзүүлж, эмчилгээ, үйлчилгээ авна.

⁸⁶ www.moh.mn

⁸⁷ <http://www.103.mn/archives/1051>

⁸⁸ http://www.ulaanbaatar.mn/index2.php?option=com_content&task=view&id=525&pop=1&page=0

д	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Хаяг	Холбогдох утас	Үйлчлэх хүрээ	Үйл ажиллагааны чиглэл
1	Баянгол Эрүүл мэндийн нэгдэл	Баянгол дүүргийн 17-р хороо, Жалханз хутагт Дамдинбазарын гудамж	365036 362530 362539	Баянгол дүүргийн хүн амд, мөн 1, 2, 3, 4, 5, 6, 16, 17, 18, 20-р хорооны хүн амд	Баянгол дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
	Амбулатори № 1	Баянгол дүүрэг, 19-р хороо	366370 361902	Баянгол дүүргийн 9, 10, 11, 12, 13, 14, 15, 17, 18, 19-р хорооны хүн амд	
2	Баянзүрх Эрүүл мэндийн нэгдэл	Баянзүрх дүүргийн 5-р хороо	450362 453979 451003	Баянзүрх дүүргийн хүн амд	Баянзүрх дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
	Амбулатори № 1	Баянзүрх дүүргийн 7-р хороо	452281 450977 454467	Баянзүрх дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 7-р хороо	
	Амбулатори № 2	Баянзүрх дүүргийн 7-р хороо, Эрдэнэ толгой 8-р хороо	460607 480401 99882485	Баянзүрх дүүргийн 8, 9, 16, 17, 19-р хороо	
3	Багануур Эрүүл мэндийн нэгдэл	Багануур дүүргийн 1-р хороо	0121-20238 0121-20290 0121-22004	Багануур дүүргийн 1, 2, 3, 4-р хороо, Төв аймгийн Баяндэлгэр суманд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, Ар хуст, Мөнгөн морьт, Хэнтий аймгийн Цэнхэр мандал, Дэлгэрхаан сумдын эмэгтэйчүүдийн төрөлт, яаралтай тусламжийн үйлчилгээ	Багануур дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
4	Налайх Эрүүл мэндийн нэгдэл	Налайх дүүргийн 1-р хороо	0123-23158 0123-23464	Налайх дүүргийн 1, 2, 3, 4-р хороо, Тэрэлж, Шохой, Харзтай, Ар жанчивлан, 4-ийн зөрлөгүүдийн хүн амд	Налайх дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
5	Хан-Уул Эрүүл мэндийн нэгдэл	Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө	341170 342493 341003	Хан-Уул дүүргийн хүн амд, мөн 1, 2, 3, 9, 10, 11, 12-р хороо	Хан-Уул дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
	Амбулатори № 1	Хан-Уул дүүргийн 6-р хороо, Чингисийн өргөн чөлөө	374285	Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8-р хороо	
6	Чингэлтэй Эрүүл мэндийн нэгдэл	Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Сүхбаатарын гудамж	327756 326275	Чингэлтэй дүүргийн хүн амд, 1, 2, 3, 4, 5-р хороо	Чингэлтэй дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
	Амбулатори № 1	Чингэлтэй дүүргийн 6-р хороо, Бага	310680 99185111	Чингэлтэй дүүргийн 6, 7, 8, 9, 10-р хороо	

		тойруу			
	Амбулатори № 2	Чингэлтэй дүүргийн 13-р хороо	357110 357069 99181783	Чингэлтэй дүүргийн 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18-р хороо	
7	Сүхбаатар Эрүүл мэндийн нэгдэл	Сүхбаатар дүүргийн 11-р хороо, Цагдаагийн гудамж	350808 350809 350810	Сүхбаатар дүүргийн хүн амд	Сүхбаатар дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
	Амбулатори № 1	Сүхбаатар дүүргийн 3-р хороо	327591 327530 99152670	Сүхбаатар дүүргийн 1, 2, 3, 4, 5-р хороо	
8	Сонгинохайрхан Эрүүл мэндийн нэгдэл	Сонгинохайрхан дүүргийн 13-р хороо, Залуусын гудамж	681665 681475	Сонгинохайрхан дүүргийн хүн амд, мөн 12, 13, 14, 15, 16, 17-р хороо	Сонгинохайрхан дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
	Амбулатори № 1	Сонгинохайрхан дүүргийн 19-р хороо, Чингис СООСЭ	632003 631750	Сонгинохайрхан дүүргийн 4, 5, 6, 19-р хороо	
	Амбулатори № 2	Баянгол дүүргийн 5-р хороо, Тээвэрчдийн гудамж	631931 631293	Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3, 18, 20-р хороо	
	Амбулатори № 3	Сонгинохайрхан дүүргийн 9-р хороо, Баянхошууны эцэс	306066 306121	Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 11-р хороо	
9	Багахангай дүүргийн эмнэлэг	Багахангай дүүргийн 1-р хороо	0222-44915 99871694	Багахангай дүүрэг, Төмөр замын Цагаан хяр өртөө, төмөр замын 13-р зөрлөг	Багахангай дүүргийн хүн амд эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
10	Баянзүрх Нэгдсэн эмнэлэг	Баянзүрх дүүргийн 5-р хороо, Өлгийн гудамж, Баянзүрх Эрүүл мэндийн нэгдлийн ард	452057 454444	Баянзүрх дүүргийн хүн амд	Эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
11	Хан-Уул Нэгдсэн эмнэлэг	Хан-Уул дүүргийн 4-р хороо, Арцатын задгай	379277 319277 379258	Хан-Уул дүүргийн 0-16 насны бүх хүүхэд, 4, 5, 6, 7, 8-р хорооны насанд хүрэгчдэд	Эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
12	Сүхбаатар Нэгдсэн эмнэлэг	Сүхбаатар дүүргийн 11-р хороо, Зуун айл	359907 359948	Сүхбаатар дүүргийн хүн амд, Чингэлтэй дүүргийн 0-16 насны хүүхдэд	Эрүүл мэндийн 2-р шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах
13	Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлэг	Сонгинохайрхан дүүргийн 19-р хороо	631102 631108 631895	Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Баянгол дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 20-р хороодын 0-16 насны хүүхдэд, Сонгинохайрхан	Эрүүл мэндийн 2 дахь шатлалын тусламж, үйлчилгээг

				дүүргийн 4, 5, 6, 18, 19-р хороонынасанд хүрэгчдэд	үзүүлэх, зохион байгуулах
14	Клиникийн 1-р амаржих газар	Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө	323283 321191 322652	Хан-Уул, Чингэлтэй, Налайх, Багануур, Багахангай дүүрэг, Сүхбаатар дүүргийн 1, 2, 3, 4, 5, 11, 12, 13, 14, 15, 16-р хороо, Туул тосгоны хүн амд	Эх барих, эмэгтэйчүүд, нярайн төрөлжсөн тусламж үйлчилгээ үзүүлэх
15	Клиникийн 2-р амаржих газар	Сүхбаатар дүүргийн 2-р хороо, Сайн ноён Намнансүрэнгийн гудамж-2	324495 321451	Сонгинохайрхан дүүргийн нийт хүн амд	Эх барих, нярайн төрөлжсөн тусламж үйлчилгээ үзүүлэх
16	Клиникийн 3-р амаржих газар	Баянзүрх дүүргийн 5-р хороо, Өлгийн гудамж, Баянзүрх Эрүүл мэндийн нэгдлийн урд	450003 454401 454611	Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүргийн 6, 7, 8, 9, 10-р хороо, Гачуурт, Хонхор тосгоны хүн амд	Эх барих, нярайн төрөлжсөн тусламж үйлчилгээ үзүүлэх
17	Шүд, Эрүү нүүрний эмгэг судлалын төв	Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Сүхбаатарын талбай-11	325790 319213	Нийслэлийн болон Улсын хэмжээнд	Амны хөндийн эрүүл мэндийн 3-р шатлалын тусламж, үйлчилгээ, сургалт, эрдэм шинжилгээ
18	Яаралтай тусламжийн төв	Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Эмнэлгийн гудамж	327485 326387 103	Нийслэлийн хүн амд	Нэн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх
19	Сэргээн засах клиникийн эмнэлэг	Хан-Уул дүүргийн 11-р хороо, Туулын хөвөө	342090 342414	Нийслэлийн хүн амд	Хүн амд эмийн бус эмчилгээ, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
20	Наркологийн эмнэлэг	Баянгол дүүргийн 20-р хороо, Сонсголонгын 10-ын буудал	634317 633985	Нийслэлийн хүн амд	Сайн дураараа эмчлүүлэхээр ирсэн архинд донтох өвчтөнд эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
21	Энэрэл эмнэлэг	Баянзүрх дүүргийн 13-р хороо	450372 450393 450972 452152	Нийслэлийн эмзэг бүлгийн хүн амд	Нийслэлийн эмзэг бүлгийн хүн амд 2-р шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх
22	Хүүхдийн клиник сувилал №4	Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө	341598	Хан-Уул дүүргийн 1-5 насны архаг, суурь өвчтэй хүүхдүүдэд	1-5 насны Архаг, суурь өвчтэй хүүхдүүдийг асран сувилах, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх
23	Хүүхдийн клиник сувилал № 20	Чингэлтэй дүүргийн 3-р хороо	325590	Чингэлтэй дүүргийн 1-5 насны архаг, суурь өвчтэй хүүхдүүдэд	1-5 насны Архаг, суурь өвчтэй хүүхдүүдийг асран сувилах, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх тусламж,

					үйлчилгээ үзүүлэх
24	Хүүхдийн клиник сувилал № 40	Баянзүрх дүүргийн 16-р хороо, Дандарын гудамж	450985 452972	Баянзүрх дүүргийн 1-5 насны архаг, суурь өвчтэй хүүхдүүдэд	1-5 насны Архаг, суурь өвчтэй хүүхдүүдийг асран сувилах, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх
25	Хүүхдийн клиник сувилал № 41	Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо, 5 шар	632651	Сонгинохайрхан дүүргийн 1-5 насны архаг, суурь өвчтэй хүүхдүүдэд	1-5 насны Архаг, суурь өвчтэй хүүхдүүдийг асран сувилах, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх
26	Гачуурт тосгоны эмнэлэг	Баянзүрх дүүргийн 20-р хороо	710003	Баянзүрх дүүргийн 20-р хорооны хүн амд, Шар хоолой, Арцат, Улиастай	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх
27	Жаргалант тосгоны эмнэлэг	Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо	631041-103	Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны хүн амд, Эмээлт өртөө, 361-ын гарам, □ ашаант, 335-р гарам, 347-р гарам, Нарийн, Шар хад, Шижир, Гүнт, Партизаны төв	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх
28	Хонхор тосгоны эмнэлэг	Баянзүрх дүүргийн 11-р хороо	948854 99876988 99696330	Баянзүрх дүүргийн 11-р хорооны нийт хүн амд	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх
29	Туул тосгоны эмнэлэг	Хан-Уул дүүргийн 13-р хороо	730103 99246640	Хан-Уул дүүргийн 13-р хорооны нийт хүн амд	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх

Дээрх төрийн эмнэлгүүдийн үйлчилгээг авахын тулд эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, тасралтгүй төлөх үүрэгтэй. Мөн үйлчилгээ авахын тулд сүүлийн гурван жилийн даатгалыг заавал төлсөн байх учиртай. Энэ нь нийгмийн даатгалын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өөрийн эрүүл мэндээ даатгуулж, тодорхой хэмжээний шимтгэлийг урьдчилан төлснөөр шаардлагатай үедээ иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжинд заасан тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжтой болдог.

Даатгалын хэлбэр	Заавал даатгуулах	Сайн дураар даатгуулах
Даатгуулагч иргэн	Монгол улсын иргэн бүр	Гадаадын иргэн, харьяалалгүй хvн
Шимтгэлийг хэн төлдөг	А. Дараахь иргэд шимтгэлээ өөрөө хариуцан төлнө. - Оюутан суралцагсад, малчид, ажил хөдөлмөр эрхлээгч иргэд	Даатгуулагч өөрөө хариуцан төлнө

	<ul style="list-style-type: none"> - Нөхөн олговрын тэтгэвэртэй иргэд - Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, - Төрийн албан хаагчид , - Аж ахуйн нэгж байгууллагын болон иргэний малыг тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу маллаж байгаа малчин <p>Б. Дараахь иргэдийн шимтгэлийг төр хариуцан төлнө.</p> <ul style="list-style-type: none"> - 16 нас хүртэлх насны хvvxэд / ЕБС-д суралцаж байгаа бол 18 нас хүртэлх / - Тэтгэврээс өөр мөнгөн орлогогvй иргэн - Хvvxдээ 2 нас / ихэр бол 3 нас / хүртэл өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/ - Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч - Нийгмийн халамжийн тухай хуулийн 12-р дугаар зүйлд заасан иргэд. 	
Шимтгэлийн хэмжээ	<p>А. Шимтгэлийн хэмжээг Засгийн газар тогтоодог даатгуулагчид:</p> <ul style="list-style-type: none"> · Аж ахуйн нэгж , байгууллагын ажилтан хөдөлмөрийн хөлс тvvнтэй адилтгах орлогоосоо сар тутам 4 хувиар төлнө . / Үүнээс: 2 хувийг нь даатгуулагч өөрөө, 2 хувийг нь ажил олгогч хариуцан төлнө. / <p>Б. Шимтгэлийн хэмжээг Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөл тогтоодог даатгуулагчид :</p> <ul style="list-style-type: none"> - Төр шимтгэлийг нь хариуцан төлдөг иргэд сар тутам 300 төгрөг - Хоригдол сар тутам 300 төгрөг - Оюутан суралцагсад сар 500 төгрөг, - Малчид сар тутам 500 төгрөг - Ажил хөдөлмөр эрхлээгvй иргэд сар тутам 500 төгрөг Нөхөн олговрын тэтгэвэртэй иргэд сар тутамд 200 төгрөг <p>В. Шимтгэлийн хэмжээг Нийгмийн даатгалын байгууллага тогтоодог даатгуулагчид:</p> <ul style="list-style-type: none"> · Аж ахуйн нэгж ийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн татварын албанд гаргасан орлогын мэдvүлгийн мөнгөн дvнгээс сар тутам 3 хувиар шимтгэл төлнө. 	Хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлогын 1.0 хувиар шимтгэл төлнө.
Хаана, хэнд	- Харьяа нутаг дэвсгэрийн Нийгмийн	- Харьяа нутаг

хандах	Даатгалын байгууллагын Эрүүл мэндийн даатгалын байцаагчид - Тухайн байгууллагын нягтлан бодогч , санхүүгийн ажилтанд	дэвсгэрийн Нийгмийн Даатгалын байгууллагын Эрүүл мэндийн даатгалын байцаагчид
Бүрдүүлэх баримт бичиг	<p>А. Шимтгэлийг төр хариуцдаг иргэд :</p> <ul style="list-style-type: none"> - иргэний үнэмлэх , төрсний гэрчилгээ, тэтгэврийн дэвтэр - Нэг хувь цээж зураг - Гэрчилгээний үнэ төлсөн баримт - Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагчийн батлах - 16 нас хүрсэн боловч ЕБС сурдаг бол сургуулийн тодорхойлолт <p>Б. Шимтгэлийг өөрөө төлдөг иргэд :</p> <ul style="list-style-type: none"> - Иргэний үнэмлэх - Нэг хувь цээж зураг - Гэрчилгээний үнэ төлсөн баримт - Нэг жилийн шимтгэлээ Нийгмийн даатгалын дансанд төлсөн баримт 	<ul style="list-style-type: none"> - иргэний үнэмлэх - Нэг хувь цээж зураг - Гэрчилгээний үнэ төлсөн баримт - Нэг жилийн шимтгэл төлсөн баримт
<p><i>Эдгээр иргэд шимтгэлээ төлсөн тохиолдолд гэрчилгээгээ байцаагчийн гарын үсэг , Нийгмийн даатгалын тэмдэгээр баталгаажуулах ёстой</i></p>		
<ul style="list-style-type: none"> • <i>Та эрүүл мэндийн даатгалд даатгуулсанаар :</i> <ul style="list-style-type: none"> - <i>Өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээ</i> - <i>Бүх шатны эмнэлгийн амбулаторийн үзлэг оношлогоо, шинжилгээ</i> - <i>Бүх шатны эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үеийн тусламж, үйлчилгээ</i> - <i>Рашаан сувиллын эмчилгээ, үйлчилгээ</i> - <i>Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт</i> - <i>Зарим төрлийн протөзийн үнийн тодорхой хувь авах эрхтэй</i> 		

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээ хэд байдаг вэ?

Д/д	Заавал даатгуулагч	Шимтгэлийн хэмжээ /төгрөг/		ЭМД-ын шимтгэлийг хариуцаж төрөл байгууллага
		Сарын	Жилийн	

1.	16 /ЕБС-д суралцаж байгаа бол 18/ хүртэлх насны хүүхэд	500	6000	Улсын төсвөөс
2.	Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн	500	6000	Улсын төсвөөс
3.	Хүүхдээ 2 /ихэр бол 3/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх, эцэг	500	6000	Улсын төсвөөс
4.	Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	500	6000	Улсын төсвөөс
5.	Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан иргэн	500	6000	Улсын төсвөөс
6.	Их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн едрийн ангийн суралцагч	500	6000	Даатгуулагч өврөө
7.	Малчин	500	6000	Даатгуулагч өврөө
8.	Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн	500	6000	Даатгуулагч өврөө
9.	Хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэн	Сарын орлогын мөнгөн дунгийн 1 хувь		Даатгуулагч өврөө
10.	Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй иргэн	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувиар бодож шимтгэл төлнө. Уний 50 хувийг иргэн өөрөө, үлдсэн 50 хувийг ажил олгогч төлнө.		
11.	Гадаадын иргэн, харъяалалгүй хүн	4000	48000	Даатгуулагч өврөө

4.4.3.3 Эрүүл мэндийн халамжийн ханш, үнэ өртөг (эмчилгээ, эм тариа, эмчийн төлбөр хөлс)

Монгол улс 1990 оноос өмнө нийт хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төр засгаас тэгш хүргэж, улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж байсан. Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн салбарт

хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо нэмэгдэж, хүн ам чанартай тусламж үйлчилгээг шаардаж байна.⁸⁹ Одоо эрүүл мэндийн системийн өмнө тулгамдаж байгаа гол асуудал нь тусламж үйлчилгээний чанарын асуудал бөгөөд чанаргүй тусламж үйлчилгээ нь санхүүжилтийн хомсдолоос үүдэлтэй гэж үздэг.

Эрүүл мэндийн даатгалаар аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношлогоо, эмчилгээний төвд хэвтэн эмчлүүлбэл үйлчилгээний зардлын 10 хувийг, клиникийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлбэл 15 хувийг тус тус өөрөө хариуцан төлөх үүрэгтэй. (Хүснэгтээс харна уу) Харин таны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцан төлж байгаа бол та ямар нэгэн төлбөр төлөхгүй. Эрүүл мэндийн даатгалын сангаас төрөл эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын дээд хэмжээ 2009 оны байдлаар 910000 төгрөг байна.

Хэрэв та өөрийгөө өвчлөх эрсдэл өндөртэй, жилдээ 910000 төгрөгөөс илүү хэмжээний тусламж, үйлчилгээ авах шаардлагатай гэж үзвэл ДАВХАР даатгалд хамрагдаж болно. Мөн дараалсан 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тасралтгүй төлсөн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ аваагүй иргэнд нэг удаагийн эрүүл мэндийн бүрэн үзлэг хийлгэх эрх олгож, зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцна.⁹⁰

НЭГ ДААТГУУЛАГЧИЙН ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ХЭМЖЭЭ⁹¹

Эмнэлгийн ангилал	Тариф	ЭМДС	Даатгуулагч өөрөө төлөх
		(Төвлөрсөн болон орон нутгийн)	
Клиникийн төв эмнэлэг, Клиникийн II эмнэлэг, ШКТЭ, Хавдар судлалын төв	67 000	56 950	10 050
Гэмтэл согог, сэргээн засалтын клиникийн эмнэлэг, Эх нялхсын эрдэм шинжилгээний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв	61 000	51 850	9 150
Бүсийн оношлогоо эмчилгээний төв	56 000	50 400	5 600
Зэвсэгт хүчний, Төрийн тусгай албан хаагчдын, Төмөр замын, ШШЕГ-ын нэгдсэн эмнэлгүүд, аймаг, дүүргийн болон бусад нэгдсэн эмнэлгүүд	51 00	45 900	5 100
Уламжлал анагаах ухааны клиник	50 000	45 000	5 000
Арьсны өвчин судлалын төв, Наркологийн эмнэлэг, амаржих газруудын эмэгтэйчүүдийн тасаг	40 000	34 000	6 000
Сэргээн засах клиникийн эмнэлэг, Элэг судлалын төв ба адилтгах эмнэлгүүд	35 000	31 500	3 500
Сум дундын эмнэлэг	35 000	33 250	1 750
Сум, тосгоны эмнэлэг	32 000	30 400	1 600
Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалтын төвийн протезийн тасаг	25 000	25 000	

⁸⁹ http://www.forum.mn/forum_topics/fellows/LuMunkhErdene.pdf

⁹⁰ <http://www.ndaatgal.mn/content.php?mid=1&file=address11-3>

⁹¹ http://www.ndaatgal.mn/law_said_tushaal.php?mid=3&tid=13

Хорихын, Цэргийн, Хилийн цэргийн ангийн салбар эмнэлэг	14 000	13 300	700
Рашаан сувилал	-		
1/Оргил болон орон нутгийн үйлчилгээтэй сувилал	20 000	20 000	
2/Оргил клиник тасаг	30 000	30 000	

АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ДААТГУУЛАГЧИД НОГДОХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ⁹²

№	Ангилал	ЭМД-ын сангаас олгох зардал
1	3-р шатлалын эмнэлгүүд, Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв	1600 төг
2	БОЭТ болон Арьсны өвчин судлал, уламжлалт анагаах ухааны клиник	1000 төг
3	Орон нутгийн нэгдсэн эмнэлгүүд	800 төг
4	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, амбулаториуд	4000 төгрөг

Харин хувийн эмнэлшүүд харилцан адилгүй үнэ ханштай байдаг. Хувийн эмнэлгүүд амбулаторийн үзлэгт ЭМД хэрэглэдэггүй бөгөөд бүх үзлэг, шинжилгээ үнэ төлбөртэй байдаг. Ихэнхи тохиолдолд хэвтэж эмчлүүлэхэд ЭМД дээр нэмж хоногийн 20 000 төгрөгнөөс дээш төлбөр авдаг. Хувийн эмнэлгүүд гол төлөв оношлогоо, дотор, эмчилгээ, арьс өнгө, шүд, эмэгтэйчүүдийн эмнэлгийн чиглэлээр ажилладаг.

4.4.3.4 Эрүүл мэндийн тогтолцоон дахь алагчлал, ялгаварлан гадуурхалт (гарал үүслийн, шашны, нийгмийн г.м)

Ямар нэгэн ялгаварлан гадуурхалт байхгүй.

4.4.3.5 Төрийн бус байгууллагын үзүүлдэг эрүүл мэндийн үйлчилгээ (олон улсын байгууллага, ТББ, сүм)

Улаанбаатар хотод ганц Энэрэл эмнэлэг нь орон гэргүй, эмзэг бүлгийн иргэдэд тусалцаа үзүүлэн Францын тусламжийн байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулагдан ажиллаж байна. Утас:7015 2182. Орон нутгуудад энэ төрлийн эмнэлэг байхгүй. Мөн Ротару клубын гишүүд зүрхний хүнд хэлбэрийн гажигтай хүүхдүүдийг эмчилгээнд үнэ төлбөргүй явуулахад тусалдаг. Мөн сүмийн шугамаар БНСУ, АНУ-аас эмч нар ирж тухайн сум, хорооны нутаг дэвсгэрт шүд, дотор, зүрх судасны оношлогоо, эмчилгээ хийдэг боловч байнгын үйл ажиллагаатай газар байхгүй байна.

4.4.3.6 Тухайн оронд эмчилдэггүй өвчин, эмгэгүүд

Манай улсад эмчилгээний орчин үеийн үр дүнтэй техник, тоног төхөөрөмж, эм хангамжийн дутагдалтай холбоотойгоор зарим өвчнийг эрт оношлох, эмчлэх боломж хязгаарлагдмал байдаг. Үүнд: бүх төрлийн хавдрууд үүн дотроо элэгний хорт хавдраар өвчилж нас барасдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа. Мөн 'Вирусээр үүсгэгдсэн тархины үрэвсэл', хүнд хэлбэрийн тархины өвчлөлүүд, эрхтэн шилжүүлэх (2008 оноос эхлэн бөөр шилжүүлэн суулгаж эхэлж байна),

⁹² Эрүүл, мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 103/122/53 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

хүүхдүүдийн дунд нэмэгдэж байгаа цусны хавдар, бөөрний архаг дутагдал, зүрхний хүндэрсэн хагалгаа, судсан доорхи мэс засал, нурууны хүндэрсэн мэдрэлийн мэс засал, гэмтсэн эрхтэнг нөхөн суулгах, хавдрын мэс заслын шинэлэг хэлбэрүүд зэргийг хийдэггүй. Ер нь хавдрыг эрт үед нь оношлох нь муугаас 3\4 нь сүүлчийн шатандаа эмнэлэгт хандаж, туслалцаа авч чаддаггүй.

4.4.3.7 Стандарт эм тарианы хангамж

Монгол улсад мөрдөгдөж буй стандартын дагуу аль ч шатлалын эмнэлэгт нэн шаардлагатай эмийн хангамж 70-80%, яаралтай тусламжийн эм, тарианы хангамж 80.0-90.0 хувьд хэлбэлздэг байна. Эмийн хангамж, хүртээмж хангалттай биш байдаг ба ялангуяа шингэн сэлбэлтийн зардал, эмчилгээний шинэ технологи-шинэ эмчилгээний уялдаа холбоогүй байдлаас болдог. Эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 23.0-70.0% нь эдэлгээ дууссан, сэлбэг хэрэгсэлгүй, хэт хуучирсан, одоогийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, их засварт оруулах шаардлагатай тоног төхөөрөмж цөөнгүй байна.⁹³ Монголчуудын хувьд эм тариа, ялангуяа антибиотойн хэрэглээ маг өндөр, өөрсдөө дур мэдэн эмчилгээ хийдэг нь өвчнийг ужигруулдаг гэж эмч нар үздэг. Одоо нийслэлд зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй 268 эмийн сан байна⁹⁴. Хаяг, байршлыг доорхи сайтаас авна уу.

(http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=527&Itemid=259)

Эмнэлгийн тусламж, эмийн хэрэглээ, хангамж, тоног төхөөрөмжтэй холбоотой асуудлаар МУ-ын СХЗГ-аас батлан гаргасан стандартуудыг мөрдөн ажилладаг⁹⁵.

⁹³ <http://mams.mn/journals/index.php?page=mypage&op=read&id=118>

⁹⁴ (http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=527&Itemid=259)

⁹⁵ http://estandard.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=217

5. Эх орондоо эргэн ирж буй тусгай хэрэгцээт иргэд

5.1 Эмэгтэйчүүд

Монгол Улс нь хүйсийн тэгш байдлыг дэмжих/хангах орчин харьцангуй сайтай улс юм. Монгол Улсын Үндсэн Хуулиар эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд тэгш эрхтэй. Засгийн Газар нь эмэгтэйчүүдийн эрх, тэгш байдлыг хангах үүргийг олон улсын конвенциудаар хүлээдэг. Иргэний нийгмийн байгууллага, хөдөлгүүнүүд эмэгтэйчүүдийн эрх, тэгш байдлыг хангах зорилгоор идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. Гэсэн хэдий ч хүйсийн тэгш бус байдал олонтаа байгаа нь эдийн засгийн боломж, нийтийн үйлчилгээ, эдийн засгийн болон гэр бүлийн хүчирхийлэл, улс төрийн эрх мэдлийн салбарт илүүтэй байна.

5.1.1 Эмэгтэйчүүдэд тулгарч буй эрсдэл

Гадаадаас эх орондоо эргэн ирсэн эмэгтэйчүүдийн нэг гол эрсдэл нь ажил олох явдал юм. Төрийн албанд ажиллах хүсэлтэй хүмүүс жилд нэг удаа болдог төрийн албаны шалгалт өгөх шаардлагатай. Хувийн компаниудын хувьд хүний нөөцийн өөрсдийн бодлоготой байдаг. Зарим компаниуд олон нийтэд нээлттэйгээр өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр ажлын байрны зар гаргадаг бол нөгөө хэсэг нь өөр эх үүсвэрээр дамжуулан ажилд авдаг.

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл нь хууль бус үйлдэл юм⁹⁶. Гэвч гэр бүлийн хүчирхийллийн ихэнхи тохиолдол хууль хэрэгжүүлэх байгууллагад бүртгэгддэггүй. Учир нь хүчирхийлэлд өртөгсдөд цагдаа, шүүхийн үйл явц хэтэрхий дарамттай тусдаг нь энэ төрлийн гэмт хэргийн бүртгэлийг бууруулах хандлагатай байна⁹⁷. Гэр доторх асуудлаасаа санаа зовох нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн бүртгэлийг бууруулахад мөн нөлөөлдөг.

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв (ХЭҮТ)-ийн тооцоолсоноор 2007 онд гурван эмэгтэй тутмын нэг нь ямар нэгэн байдлаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бол арван эмэгтэй тутмын нэг нь зодуулсан байна.

Монгол Улсад бэлгийн дарамтын тухай хууль байдаггүй. Төрийн бус байгууллагууд энэ асуудлаарх нийгмийн ойлголт хандлага төлөвшөөгүй байгаа нь энэ хэргийг нууцлаг, илрэх боломжгүй болгодгийн гадна асуудал гүнзгийрэхэд нөлөөлдөг гэж үздэг. Хүний Эрхийн Үндэсний Комиссын хийсэн судалгаагаар 35-аас доош насны хоёр эмэгтэй тутмын нэг нь ажлын байран дахь бэлгийн дарамтанд өртдөг хэмээн тодорхойлсон байдаг.

⁹⁶ <http://legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=1300>

⁹⁷ <http://safefuture.mn/mn/resource.html>

ХЭҮТ нь гэр бүлийн болон бусад төрлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлдэг. Энэхүү байгууллага нь хүчирхийлэлд өртсөн тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд хуулийн болон сэтгэл зүйн зөвөлгөө өгдөг ба хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байраар хангадаг.

ХЭҮТ-ийн хаяг : Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу-1, 40-р байр, 26 тоот

Утас: +976 11 318087, 318086

И-мэйл: mongolcav@magicnet.mn

5.1.2 Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд зориулсан дэмжлэгийн хэлбэрүүд.

Эх орондоо эргэн ирэгсдэд зориулсан хуулийн, эдийн засгийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг тусгай байгууллага гэж байдаггүй.

Эргэн ирэгсэд нийгмийн болон хуулийн үйлчилгээ үзүүлдэг зарим ТББ-уудаас мэдээлэл авах боломжтой:

Хүйсийн Тэгш Эрхийн Төв нь хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон иргэдэд мөн гадаадын орнуудаас сайн дураараа эргэн ирэгсдэд туслалцаа үзүүлэх, эргэн нийгэмших үйлчилгээг үзүүлдэг.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Эрх чөлөөний талбай №2-1/101, 102 тоот,
Улаанбаатар, Монгол Улс

Утас: +976-11-311512, итгэлийн утас1903

И-мэйл: gendereqcen@magicnet.mn

Вэб хуудас: www.stoptrafficking.mn

Хүүхэд, Эмэгтэйчүүдийн Халамж, Хамгаалал Төв нь Европын Холбооны Улсуудаас сайн дураараа эргэн ирсэн иргэдэд эргэн нийгэмших үйлчилгээг үзүүлдэг.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, Хурд Хорооллын 1-р байр, Бага Тойруу, Улаанбаатар, Монгол Улс

Утас: +976 11 324333

И-мэйл: ccwp2008@gmail.com

Өнөөгийн нийгмийн халамжийн тэтгэмжийн тогтолцооны дагуу Монгол Улсын иргэн 62 төрлийн тэтгэвэр, тэтгэмж авах боломжтой. Засгийн Газраас олгож буй өөрт тохирох тэтгэвэр, тэтгэмжийн

талаарх мэдээллийг Нислэлийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн вэб хуудаснаас авах боломжтой⁹⁸.

Одоогийн мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу хүн амын амьжиргааны түвшингийн доод хэмжээг нэг жилд нэг удаа тогтоодог. Үндэсний Статистикийн Хорооны 2009 оны 4 дүгээр сарын мэдээллээр хүн амын амьжиргааны түвшингийн доод хэмжээ Баруун бүсэд 96,100 төгрөг, Хангайн бүсэд 90,600 төгрөг, Зүүн бүсэд 86,300 төгрөг, Төвийн бүсэд 91,200 төгрөг, Улаанбаатар хотод 101,100 төгрөг байжээ.

5.1.2.1 Хүүхэдгүй ганц бие эмэгтэйчүүд

Монгол Улсын одоогийн хууль, тогтоомжийн дагуу эмзэг бүлгийн ганц бие эмэгтэйчүүд нь эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд тооцогддоггүй. Гэсэн хэдий ч тэд Монгол Улсын Нийгмийн халамж, нийгмийн даатгалын тухай хуулинд заасан нийгэм, эдийн засгийн бүх төрлийн халамжийг авах эрхтэй.

Эмзэг бүлгийн ганц бие эмэгтэйчүүд иргэний нийгмийн байгууллагуудын зохион байгуулдаг хүчирхийллээс хамгаалах олон төрлийн төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой байдаг.

Нийгмийн хамгааллын үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг орон нутгийн Хөдөлмөр, Нийгмийн Халамжийн Хэлтэстэй холбогдож авна уу.

5.1.2.2 Хүүхэдгүй бэлбэсэн эмэгтэйчүүд

Бэлбэсэн эмэгтэйчүүд тодорхой шалгууртайгаар нийгмийн халамжийн тэтгэмж авах эрхтэй. Эдгээр шалгуурын талаар Нийгмийн Халамжийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 17 ба 18-р зүйлд заасан байдаг. Нийгмийн халамжийн тэтгэвэрийн тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангийн хүнгүй 55 ба түүнээс дээш настай эмэгтэй авах эрхтэй⁹⁹. Бэлбэсэн эмэгтэйчүүд нийгмийн халамжийн асран хамгаалагчийн тусламжийг авах эрхтэй. Нийгмийн халамжийн тэтгэвэр болон асран

⁹⁸http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=1143&Itemid=274&tmp

⁹⁹http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=1143&Itemid=274&tmp = article 18.1.1

халамжлагчийн тусламжийн өргөдлийг харьяа нутаг дэвсгэрийнхээ Хөдөлмөр, Нийгмийн Халамжийн Хэлтэст өгдөг.

Өнөөгийн нийгмийн халамжийн тогтолцоо:

Улсын Хөдөлмөр Нийгмийн Халамжийн Газар (Улаанбаатар хотод байралдаг ба Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны харьяа);

21 аймаг ба Улаанбаатар хотын 9 дүүрэгт байрлах Хөдөлмөр, Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтсүүд;

340 суманд байрлах Нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд;

Улс болон аймгийн түвшин дэх асрамжийн газрууд (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон гудамжны хүмүүст зориулсан) болон өндөр настнуудад зориулсан сувилалын газрууд.

5.1.2.3 Хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд

Олон хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүд нь хүн амын эмзэг бүлэгт зүй ёсоор тооцогддог. Эдгээр хүмүүс нийгмийн даатгал, нийгмийн халамжид албан ёсоор хамрагддагийн гадна Засгийн газар болон олон улсын байгууллага, ТББ-уудын хэрэгжүүлдэг төслүүдэд хамрагддаг.

Засгийн Газраас шинэ төрсөн хүүхдэд олгох тэтгэмж:

Тайлбар: 2008.01.01-ний өдрөөс хойш төрсөн хүүхэд бүрт олгох тогтмол тэтгэмж.

Хугацаа, нэрлэсэн хэмжээг Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нь 100.000 төгрөг100 болно.

Хүлээн авагч нь Монгол Улсын иргэн байна.

Шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тэтгэмжийн өргөдлийг хүүхдийг 1 нас хүрэхээс өмнө эхийн гаргасан хүсэлт болон доорхи нэмэлт бичиг баримтын хамт оршин суугаа газрынхаа Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний Газарт өгнө: Үүнд:

Хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;

Хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай өрхийн эмнэлэгийн тодорхойлолт;

Эхийн Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

Оршин суугаа хороон дээр тэтгэмжийн өргөдөл бөглөх101;

¹⁰⁰ Legalinfo, Нийгмийн Халамжийн тухай Хууль

¹⁰¹ Хороо нь Улаанбаатар хотын засаг захиргааны хамгийн жижиг нэгж юм.

Гадаадын оронд төрсөн хүүхэд бол тухайн орон дахь Монгол Улсын ЭСЯ аль эсвэл Консулын газраас авсан баталгаа/тодорхойлолт.

Нярай хүүхэд асарсаны тэтгэмжийг жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдэд олгодог.

Хугацаа/Хэмжээ: Эх жирэмсэний 5 сартайгаас 1 жилийн турш сар тутам тэтгэмж авна. Ихэр хүүхэд төрүүлсэн бол хүүхдүүдийг 1 нас хүртэл нь сар тутам тэтгэмж авна;

Нэрлэсэн хэмжээг хуулинд заасан,

Хүлээн авагч: Орологоос үл шалтгаалан бүх эмэгтэйчүүд.

Хүүхдийн тэтгэмжийн өргөдлийг доорхи бичиг баримтын хамт эхийн тогтмол оршин суугаа дүүрэг буюу сумын Хөдөлмөр, Нийгмийн халамжийн Үйлчилгээний Хэлтэст өгнө: Үүнд:

Оршин суугаа хорооны Засаг даргын баталсан хүсэлт;

Эхийн иргэний үнэмлэх хуулбарын хамт;

Дүүргийн эмнэлэгт жирэмсэний хяналтанд бүртгүүлсэн тухай бичиг;

2 хувь цээж зураг;

Дэвтрийн үнэ болох 600 төгрөгийг Банкинд тушаасан баримт.

Хүүхдийн тэтгэлэг болон хүүхдийг асран хамгаалах үүргийн тухай заасан Гэр бүлийн тухай хуулиар нөхрөөсөө салсан эмэгтэйчүүд хүүхдийн тэтгэлэг авна. Салсан эхнэр, нөхөр хоёр гэр бүл байхдаа бий болгосон бүх хөрөнгийг тэнцүү хуваадаг. Гэсэн хэдий ч, гэр бүлийн бизнес ихэвчлэн нөхрийн нэр дээр бүртгэлтэй байдгаас болж эрхэлж байсан бизнесийг салсан нөхөр авч үлдэх нь элбэг тохиолддог.

5.1.2.4 Гэрлэлтээ бүртгүүлээгүй эхээс төрсөн хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд

Монгол Улсын хуулиар гэрлэлтээ бүртгүүлээгүй гэр бүлээс төрсөн хүүхэд нь гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлсэн гэр бүлээс төрсөн хүүхэдтэй адил тэгш эрхтэй. Ийм хүүхдийг хуулийн болон нийгмийн зүгээс ялгаварладаггүй.

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө ажилладаг байгууллагууд:

Хүүхдийн төлөө Үндэсний газар

Хаяг: Улаанбаатар хот 210648, Бага тойруу 44-А,

Факс +976 11 322048

Утас: +976-51 262109, 262914, 262814

И-мэйл: ncc@magicnet.mn, info@nac.gov.mn

www.nac.gov.mn

Эмэгтэйчүүдийн эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын жагсаалтыг <http://www.monfemnet.org/member.php> үзэж болно.

5.2 Эрэгтэйчүүд

5.2.1 Эрэгтэйчүүдэд тулгардаг эрсдэл (хэрэв байдаг бол)

Гадаадаас эх орондоо эргэн ирсэн эрэгтэйчүүдэд тулгарах тусгай эрсдэл байхгүй.

5.2.2 Цэргийн алба

Цэргийн албыг 1992 онд батлагдсан Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Цэргийн албаны журмаар зохицуулдаг¹⁰². Цэргийн алба хаах нь бие болон оюун ухааны хувьд эрүүл Монгол эрэгтэй хүн бүрийн иргэний үүрэг мөн. 18-27 насны эрэгтэй цэргийн албанд бүртгүүлэх, цэргийн алба хаах үүрэгтэй.

Монгол Улсын иргэн эрэгтэй хүний бас нэгэн цэргийн үүрэг бол 60 нас хүртэл цэргийн бэлтгэл хүч бүрдүүлэх явдал юм. Энэхүү үүрэг нь цэргийн алба хаасан бүх эрэгтэйчүүдэд хамааралтай. Цэргийн алба 12 сарын турш үргэлжилдэг.

5.2.2.1 Хуулийн зохицуулалт ба хэрэгжилт (тэр дундаа гадаадад амьдарч байсан Монголчуудын хувьд)

Гадаадын орнуудад амьдарч байгаад эргэж ирсэн эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн талаар тусгай зүйл хуулинд тусгагдаагүй¹⁰³. Гадаадаас эх орондоо эргэж ирсэн эрэгтэйчүүд өөрийн

¹⁰² www.legalinfo.mn, Батлан хамгаалах тухай Хууль

¹⁰³ <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=1397>

харьяалагдах аймаг буюу дүүргийн Цэргийн Хэлтэст ямар нэгэн торгуульгүйгээр бүртгүүлэх боломжтой.

5.2.2.2 Цэргийн албанаас татгалзах хууль ёсны боломж ба хэрэгжилт

Цэргийн алба хаахаас татгалзсан хүн 2 янзын дүйцүүлэх албанаас сонголт хийх эрхтэй ба үүнийг тухайн эрэгтэй өөрийн сонголтоороо шийднэ. Цэргийн албыг биеэр хаахаас татгалзсан хүн цэргийн албыг дүйцүүлэн хаах боломжтой. Өөр нэгэн боломж бол цэргийн албанд алба хааж байгаа нэг цэргийн 12 сарын хугацаанд гарах зардлыг төлөх юм. Энэ нь өнөөгийн байдлаар ойролцоогоор 1,450 америк доллартай тэнцэх хэмжээтэй байгаа ба үүнийг 5-7 жилийн дотор төлөх боломжтой.

Цэргийн албыг цэргийн ангид хаахаас татгалзвал дүйцүүлэн хаах албыг сонгож болно. Цэргийн албыг дүцүүлэн хаагчдад зориулсан ажлын байруудыг ажил олгогчидтой тохиролцож тогтоодог. Цэргийн албыг дүйцүүлэн хаах олон төрлийн ажил байдаг ба энэ нь улс орны эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалтай нягт уялдаатай байдаг. Жишээ нь:

Цаг агаарын хүндрэл, гамшиг;

Ойн түймэр унтраах;

Халдварт өвчний үед тусламж үзүүлэх.

Энэхүү хөтөлбөрийн үйлчилгээ нь ихэнхдээ 24 сарын хугацаатай буюу цэргийн алба хаахтай ойролцоо хугацаатай байна.

5.2.2.3 Цэргийн албан хаахаас татгалзагчид үзүүлэх дэмжлэг (ТББ-ууд, шашны байгууллагууд гэх мэт)

Энэ тал дээр тусгайлан ажилладаг байгууллага байдаггүй.

Цэргийн албаны цэрэг татлага нэг жилд 2 удаа зохион байгуулагддаг. Монгол Улсын аймгууд болон Улаанбаатар хотын Дүүрэг бүр цэргийн хэлтэстэй байдаг.

5.3 Хүүхэд

5.3.1 Хүүхдийн амьдралын ерөнхий төлөв байдал

Монгол Улсын хүн ам 2000 оны тооллогоор 2,373,500 байсан. Хүн амын жилийн дундаж өсөлт 1,4 хувь болсон нь 1950-иад оноос хойш бүртгэгдсэн хамгийн бага өсөлтийн үзүүлэлт юм. Хүн амын 46,6% нь 18 хүртэл насны хүүхэд, 12,1% нь 19-24 насны залуучууд байна.

Сүүлийн жилүүдэд хотжих үйл явц нэмэгдэж, нийт хүн амын 58,6% нь хот, суурин газар, үүнээс 32,5% нь нийслэлд амьдарч байна. Ийнхүү хотын хүн ам огцом нэмэгдэж байгаа нь нийслэл, төв,

суурин газар дахь сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн бусад үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улс хүүхдийн язгуур эрх ашгийг хангахтай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн тэдгээрийн үзэл санааг үндэсний хууль тогтоомжид тусгах чиглэлээр дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Монгол Улс 1998 онд Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцид нэгдэн орж, 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх асуудлыг тусгасан¹⁰⁴.

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай 182 дугаар конвенцид 2000 онд нэгдэж, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн 2 дахь үе шатны ажлыг хэрэгжүүлэх Ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна.

Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцохоос сэргийлэх тухай, Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай нэмэлт Протоколууд олон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцийг соёрхон баталсан байна.

Улсын Их хурлаас 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай бие даасан хуулийг баталж, одоогийн байдлаар салбарын 50 гаруй хуульд хүүхдийн эрхийн харилцааг зохицуулсан заалтууд орсон байна.

5.3.1.1 Хүүхдэд тулгарч буй эрсдэл, ерөнхий байдал

2000 оны хүн амын тооллогын дүнгээр 18 хүртэлх насны хүүхдийн 22 орчим хувь нь амьдралын хэвийн нөхцөл нь ямар нэг хэмжээгээр алдагдсан орчинд амьдарч байна.

Монголын өнөөгийн нийгэм-эдийн засгийн онцлог байдлаас шалтгаалан эмзэг бүлгийн хүүхдүүд олон янзын бэрхшээлтэй тулгарч байна. Эдгээр хүүхдүүдийг 3 бүлэгт хувааж болно. Үүнд: тусгай хэрэгцээтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, халамжийн төвд амьдардаг буюу гэр орноосоо тусгаарлагдсан хүүхдүүд, хөдөлмөр эрхэлдэг ба гудамжны хүүхдүүд.

¹⁰⁴ Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр, МУ ЗГ, 2002 он

Сүүлийн жилүүдэд орон нутгаас нийслэл рүү шилжин ирэгсдийн тоо хурдацатай нэмэгдэж байгаа нь сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээвэр, эрчим хүч зэрэг нийтийн үйлчилгээний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж байна.

Нийслэл хотод согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх, ядуурал болон ажилгүйдэл их байгаад хүүхэд хохирох тохиолдол олон байна. Олон хүүхэд гудамж болон асрамжийн төвд амьдарч байгаагаас гадна тэд хөдөлмөр эрхлэх, биеэ үнэлэхэд хүрч байна. Эцэг, эхийн үүргээ ухамсарладаггүй, хүүхдэд дарамт үзүүлдэг, хайхрамж орхидог зэргээс хүүхэд хараа хяналтгүй болж улмаар дулааны цооног, орц, хонгил олон нийтийн газруудад амьдрахад хүрч байна.¹⁰⁵

Хүүхдийн хүчирхийлэл ноцтой асуудлын нэг бөгөөд энэ нь ерөнхийдөө гэр бүл дэх хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр илэрдэг. Хүүхдийг бэлгийн үйл ажиллагаанд оруулах нь хууль бус ч хүүхдийг ашиг хонжоо олох зорилгоор бэлгийн мөлжлөгт оруулах асуудал өргөжсөөр байна. Зарим ТББ-ын мэдээлснээр өсвөр насны охидыг хулгайлан улмаар албадан эсвэл хууран мэхэлж биеийг нь үнэлүүлж байжээ. Бэлгийн харьцаанд орох доод нас 16 нас байдаг. Хуулийн дагуу хүчингийн хэрэг хийгсэд нь 3 хүртэлх жилийн хорих ялаар шийтгүүлнэ хэмээн заасан байдаг бол садар самууныг харуулсан бичлэгийг хийсэн, худалдсан аль эсвэл үзүүлсэн этгээдийг 3 хүртэлх сар хорих ялтай. Монгол Улс нь жуулчдыг хүүхдийн садар самуунд уриалан дуудсан улсын тоонд ордоггүй боловч олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар жуулчдын тоо нэмэгдсэн нь бэлгийн мөлжлөг байгаатай холбоотой гэжээ.¹⁰⁶

Монголд хүүхдийг нийгэм хамт олны дунд өсгөх олон жилийн уламжлалтай хэдий ч нийгэм болон ар гэрт гарсан өөрчлөлтүүдээс болж олон хүүхэд өнчирсөн. Хүүхдээ орхиж явах нь том асуудал болж зарим хүүхдүүд эцэг, эхээсээ өнчирж үлддэг ба ихэвчлэн архи хэрэглэдэг эцэг, эхчүүд үр хүүхдээ гэр бүлийн хүчирхийлэлд оруулсанаас тэдгээр хүүхдүүд гэр орноосоо зугатдаг байна.¹⁰⁷

5.3.1.2 Цэцэрлэг, сургуульд сурах боломж

Монгол Улс төрийн санхүүжилттэй сургуулийн өмнөх боловсролын системтэй. Өнөөдрийн байдлаар улсын болон хувийн 700 гаруй цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Цэцэрлэгүүд ихэвчлэн 3 нас хүрсэн хүүхдийг хүлээн авдаг. Сүүлийн үед Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа

¹⁰⁵ http://www.crin.org/docs/Shadow%20report_%20NGO%27s_Eng.pdf

¹⁰⁶ ЭКПАТ Монгол, 2007

¹⁰⁷ Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр, МУ ЗГ, 2002 он

явуулж байгаа хувийн сургууль, цэцэрлэгүүд орос болон бусад гадаад хэлний сургалттай болсон байна.¹⁰⁸

Монгол Улсын нийт хүн амын 17%-ийг сургуулийн өмнөх насны хүүхэд эзэлж байгаа боловч тухайн насны хүүхдийн 62,3%, ялангуяа амьжиргааны түвшин доогуур гэр бүл болон малчдын 3-7 настай хүүхдийн гуравны хоёр нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна. Хүүхдийн цэцэрлэгийн барилга, халаалтын байгууламжийн 74%-д засвар, үйлчилгээ хийгдээгүй, хуучирч муудсан, 77%-д нь туслах аж ахуй, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн дутагдалтай байгаагаас гадна сургуулийн өмнөх боловсрол олгох ажилд эцэг, эх, олон нийт бэлтгэгдээгүй байна.

Нийт хүн амын 21 хувийг ЕБС-ийн насны хүүхэд эзэлж байгаагаас ЕБС-ийн 78%, нийт сурагчдын 67% хөдөө амьдарч байна.¹⁰⁹

Хуучин социалист орнуудын нэгэн адилаар Монголын сургуулиуд 10 жилийн системтэй байсан нь 2008 оноос 11 жилийн сургалттай болсоноос гадна сургуульд элсэн орох насыг багасган 6 нас болгосон. Хичээлийн шинэ жил 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлдэг.

Сумын төвийн сургуулиуд нь алслагдсан нутагт амьдардаг хүүхдүүдэд зориулсан дотуур байртай. Эдгээр сургуулиудын ихэнх нь 8 жилийн системтэй ба бүрэн бус дунд боловсролыг бүрэн эзэмших хүсэлтэй сурагчид цаашид тухайн аймгийн төвд байрлах сургуулиудад сурдаг.

Улаанбаатар, Эрдэнэт зэрэг хотуудад хувийн сургуулиуд олонтаа байдаг ба тэдгээрийн сургалтын чанар нь харилцан адилгүй. Улаанбаатар хотод орос, хятад, англи, герман зэрэг хэлний гүнзгийрүүлсэн сургалттай дунд сургуулиуд бий болсон.¹¹⁰

Хүүхдийн халамжийн төвд амьдарч байгаад 18 нас хүрсэн хүүхэд цаашид өөрөө бие даан амьдарч эхлэх хэрэгтэй болдог ба нийгэмд тодорхой байр суурь эзлэх болдог. Төрийн боловсролын байгууллагын олгосон боловсролын чанар хангалтгүйгээс цаашид суралцахад томоохон бэрхшээл болдог.¹⁰

5.3.1.3 Хүүхэдтэй гэр бүлд төрөөс үзүүлэх дэмжлэг

Хүүхэдтэй гэр бүлд үзүүлэх дэмжлэг төрийн бодлогын хүрээнд явагддаг. Хүүхэд болон хүүхэдтэй гэр бүлд олгодог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжүүд:

¹⁰⁸ http://en.wikipedia.org/wiki/Education_in_Mongolia

¹⁰⁹ Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр, МУ ЗГ, 2002 он

¹¹⁰ http://en.wikipedia.org/wiki/Education_in_Mongolia

Хүүхэдтэй гэр бүлд төрөөс доорх дэмжлэг туслалцааг үзүүлж байна. Монгол Улсын Халамжийн тухай хуульд зааснаар:¹¹¹

4 дүгээр бүлгийн 17 дугаар зүйлд: “16 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх аль эсвэл 50 насанд хүрсэн эцэг халамжийн тэтгэвэр авах эрхтэй” гэж заасан ба энэ нь нэг сарын 53,800 төгрөг байна.

5 дугаар бүлгийн 19 дүгээр зүйлд: “Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж олгоно” хэмээн заасан ба энэ нь нэг сарын 26,000 төгрөг байна.

4 дүгээр бүлгийн 18 дугаар зүйлд: “Хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд халамжийн тэтгэвэр олгоно” хэмээн заасан ба үүнд 16 нас хүрээгүй тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд багтанх ба энэ нь нэг сарын 53,800 төгрөгийн тэтгэвэр юм.

5 дугаар бүлгийн 28 дугаар зүйлд 3 ба түүнээс дээш ихэр хүүхдийг 4 нас хүртэл нь төрийн зардлаар асрамжилна гэжээ.

Хэдийгээр ийм олон төрлийн тэтгэвэр тэмгэмжийг олгодог ч энэ нь гэр бүлийн амьдралын хэрэгцээг хангахад хүрэлцээгүй байна.

5.3.2 Гэр бүлээс тусгаарлагдсан хүүхэд (гэр бүлийг орлох үйлчилгээ)

Орон гэргүй, эцэг эхийн хараа хяналтнаас гарсан хүүхдийн тоо буурахгүй байна. Орон нутгаас Улаанбаатар хотод суурьшихаар ирэгсдийн шилжилт хөдөлгөөнөөс үүдэн хүүхдийн боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн үйлчилгээ улам ачаалалтай болж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь улс даяар үйлчилгээ хүргэх тогтолцоотой.

Дараах нөхцөл байдалд орсон хүүхдийг гэртээ авч асрамжилсан иргэн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг авдаг. Үүнд:

Бүтэн өнчин хүүхэд;

Эцэг эх нь хүүхдээ асрах эрх зүйн чадамжгүй болсон хүүхэд;

Эцэг эх нь 3 сараас дээш хугацаагаар эмнэлэгт байгаа хүүхэд;

¹¹¹ Нийгмийн халамжийн тухай хууль

Эцэг эх нь засан хүмүүжүүлэх газарт байгаа хүүхэд;

Хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд.

Энэхүү тэтгэмжийн хэмжээ, бүрдүүлэх бичиг баримтын талаарх мэдээллийг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны дараах веб хуудаснаас авч болно. www.mswl.gov.mn

Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан эсвэл асран хамгаалж буй иргэд хуулийн дагуу тэтгэмж авдаг. Энэхүү тэтгэмжийн хэмжээ, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаарх мэдээллийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны дээрх веб хуудаснаас үзнэ үү.

5.3.3 Өнчин хүүхдүүд

Эцэг, эхгүй өнчин хүүхдүүд насанд хүртэлээ төрийн хамгаалалтанд байдаг.

Үндэсний Статистикийн Газрын мэдээллээр бүтэн өнчин хүүхдийн тоо 2006 онд 5,276, 2007 онд 5,074, 2008 онд 5,018, 2009 онд 4,684 байсан байна.

Хүүхдийн төлөө ихэнх байгууллагууд, халамжийн төвүүд нь бүтэн болон хагас өнчин, эцэг эхийн хараа хяналтгүй, хаягдсан болон хүчирхийллийн золиос болсон хүүхдүүдийг орон байраар хангах, зөвлөгөө өгөх, сургалтанд хамруулах, эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрт хамруулдаг. Ихэнх халамжийн төвүүд нь эдгээр хүүхдүүдэд нийгмийн үйлчилгээ тэр дундаа Иргэний үнэмлэх, Төрсний Гэрчилгээ, Эрүүл мэндийн даатгалын дэвтэр шинээр авч өгөх зэрэг үйлчилгээг үзүүлдэг.¹¹²

5.3.3.1 Асрамжийн төвүүдэд тавих төрийн хариуцлага, хуулийн зохицуулалт

Өнчин хүүхдийн асрамжийн төвд тавих төрийн хариуцлагыг Нийгмийн Хамгааллын тухай хуулиар зохицуулдаг. Дэлгэрэнгүй мэдээлэл авах шаардлагатай бол www.legalinfo.mn вэб хаягаар орох ба Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуультай танилцана уу. Эцэг, эхгүй хүүхдийг эдгээр хуулийн дагуу хамгаалдаг ба насанд хүртэл нь төр тэднийг хариуцна.

¹¹² http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=1149&Itemid=274&tmp=1

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг Дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болно гэжээ. Мөн зүйлд бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдлэж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй эсвэл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг, сонирхлыг сум, дүүргийн Засаг Дарга хамгаална.

Улаанбаатар хотын хороо бүрт мөн 21 аймгийн сум болгонд нийгмийн ажилтан ажилладаг ба эдгээр мэргэжилтнүүд нь өнчин хүүхдийг зохих үйлчилгээ авахад нь дэмжлэг үзүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээ авахад туслах үүрэгтэй.

Засгийн Газрын харьяа асрамжийн төвүүдийн хаяг, утас:

3-7 насны хүүхдийн цэцэрлэг

8-18 насны хүүхдийн дотуур байр

Хаяг: Баянзүрх Дүүрэг, Улаанбаатар хот

Утас: +976 11 457673, 99182312 99186106

Нялхсын Клиник Сувилал

Дутуу төрсөн, эцэг эхдээ хаягдсан

0-4 насны хүүхдийг хүлээн авдаг.

Хаяг: Баянгол Дүүрэг, 19-р хороо, 4-р хороолол

Дамдинбазарын Гудамж, Өөрийн байр, Улаанбаатар хот

Утас: +976 11 360548, 360735, 360728, 362886

Хүүхэд Хамгаалал, Хаяг Тогтоох Төв

Уг төв нь 14 хүртэлх хоногийн хугацаагаар хаягдсан, төөрсөн, гэр оронгүй хүүхдийг байрлуулах үйлчилгээ үзүүлдэг.

Хаяг: Хан-Уул Дүүрэг, 11-р хороо, Өөрийн байр, Улаанбаатар хот

Утас: +976 99198228, 70124035, 88871550, 70122602

Хүүхдийн Сургалт, Хүмүүжлийн Тусгай Төв

Эцэг, эхийн хараа хяналтаас гарсан

хүүхдэд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг.

Хаяг: Баянзүрх Дүүрэг, 8-р хороо, Өөрийн байр, Улаанбаатар хот

Утас: +976 11 480121

5.3.3.2 Эх орондоо эргэн ирж буй хүүхдэд зориулсан өнчин хүүхдийн асрамжийн төв, түүнд хамрагдах боломж

Эх орондоо эргэж ирсэн хүүхдэд зориулсан тусгай төв Монгол Улсад байхгүй. Тоон мэдээллээс үзэхэд Монгол Улсын хэмжээнд гадаад, дотоодын байгууллагууд, хувь хүмүүсийн ажиллуулдаг 46 халамжийн төвүүдэд 1,500 орчим хүүхэд хүмүүждэг ба тэдгээр хүүхдүүдийн 20% нь бүтэн өнчин, 50% нь хагас өнчин, үлдсэн хүүхдүүд нь эцэг, эхтэй байдаг байна.¹¹³

Эдгээр төвийн ихэнх хүүхэд Улаанбаатар хотын Цагдаагийн хэлтсийн харьяа Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төвөөр дамжин ирдэг. Эцэг, эхийн хүсэлтээр аль эсвэл гудамжинд гарсан хүүхдүүдийг халамжийн төвийн ажилтнууд халамжийн төвд авч ирэх тохиолдол айдаг байна. Халамжийн төвүүдийн хоорондын хамтын ажиллагаа сул, зохицуулалт байхгүй байгаа нь тогтворгүй байдлыг үүсгэж, хүүхэд нэг төвөөс нөгөө төв рүү шилжих боломжийг олгодог. 1 жилийн дотор 10-20 халамжийн төв дамжсан ч хүүхдүүд байдаг байна.¹¹⁴

Хүүхдийг халамжийн төв рүү илгээсний дараа байршуулалтын судалгаа аль эсвэл удирдлагын үйлчилгээ хийдэггүй. Халамжийн төвд ирсэн хүүхдүүд бусад хүүхдэд дээрэлхүүлэх, ялгаварлан гадуурхагдах, багш болон асран хамгаалагч нартай харьцаа муутай байх аль эсвэл уйдах зэрэг олон янзын шалтгаанаас болж эргээд гудамжинд гарах нь олонтаа.¹¹⁵

5.4 Ахмад настан

¹¹³ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам

¹¹⁴ http://www.crin.org/docs/Shadow%20report_%20NGO%27s_Eng.pdf

¹¹⁵ www.mongolhuuhed.org

5.4.1 Тэтгэвэрийн системийн еөрнхий байдал; ахмад настнууд дундаж тэтгэвэрээр амьдрах боломжтой юу

Монгол Улсын тэтгэвэрийн тогтолцоо нь 1994 онд батлагдсан Нийгмийн Даатгалын хуулийн хүрээнд байгуулагдсан бөгөөд нийгмийн даатгалын томоохон 5 хөтөлбөрийн нэг юм. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам нь тэтгэвэрийн бодлогыг боловсруулж, Улсын Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар тэтгэвэрийн тогтолцоог хэрэгжүүлэх мөн даатгалын хураамжийг цуглуулан тэтгэмж төлөх үүрэгтэй. Тэтгэвэрийн Сан болон төрийн бусад сангууд нь сангийн үйл ажиллагаанаас хараат бөгөөд Сангийн Яам нь эдгээр санг зохицуулдаг. Төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тэр дундаа малчид нь тэтгэвэрийн өөр өөр төлөвлөгөөтэй байдаг ба нийлбэр дүнгийн хэмжээгээр зохицуулагддаг. Одоогийн байдалаар тэтгэвэрийн тогтолцоо нь төлсөн чинээгээрээ тэтгэвэр авах нөхцөлтэй. Жил бүрийн хураасан оролгыг тухайн жилийнхээ тэтгэмжийг санхүүжүүлэхэд ашигладаг.

Энэхүү тогтолцоо нь жилийн 37,7 сая америк долларын алдагдалтай байдаг ба ойрын ирээдүйд цуглуулсан тэтгэвэрийн хураамжаасаа илүүтэйгээр иргэдэд олгох тэтгэмж нэмэгдсэнээр алдагдал огцом өсөх тухай тооцоо гарсан байна¹¹⁶.

Нийгмийн даатгалын сан дор дурьдсан төрөлтэй:

- 1) тэтгэвэрийн даатгал;
- 2) тэтгэмжийн даатгал;
- 3) эрүүл мэндийн даатгал;
- 4) үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал;
- 5) ажилгүйдлийн даатгал.

Нийгмийн даатгал нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна¹¹⁷.

Даатгуулагчийн сар бүр төлөх нийгмийн даатгалын хураамж нь тухайн үед Засгийн Газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна:

1) тэтгэвэрийн даатгал	3.5%
2) тэтгэмжийн даатгал	1.0%

¹¹⁶ Asian Development Bank (ADB). 2006. Technical Assistance Report on Mongolia: Strengthening the Pension System (TA 4910-MON). Manila.

¹¹⁷ Law on Social Insurance http://www.ndaatgal.mn/eng_content.php?mid=3&file=eng_laws1

1999 онд баталсан Нийгмийн Даатгалын тухай хуулиар тэтгэвэрийн тооцооллыг гаргасан ба энэхүү тооцооллын дагуу 1960-аас хойш онд төрсөн хөдөлмөр эрхлэгч нарт төлсөн шимтгэлээс нь хамааран тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд тооцож оруулахаар болсон. Тухайн хүн тэтгэвэрт гарах насандаа нэрийн дансанд хуримтлагдсан дүнг амьдрах насных нь тоонд хуваасны дундаж тэтгэвэрийг авах юм. Гэсэн хэдий ч энэхүү тогтолцоог төлөвлөсөн ёсоор хэргжүүлж чадахгүй байгаа. Шинэ тогтолцооны дагуу хуримтлагдсан дүнг хуримтлуулалгүй харин тухайн жилийнхээ тэтгэмжийн төлбөрт зарцуулж байна.

Нийгмийн Даатгалын сангаас гаргасан Тэтгэвэр, Тэтгэмжийн тухай хуулиар тэтгэвэрийн доод хэмжээ нь тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75%-иас багагүй байна гэж заасан байдаг (2010 оны 12 дугаар сарын байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь нэг сарын 108,000 төгрөг байна). Энэхүү мөнгөн дүнгээс харахад амь зуух цорын ганц эх үүсвэр болсон тэтгэвэрээрээ Монголын өндөр настнууд амьдралаа залгах нь хэцүү.

Тэтгэвэр, тэтгэмжийн талаар шаардлагатай мэдээллийг доорх вэб хуудаснаас үзнэ үү:

<http://www.ndaatgal.mn/content.php?mid=1&file=address11>,

Нийгмийн даатгалын сан болон түүний зарлагын талаарх сүүлийн үеийн мэдээллийг дорх вэб хуудаснаас үзнэ үү:

http://www.ndaatgal.mn/files/NDS%20sar%20medee_8.pdf

Нийгмийн Халамжийн Даатгал

2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс Нийгмийн Даатгалын сангаас олгох бүх тэтгэвэрийн хэмжээ 30%-иар нэмэгдсэн. Өндөр насны тэтгэвэр 81,000-105,300 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэвэр 54,000-70,200 төгрөг байгаа ба өндөр настны дундаж тэтгэвэр 96,000-125,000 төгрөг байна. Тэтгэвэр авагсдын 60% нь тэтгэвэрийн аль эсвэл хувь тэнцүүлсэн тэтгэвэрийн хамгийн доод хэмжээгээр авдаг байна¹¹⁸.

Нийгмийн Даатгалын Сангаас тэтгэвэр авах эрхгүй хөдөлмөрийн чадвараа алдагсад, асрамжлан хамгаалагч аль эсвэл үр хүүхэдгүй өндөр настан болон тахир дутуу иргэд Нийгмийн Даатгалын сангаас тэтгэмж авдаг¹¹⁹.

Шилжилт болон байгалийн гамшгаас үүдэн хүмүүсийн амьдралын боломж муудаж байгаа ба ядууралд эмэгтэйчүүд, тахир дутуу иргэд болон өндөр настнууд илүүтэйгээр өртөж байна¹²⁰.

¹¹⁸ <http://www.news.gogo.mn/r/76204>

¹¹⁹ <http://legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=6216>

2010 оны 10-р сараас нийгмийн халамжийн тэтгэвэр 30%-иар нэмэгдсэний дараа Нийгмийн Даатгалын Сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхгүй хүмүүс (ганцаараа амьдардаг хөдөлмөрийн чадваргүй хүн, асрамжлан халамжлагч, үр хүүхэдгүй ахмад настнууд болон тахир дутуу иргэд) сар бүр 53,820 төгрөг авч байна. Гэсэн хэдий ч энэ мөнгөн дүн амь зуухад тун бага юм.

5.4.2 Тэтгэвэр болон бусад тэтгэмж авах шалгуур

Тэтгэвэрийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэвэр дор дурьдсан төрөлтэй байна:

- 1/ өндөр настны тэтгэвэр;
- 2/ тахир дутуугийн тэтгэвэр;
- 3/ тэжээгчээ алдсаны тэтгэвэр.

Тэтгэвэрийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж дор дурьдсан төрөлтэй байна:

- 1/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- 2/ жирэмсэний болон амаржсаны тэтгэмж;
- 3/ оршуулгын тэтгэмж.¹²¹

20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 нас хүрсэн эмэгтэй болон 60 нас хүрсэн эрэгтэй өндөр настны тэтгэвэр тогтоолгох эрхтэй. 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эмэгтэй 50 насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Зарим хууль, журам эмэгтэйчүүдэд ээлтэй биш байдгийн нэг жишээ нь 1991 онд батлагдсан Тэтгэвэрийн хуульд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэй 50 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй гэж заасан нь эмэгтэйчүүдийг эрт ажилгүй болгох аль эсвэл ажлаасаа гарахыг дэмжиж байгаа мэт нөхцлийг бүрдүүлж байна.

Өндөр настнуудад зориулсан тэтгэмж, үйлчилгээний тухай хуулиар өндөр настнууд орон сууцны тэтгэмж, мөнгөн тэтгэмж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг рашаан сувилалд эмчлүүлэх эрхийн бичиг, эх оронд үйлдвэрлэсэн сонсголын, харааны, хиймэл шүдний, гарны, хөлний протез хийлгэх зэрэг олон төрлийн тэтгэмж авах эрхтэй. Дээрх үйлчилгээний зардлыг Засгийн газраас гаргадаг.

¹²⁰Country report for Seminar on the Social, Health and Economic Consequences of Population Ageing in the Context of Changing Families http://www.unescap.org/esid/psis/meetings/Ageing_Change_Family/Mongolia.pd

¹²¹ http://www.ndaatgal.mn/eng_content.php?mid=3&file=eng_laws2

Жишээ нь нийгмийн халамжийн сангийн 15%-ийг өндөр настнуудад зориулсан ийм төрлийн тэтгэмж, үйлчилгээнд зарцуулсан байна¹²².

Өндөр настнуудад зориулсан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжүүд

2005 оны 9 дүгээр сард шинэчлэгдсэн Нийгмийн Халамжийн тухай хуулийн дагуу өндөр настнууд дор дурьдсан тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, үйлчилгээг авах эрхтэй юм:

- Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж;
- Нийгмийн хамгааллын тэтгэвэр;

Нөхцөлт мөнгөн тэтгэмж;

Тусламж, хөнгөлөлтүүд;

Төрөлжсан асрамжийн үйлчилгээ;

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ.

Нийгмийн Даатгалын сангаас тэтгэвэр авах нөхцөл нь бүрдээгүй хүмүүс Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах хүсэлтээ өгч болно.¹²³

Өндөр настнуудад олгох бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дорх вэб хуудаснаас авч болно.

http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=1202&Itemid=274&tmp=1

5.4.3 Тэтгэвэр, тэтгэмжийн байгууллагатай холбогдох хаяг

Нийгмийн Даатгалын Хэлтсийн хаягууд:124.

№	Агентлаг	И-Мэйл	Шуудангийн хаяг	Хаяг
1	Улсын Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар	undeg@ndaatgal.mn media_nd@ndaatgal.mn Fax: 976-11-320716	211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Бага тойруу 13/1	211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Бага

¹²²Country report for Seminar on the Social, Health and Economic Consequences of Population Ageing in the Context of Changing Families http://www.unescap.org/esid/psis/meetings/Ageing_Change_Family/Mongolia.pdf

¹²³http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=1195&Itemid=274&tmp=1

¹²⁴www.socialinsurance.mn

				тойруу 13/1
2	Нийгмийн Даатгалын Үндэсний Хороо	ndyz@ndaatgal.mn bataa@ndaatgal.mn	211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Бага тойруу 13/1	211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Бага тойруу 13/1
3	УНДЕГ-ын Гомдлын Зөвлөл	ndyz@ndaatgal.mn bataa@ndaatgal.mn	Чингэлтэй дүүрэг 4-р хороо бага тойруу 13/1 УНДЕГ Үндэсний Зөвлөл-д	Чингэлтэй дүүрэг 4-р хороо Бага тойруу 13/1 УНДЕГ-ын ГШТЗ 503 тоот ерөө

Өндөр настны тэтгэвэрийг Дүүргийн болон орон нутгийн Даатгалын Хэлтэс, Нийгмийн Халамжийн Хэлтэс олгодог.

Баянгол Дүүрэг	www.bgd.ub.gov.mn
Баянзүрх Дүүрэг	www.bzd.ub.gov.mn
Сүхбаатар Дүүрэг	www.sbd.ub.gov.mn
Чингэлтэй Дүүрэг	www.chd.ub.gov.mn
Хан-Уул Дүүрэг	www.hud.ub.gov.mn
Сонгинохайрхан Дүүрэг	www.shd.ub.gov.mn

Бүх аймгуудын Нийгмийн Даатгалын Хэлтсийн хаяг байршил, холбогдох утас, факсын дугаар, и-мэйл хаягийг доорх вэб хуудаснаас авах боломжтой.

<http://www.ndaatgal.mn/content.php?mid=6&file=address>

5.4.4 Өндөр настнуудад зориулсан байр сууцны болон халамжийн бололцоо

Өндөр настнуудын байр орон сууцны асуудал нь нийт хүн амын орон сууцны хангамжаас илүү чухал байдаг. Амьдралын боломж муутай өндөр настнууд тэр дундаа ахмад дайчдын орон сууцны асуудлыг Засгийн Газар нухацтайгаар авч хэлэлцэж байгаа ба тэдэнд зориулсан орон сууц барих барилгын ажил нь томоохон ажлын нэг юм. Түүнчлэн орон сууцны нөхцөл байдлыг сайжруулах, шинэ орон сууц барих зорилгоор хөнгөлттэй зээл олгох асуудлыг хуулинд тусгаж өгсөн. Гэсэн хэдий ч орон сууц худалдаж авах, орон сууцны зээл авах ажиллагаа хангалтгүй хэвээр байгаа¹²⁵.

¹²⁵Country report for Seminar on the Social, Health and Economic Consequences of Population Ageing in the Context of Changing Families http://www.unescap.org/esid/psis/meetings/Ageing_Change_Family/Mongolia.pdf

Монгол Улсад орон сууцны барилгын ажлыг барилгын хувийн компаниуд хийж гүйцэтгэдэг. Ерөнхийдөө өндөр настнуудад зориулсан орон байрны тусгай хөтөлбөр байдаггүй ч сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн Газар Халхын Голын дайнд оролцсон ахмад дайчид болон 1930-1940 онуудын хэлмэгдүүлэлтэд хэлмэгдсэн өндөр настнуудад зориулсан орон сууцаар хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Банкууд орон сууцны зээл олгож байгаа хэдий ч уг зээлийг авахын тулд барьцаа хөрөнгөтэй байх мөн зээлээ эргэн төлөх тогтмол орлоготой байх шаардлагатай учир өндөр настнууд орон сууцны зээл авах боломж хомс юм.

5.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Монгол Улсад 110,000 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт хүн амын 3,8%-тай тэнцэж байна.¹²⁶

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг олон хуулиар зохицуулдаг ч амьдрал дээр тахир дутуу иргэдэд хөдөлмөр эрхлэх, сургуульд сурах болон, амьдралд нь хүрэхүйц нийгмийн хамгааллын дэмжлэг авах боломж бага байна.

Монгол Улсын Халамжийн тухай хуульд¹²⁷ заасны дагуу Аймаг, Нийслэлийн Засаг дарга нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, халамжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

2010 онд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 43% нь Засгийн Газрын Нийгмийн Халамжийн Сангаас тэтгэмж авсан бол 47.9% нь Нийгмийн Даатгалын Сангаас тэтгэвэр, тэтгэмж авчээ.¹²⁸

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд ядуурлын үзүүлэлт нийт хүн амын ядуурлын үзүүлэлттэй харьцуулахад 52%-иар их байгаа нь тэд хүн амын хамгийн эмзэг бүлэг болохыг харуулж байна. Тахир дутуу иргэдэд Нийгмийн Халамжийн сангаас мөнгөн тэтгэмж, нэн ядуу өрхөд орон сууцны хөлс төлөх, нүүрс түлээ худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж олгодог ба эдгээр үйлчилгээг дүүргүүдээс авдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэвэр тэтгэмжийн талаарх мэдээллийг Улаанбаатар¹²⁹ хотод дүүргүүдийн харин аймгуудад нийгмийн халамж, нийгмийн даатгалын хэлтсийн дараах хаягаас авч болно.

Баянгол Дүүрэг	www.bgd.ub.gov.mn
Баянзүрх Дүүрэг	www.bzd.ub.gov.mn
Сүхбаатар Дүүрэг	www.sbd.ub.gov.mn
Чингэлтэй Дүүрэг	www.chd.ub.gov.mn

¹²⁶ Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам

¹²⁷ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль

¹²⁸ http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=1198&Itemid=274&tmp=1

¹²⁹ http://www.ulaanbaatar.mn/index.php?option=com_content&task=view&id=1183&Itemid=274&tmp=1

5.5.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан халамжийн байгууллага ба Төрийн үүрэг (хуулийн зохицуулалт ба хэрэглээ)

Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгмийн Халамжийн тухай хуулийн 5.1.2-т заасны дагуу 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутамд нэг удаа, мөн хуулийн 5.1.3-д зааснаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез сэргээн засалтын хөнгөлөлт авдаггүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 5 жил тутамд нэг удаа 100% нөхөн олгоно.

Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгмийн Халамжийн тухай хуулийн 5.1.9-д зааснаар: “Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн аймгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчилгээ, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгоно.

Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгодог.

Нийгмийн халамжийн тэтгэврийг:

Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн авах эрхтэй,

16 насанд хүрсэн одой иргэн мөн авах эрхтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байгууллага:

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх зориулалттай халамж, асрамжийн тусгайлсан төв байхгүй боловч цөөн тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон нутагт байралдаг холимог асрамжийн төвүүд мөн Төв аймгийн Батсүмбэр дахь ахмадын асрамжийн газарт хамруулан асрамжилдаг¹³⁰. Эдгээр төвүүд төрийн санхүүжилттэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

Үүнээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засалтын үндэсний төв Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг. Сэргээн засалт мэргэжлийн сургалтын Үндэсний төв хөгжлийн

¹³⁰ Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

бэрхшээлтэй иргэдийг нөхөн сэргээх эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулдгаас гадна тэдэнд зориулсан протез, ортопедын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэдэг. Энэ төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэд янз бүрийн мэргэжил эзэмшдэг. Үүнд :

Компьютерийн операторч, түргэн бичиг

Тогооч

Талх нарийн боовчин

Цэцэгчин-ногоочин

Гоо-засал, массаж

Оёдолчин

Мужаан

Гар урлалчин

Тус төв хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөрийн дадлага олгох, сэргээн засах, дасган сургах эмчилгээ үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн болон хууль эрх зүй, сэргээн засалтын зөвлөгөө өгөх үйлчилгээ явуулдагийн гадна, 9 дүүрэг, 18 аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тэгш дүүрэн хөтөлбөрийн орон нутгийн зөвлөлийн хаягийг дараах веб хуудаснаас авч болно.

Хаяг: <http://nrc.gov.mn/>

Хараагүйчүүдийн үйлдвэр олон жилийн түүхтэй бөгөөд энэ үйлдвэрт харааны бэрхшээлтэй хүмүүс үйлдвэрлэл явуулдаг. Үйлдвэр түүхий эд, зах зээл, төсөв нөөцийн бэрхшээлтэй байнга тулгардаг.

Дээрх байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг. Үүнээс гадна Төрийн бус байгууллага, Олон Улсын төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйл ажиллагаа мөн явагддаг.

5.5.2 Эх орондоо эргэн ирэгсэдэд зориулсан байгууллага үйлчилгээ, түүнд хамрагдах нь

Эх орондоо эргэн ирэгсэд бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ижил тэгшээр боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж авах эрх эдэлнэ.

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэд хэдэн сургууль байдаг ч хүүхдүүд жирийн сургуульд ч явах боломжтой. Хөдөө орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ийм тусгайлсан сургуульд хамрагдах боломж бага байдаг. Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбооны тооцоолсонор улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд тутмын 2 нь бүрэн дунд боловсрол эзэмшээгүй байна.

Асрамж халамжийн үйлчилгээ шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Нийслэлийн дүүрэг болон аймгийн Засаг Даргын захирамжинд үндэслэн Хөдөлмөр, Халамж, Үйлчилгээний газраас зохих асрамжийн газарт хуваарилах шийдвэр гаргадаг.

Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу 50 хүртэл ажилтантай үйлдвэр, аж ахуйн нэгжүүд 3 хүртэл хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулах үүрэгтэй байдаг.

5.5.3 Эргэн ирж буй оронд үйл ажиллагаа явуулдаг буяны болон халамжийн байгууллага

НҮБ, Дэлхийн зөн ОУБ, Италийн ЗГ-ын бус АЙФО байгууллага, АДРА, Мерси Кор, ХИС, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн эцэг эхийн холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо зэрэг олон улсын болон дотоодын ТББ-ууд тахир дутуу иргэдэд үйлчилгээ үзүүлэх төсөл хэрэгжүүлж ажилладаг. Эдгээр байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах, өдөр өнжүүлэх, боловсрол эзэмшүүлэх, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ үзүүлэх төвүүдийг ажиллуулдаг¹³¹.

5.6 Сэтгэцийн эмгэгтэй иргэд (бэртэл гэмтэл авсан иргэдийг оролцуулан)

Монгол Улсад сэтгэцийн эмгэгтэй 20,000 гаруй иргэн бий. Дээр дурдсанчлан оюун ухааны хоцрогдолтой хүүхдүүд тусгай сургуульд суралцаж хөнгөвчилсөн программаар хичээллэдэг. Цаашид тэдэнд зориулсан мэргэжлийн сургалтад хамрагдах боломж хомс, ажлын байраар хангагдах боломж бараг үгүй. Харин сүүлийн үед оюун ухааны хоцрогдолтой, сэтгэцийн хөнгөн эмгэгтэй хүүхдүүд энгийн сургуульд суралцах боломжтой болсон.

¹³¹ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

5.6.1 Мэргэжлийн байгууллага, төрийн үүрэг оролцоо (хуулийн зохицуулалт ба хэрэглээ)

Сэтгэцийн эмгэгтэй хүүхдэд зориулсан тусгай сургууль Улаанбаатар хотын 4 дүүрэгт бий. Эдгээр сургуульд хамруулах хүүхдийн талаарх шийдвэрийг тухайн дүүргийн боловсролын асуудал хариуцсан байгууллага гаргадаг.

Сэтгэцийн эмгэгтэй иргэдийг эмчлэх мэргэжлийн эмнэлэг Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний төв нь Улаанбаатар хотод байрладаг.

Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний төв нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг эрт оношилж, эмчлэх, нөхөн сэргээх, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүсийн асуудлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран шийдвэрлэх, үйлчилгээ хямд, тогтвортой, олон нийтийн санал хүсэлт дээр тулгуурлан явуулахад анхаардаг.

Хаяг: Баянзүрх дүүрэг 9 дүгээр хороо, Шархад
Утас/ Факс: 976-11-458298

(<http://www.metuf.mn>)

Сэтгэцийн эмгэгтэй иргэн болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан асрамжийн газар.

Төв аймгийн Батсүмбэр дэх асрамжийн газар нь сэтгэцийн эмгэгтэй иргэдэд зориулагдаагүй ч энд өндөр настан, өнчин хүүхэд хамт байрладаг.

5.6.2 Эх орондоо эргэн иргэсэд мэргэшсэн байгууллага ба үйлчилгээнд хамрагдах боломж

Асрах халамжлах хүнгүйн улмаас асрамжийн үйлчилгээ шаардлагатай оюун ухааны хомсдолтой иргэдийг нийслэлийн дүүрэг болон аймгийн Засаг Даргын захирамжинд үндэслэн Хөдөлмөр, Халамж, Үйлчилгээний Газраас зохих асрамжийн газарт асрамжлах шийдвэр гаргадаг. Эх орондоо эргэн ирэгсэдүүний адил эрх эдэлнэ.

5.6.3 Эргэн ирэгсэдийн эх оронд үйл ажиллагаа явуулдаг буяны байгууллага

Тахир дутуу иргэдийн эрх, боловсрол, нийгмийн халамжийн чиглэлээр буяны үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын байгууллагууд олон байна. Үүнээс заримыг дурдвал:

Каритас Бүгд Найрамдах Чех Улс нь Диосесан Каритас Литомерис (Diocesan Caritas Litomerice) байгууллагатай хамтран Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шинэ төслийг Улаанбаатар хотод эхлүүлж байна.¹³²

Мерси Кор байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн Конвенцид заасан тэднийг нийгэм, эдийн засгийн амьдралд тэгш оролцуулах боломж олгох төслийг хэрэгжүүлсэн.¹³³

Чарити Ралли (Charity Rally) байгууллага Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сэргээн засалт, боловсролын төвийг байгуулсан.¹³⁴

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө ажилладаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санаачлан байгуулсан үндэсний ТББ-ын талаарх мэдээллийг <http://www.yellowpages.mn/ngo/?catid=104> вэб хуудаснаас үзнэ үү.

5.7 Цөөнх

5.7.1. Хүйсийн цөөнх

Хүйсийн цөөнх гэдэг ойлголт Монгол Улсад шинэ юм. Ижил хүйстэн, лесби, бисексуалуудад нийгэм шүүмжлэлтэй ханддаг. Гэсэн хэдий ч залуучууд үүнд арай уян ханддаг. ТББ-ууд болон Засгийн Газартай хамтран ДОХ-ын эсрэг ажилладаг ижил хүйстнүүдийн хөдөлгөөн, бүлэглэлүүд байдаг.

5.7.2. Угсаатны цөөнх

Монголын цөөнх болох казахууд нутгийн баруун хэсэгт орших Баян-Өлгий аймагт суурьшдаг. Ихэнх казахууд лалын шашинтай ба өөрийн хэлээр ярьдаг. Казахууд бол угсаатны цөөнхийн хамгийн том нь буюу Монголын нийт хүн амын 4 орчим хувийг, Баян-Өлгий аймгийн нийт хүн амын 85 орчим хувийг бүрдүүлдэг.

¹³² <http://www.charita.cz/article.asp?nArticleID=986&nLanguageID=1>

¹³³ <http://www.mercycorps.org.mn/index.php?cid=163>

¹³⁴ <http://mongolia.charityrallies.org/charityprojects/disabled-children-centre>

Үндсэн Хуулийн 8-р зүйлд “Хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө” гэж заасан нь бодит байдал дээр казахуудаас бусад цөөнх энэхүү эрхээ эдлэж чадахгүй байна. Энэхүү заалт нь Монголын нийт хүн амын 2%-ийг эзэлдэг Хятадууд, мөн 2%-ийг эзэлдэг Оросууд зэрэг томоохон цөөнхийг ялгаварлан үзэж байгаа мэт санагдаж болох юм.¹³⁵

5.7.3. Шашин шүтлэгийн цөөнх

Монгол Улсын Үндсэн Хууль нь шашин шүтлэгийн эрх чөлөөг олгодог ба Засгийн Газар ерөнхийдөө энэхүү эрх чөлөөг хүндэтгэн үздэг. Дэлхийн Фактбук ном болон АНУ-ын Төрийн Департаментын дурдсанчлан Монголын нийт хүн амын 50% нь Төвдийн буддын шашин, 40 хувь нь шашин шүтдэггүй, 6 хувь нь бөө, бахай болон загалмайтны шашин, үлдсэн 4 хувь нь лалын шашин шүтдэг хэмээн дурьджээ.¹³⁶

¹³⁵ <http://www.unhcr.org/refworld/publisher,MRGI,,MNG,48abdd79c,0.html>

¹³⁶ <http://en.wikipedia.org/wiki/Mongolia#Religion>